- Шалгалтын сорил алдаагүй, үнэн зөв байх, шалгалтын төгсгөлд алдсан сорилоо эргэн харах боломжтой байх;
- Албан хаагчдын угтах, мэндлэх, найрсаг, хүндэтгэлтэй харилцах, үйлчлэх соёлд сургах зэрэг хүсэлтүүд ирсэн байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй болон цахим хуудсаар зочилж буй хэрэглэгч, үйлчлүүлэгчдээс авсан асуумж судалгааны асуулт тус бүрд тохирох хариултуудад 0-5 оноо өгч кодлон үр дүнгийн боловсруулалт хийсэн. Судалгаагаар хэрэглэгчийн үнэлгээ 71 хувьтай байлаа.

## СУДАЛГААНЫ НЭР

# МОНГОЛ УЛСАД ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА

## СУДАЛГААНЫ БАГ

### Судалгааны зөвлөх:

**О. ЧИМЭДСҮРЭН** (ЭМХТ, ЭМЭЗБСА-ны зөвлөх,  
профессор, АУ-ны доктор)

### Судлаачид:

**Г.ТУНГАЛАГТАМИР** (Эрүүл мэндийн эдийн засаг,  
бодлогын судалгааны албаны  
мэргэжилтэн)

**Г. ЛУВСАНЦЭРЭН** (Эрүүл мэндийн эдийн засаг,  
бодлогын судалгааны албаны  
мэргэжилтэн)

**Б.СОЛОНГО** (Эрүүл мэндийн эдийн засаг,  
бодлогын судалгааны албаны  
мэргэжилтэн)

## **СУДАЛГАА ЯВУУЛСАН ХУГАЦАА**

2022 оны 4 сарын 11-нөөс 2022 оны 06 сарын 01

## **ХАМТРАН АЖИЛЛАСАН**

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ БА ХЭРЭГЦЭЭ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ЗАГВАР

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН АРГУУД

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ОУ	Олон улс
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
ЭМТ	Эрүүл мэндийн тайлан
ЭЦНБМЗТ	Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг
ЦХМЗТ	Цээжний хөндийн мэс заслын тасаг
ЕМЗТ	Ерөнхий мэс заслын тасаг
НСМЗТ	Нөхөн сэргээх мнс заслын тасаг
ЭМЗТ	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг
ЯТТ	Яаралтай тусламжийн тасаг
ДОТ	Дүрс оношлогооны тасаг

## ГАДААД НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

CEA	Зардал, үр ашгийн шинжилгээ
MWA	Бичил долгионоор түлэх
RFA	Радио долгионоор түлэх
TACE	Хавдрын тэжээгч судас бөглөх
PEIT	Этанолоор тарилга хийж аргаах
PVE	Элэгний үүдэн венийг бөглөх
LTS	Элэг шилжүүлэн суулгах мэс засал
ICG	Индоцианин ногоон
ICG test	Индоцианин ногоон бодис ашиглан элэгний үйл ажиллагаа үнэлэх тест
IGFI	Индоцианин ногоон флюоресценст
CT	Компьютер томографи
MRI	Соронзон резонанст томографи
AFP	Альфа-фетопротеин

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ
- Хүснэгт 2. Технологийн үнэлгээнд шаардлагатай мэдээлэл
- Хүснэгт 3. Эдийн засгийн үнэлгээний үзүүлэлт
- Хүснэгт 4. Зардал бүртгэх хуудас
- Хүснэгт 5. Эмч нартай хийх ярилцлагын асуулт
- Хүснэгт 6. Үйлчлүүлэгчтэй хийх ярилцлагын асуулт
- Хүснэгт 7. ХСҮТ-ийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
- Хүснэгт 8. ХСҮТ-ийн шинээр нэвтрүүлсэн технологийг бүртгэсэн байдал
- Хүснэгт 9. ХСҮТ-ийн 2018-2021 онд шинээр нэвтрүүлсэн технологийн бүртгэл
- Хүснэгт 10. 2018-2021 онд шинээр нэвтрүүлсэн мэс засал эмчилгээний технологи
- Хүснэгт 11. Бичил долгионоор түлэх шинэ технологи
- Хүснэгт 12. RFA, MWA түлэх эмчилгээний онцлог ялгаа
- Хүснэгт 13. ИЦН флюоресценст дүрслэлийн шинэ арга технологи
- Хүснэгт 14. Элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний шинэ арга технологи
- Хүснэгт 15. Элэгний хорт хавдрын эмчилгээний төрөл
- Хүснэгт 16. Элэгний хавдрын эмчилгээний үр дүн тооцох
- Хүснэгт 17. MWA, RFA эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн өвчний төгсгөл болон зарим үзүүлэлт
- Хүснэгт 18. Нас барсан үйлчлүүлэгчдийн дундаж амьдарсан хугацаа
- Хүснэгт 19. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн амьдрах чадамж
- Хүснэгт 20. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн хавдрын үе шат
- Хүснэгт 21. Элэг тайрах мэс заслын дараах зарим үзүүлэлт.
- Хүснэгт 22. Элэг тайрах эмчилгээний амьдрах чадамжийг зарим үзүүлэлтээр
- Хүснэгт 23. Шинэ технологи нэвтрүүлэлтийн зардал
- Хүснэгт 24. MWA мэс засал эмчилгээний зардал
- Хүснэгт 25. MWA болон элэг тайрах эмчилгээний дундаж ор хоног, ор хоногийн төлбөр
- Хүснэгт 26. Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагын үр дүн



## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

- Зураг 1. Судалгааны загвар
- Зураг 2. Үйл ажиллагааны хэрэгжилт
- Зураг 3. Дархлаа дарангуйлах эм хэрэглэж буй хүний тоо. 2021 он
- Зураг 4. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жагсаалт
- Зураг 5. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн өвчний төгсгөл
- Зураг 6. MWA болон элэг тайрах мэс заслын дараах өвчний төгсгөл.
- Зураг 7. MWA болон элэг тайрах мэс заслын дараах хүндрэл

## **НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО**

### **1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ**

Аливаа улс орны эрүүл мэндийн бодлого нь эрүүл мэндийг хамгаалах, дэмжих гэсэн үндсэн чиг хандлагад суурилдаг ба үүнтэй уялдан эрүүл мэндийн технологи хөгжиж ирсэн түүхтэй. Эрүүл мэндийн технологийн бодлого нь эмнэлгийн шатлал ба тусламж үйлчилгээний онцлогт тохирсон, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашигтай, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлдэг. Технологийн үнэлгээ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологийг богино ба урт хугацаанд хэрэглэснээр нийгэмд гарч ирэх үр дагавар, эдийн засгийн ач холбогдлыг шалгах бодлогын судалгааны цогц хэлбэр юм.

Хорт хавдрын бүртгэл тандалтыг Хавдар судлалын үндэсний төвийн Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн алба нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж хорт хавдрын өвчлөл, нас баралтын жилийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээллэн Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Хорт хавдрын өвчлөл, нас баралтын үндэсний хэмжээний мэдээний сан” үүсгэн ажилладаг.

Монгол улс дэлхийд хорт хавдрын шалтгаант нас баралтаар нэгдүгээрт, элэгний хорт хавдрын өвчлөл болон нас баралтаар тэргүүлж байна. Манай улсад хавдраар оношлогдсон 23,278 хүн амьдарч байгаа ба 1997 онд улсын хэмжээнд 1012 хүн хорт хавдраар шинээр оношлогдож байсан бол хорт хавдрын шалтгаант нас баралт 762 байсан бол 2020 оны тайлангаар улсын хэмжээнд 6702 хүн шинээр хорт хавдраар өвчилж бүртгэгдэн өвчлөл бодит тоогоор 6 дахин, 4260 хүн хорт хавдрын улмаас нас барж нас баралт бодит тоогоор 5,6 дахин нэмэгдсэн.

Өвчлөлийн тоо нэмэгдэхийн хэрээр тэдэнд ээлтэй тусламж үйлчилгээ, чанартай, хүртээмжтэй оношилгоо, эмчилгээний олон шинэ арга, технологи нэвтэрч байгаа ба тус технологийг нэвтрүүлэх, ашиглах, үнэлэх, шинэчлэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрт нотолгоонд тулгуурлан үр дүнгийн шинжилгээ хийх, өртгийг судлах, цаашлаад өвчтөн болон түүний ар гэр, эрүүл мэндийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах судалгаа хомс байна. Мөн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд чиг үүргийн хүрээнд эмчилгээ, оношилгоонд шинэ технологи нэвтрүүлэн байгууллагын тайланд тусгадаг хэдий ч улсын хэмжээнд нэвтрүүлсэн шинэ технологийг бүртгэх, мэдээлэх, үр дүнг тооцох нэгдмэл удирдамж, тогтолцоо, мэдээлэл, нотолгоо бүрэн бүрдээгүйгээс бид энэ судалгааг ХСҮТ-ийн жишээн дээр авч шийдвэр гаргалтанд нөлөөлөх зорилгоор тус судалгааг хийж гүйцэтгэв.

Шинээр нэвтрүүлсэн технологийг бүртгэх, мэдээлэх, үнэлгээ хийх нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, оношилгоо, эмчилгээний үр дүнг үнэлэх, нутагшуулах, олон улсад нэвтэрсэн шинэ аргыг судлах, нэвтрүүлэх шийдвэр гаргах, нөөцийг төлөвлөх зэрэг чухал ач холбогдолтой юм.

### **1.2 ЗОРИЛГО**

Хавдрын мэс заслын оношилгоо, эмчилгээнд нэвтэрсэн шинэ технологиудыг бүртгэх, зардал болон үр ашгийн шинжилгээ хийх

### 1.3 ЗОРИЛТ

1. Хавдрын оношилгоо, эмчилгээнд нэвтэрсэн шинэ технологиудыг бүртгэл мэдээллийн өнөөгийн байдлыг судлах
2. Элэгний хавдрын эмчилгээнд нэвтэрсэн “Бичил долгионоор түлэх эмчилгээ (MWA)” шинэ технологийн зардал, үр ашгийг судлах


### 1.4 СУДАЛГААНЫ ГОЛ АСУУЛТ

1. Элэгний хавдрын оношилгоо, эмчилгээнд шинээр ямар арга технологи нэвтрүүлсэн бэ? Түүний бүртгэл, мэдээлэл хэр оновчтой байна вэ?
2. Элэгний хавдрын оношилгоо, эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн технологи нь эдийн засагт зардал болоод үр ашгийн хувьд хэр ач холбогдолтой вэ?

### ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ЗАГВАР

Судалгаанд эмнэлэгт суурилсан агшингийн судалгааны загварыг ашиглан хавдар судлалын салбарт шинээр нэвтэрсэн эмчилгээ, оношилгооны технологийн бүртгэл, түүний үнэлгээний өнөөгийн байдлыг судалсан.

#### 2.1 СУДАЛГААНЫ ЗАГВАР



Зураг 1. Судалгааны загвар

#### 2.2 ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд ХСҮТ-ийн Элэг, цэс, нойр булчирхайн болон Ангиографийн тасгийг сонгон сүүлийн 5 жилд нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний шинэ технологийг судалсан бөгөөд хамруулсан тасаг, уг тасгаас сонгосон зорилтот бүлгийг доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ

Байгууллага	Алба, тасаг	Хамрагдах нэгж
-------------	-------------	----------------

<b>ХСҮТ</b>	Элэг, цөс, нойр булчирхайн тасаг	Эмч, сувилагч, техникч, үйлчлүүлэгч
	Ангиографийн тасаг	Эмч, сувилагч, техникч, үйлчлүүлэгч
	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба	Чанарын менежер
	Санхүү бүртгэлийн алба	Даатгалын эмч
	Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн алба	Албаны дарга, статистикч
	Элэг шилжүүлэн суулгах тасаг	Тасгийн эмч, сувилагч

### 2.3 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН АРГА

Уг судалгааг ХСҮТ-ийн статистик мэдээ, мөн бүртгэх хуудас боловсруулан технологийн үнэлгээнд шаардлагатай баримтыг холбогдох нэгжүүдээс цуглуулсан.

#### А. Технологийн үнэлгээнд шаардагдах мэдээлэл

##### *Хүснэгт 2. Технологийн үнэлгээнд шаардлагатай мэдээлэл*

Мэдээлэл	Үзүүлэлт
1. Шинээр нэвтрүүлсэн технологийн бүртгэлийн хуудас	Технологийн нэр, ОУ-д нэвтэрсэн он, Тонголд нэвтэрсэн он, зориулалт, хэрэглээ, онцлог, давуу болон сул тал, эсрэг заалт, өртөг, хийгдсэн хүний тоо, үр дүн.
2. Эмч нартай хийх ярилцлага	13 асуулт бүхий ярилцлагын асуултаар дэлгэрүүлж асуусан.
3. Технологийн зардал	Хүний нөөц бэлтгэх /мэргэшсэн мэргэжилтэн цалинжуулж ажиллуулсан, дотоодын эмч, мэргэжилтэнг сургалтад хамруулсан г.м/, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, эмийн бүтээгдэхүүн, тусгай орчны засвар үйлчилгээ, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлт, Нэг үйлчлүүлэгчид гаргаж буй зардал /эмнэлгээс/, ЭМД-аас гарах зардал, Мэс засал эмчилгээний зардал /нэг хүнд/, үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэх нэг өдрийн зардал, эмнэлгийн ор хоног /хэвтсэн хоног/
4. Үр дүнг хянах	Тус технологийн мэс засал эмчилгээ хийгдсэн хүний тоо, эдгэсэн хүний тоо, дахилт өгсөн хүний тоо, эргэн дуудах тогтолцоогоор хяналтад орсон хүний тоо, нас баралт зэрэг мэдээлэл
5. Үйлчлүүлэгч/ ар гэртэй уулзах	Үйлчлүүлэгчийн ерөнхий мэдээлэл, тус эмчилгээний зардал, эдгэрсэн эсэх, нас барсан эсэх, хяналтад байгаа эсэх, хаана хяналтад орсон болон эмчилгээний сэтгэгдэл.

## **Б. Эдийн засгийн үнэлгээнд шаардагдах мэдээлэл**

### *Хүснэгт 3. Эдийн засгийн үнэлгээний үзүүлэлт*

Үр ашиг	
Үзүүлэлт	Эдгэрэлт
	Элэгний эсийн дахилт
	Бусад эрхтнээс дахилт өгсөн эсэх
	Хяналт /эргэн дуудах тогтолцоо/ Амьдрах хугацаа уртассан байдал, амьдрах чадварын хувь
	Дундаж ор хоног
Зардал	
Үзүүлэлт	Мэс засал эмчилгээний зардал
	Эмнэлгийн ор хоногийн зардал
	ЭМД-аас гарах зардал
	Тус технологийг нэвтрүүлэхэд гарсан зардал
	Хүний нөөцийг бэлдэхэд гарсан зардал
	Тоног төхөөрөмжийн зардал

## **В. Баримтын судалгаанд ашигласан материал**

- Шинээр бүртгэгдсэн хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 маягтын тайлан
- Шинээр нэвтрүүлсэн технологийн тайлан
- Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ /АМ7/, тайлан
- Өвчний түүх
- ХСҮТ-ийн сар, улирал, жилийн эцсийн тайлангууд
- Хорт хавдрын хяналтын баазыг судалгааны материал болгон ашигласан.

## **Г. Судалгааны мэдээллийг тоон болон чанарын аргаар цуглуулав.**

Тоон аргаар:

- Зардлыг бүртгэх 10 үзүүлэлт бүхий бүртгэлийн хуудас

### *Хүснэгт 4. Зардал бүртгэх хуудас*

Үзүүлэлт	Хүний нөөцийг бэлтгэхэд гарсан зардал
	Тоног төхөөрөмжийн зардал
	Багаж хэрэгсэл
	Эм, эмийн бүтээгдэхүүн
	Тусгай орчны засвар үйлчилгээ
	Хувийн хамгаалах хэрэгсэл
	Ариутгал халдваргүйжүүлэлт
	ЭМД-аас гарах зардал
	Мэс засал эмчилгээний зардал
	Ор хоногийн зардал

Чанарын аргаар:

- ХСҮТ-ийн Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг, Элэг шилжүүлэн суулгах мэс заслын тасаг, Ангиографийн тасагт шинэ технологийг нэвтрүүлэн ашиглаж буй эмч, сувилагч, техникчтэй хийсэн 14 асуулт бүхий ганцаарчилсан ярилцлага хийсэн. Ярилцлагыг чиглүүлэгч, ярилцагч гэсэн 2 бүрэлдэхүүнтэй явуулж дунджаар 150 минут үргэлжилсэн.

*Хүснэгт 5. Эмч нартай хийх ярилцлагын асуулт*

№	Асуулт
1.	Та тус технологийн мэдээллийг хаанаас авсан бэ? /ямар улсаас, одоо ашиглагдаж байгаа юу? /
2.	Шинэ технологийн удирдамж, стандарт батлагдсан уу?
3.	Тухайн технологийг ямар өртгөөр оруулж ирсэн бэ?
4.	Зардлын эх үүсвэр? / Улсаас, эмнэлгээс, гадаад, дотоодын санхүүжилт, хандив, тусламжаар /
5.	Энэ технологи бусад улсад ашиглагдаж байгаа юу? Таны бодлоор энэ технологи хуучирсан уу? Илүү шинэлэг технологийн талаар та судалж мэдсэн үү?
6.	Олон улсад нэвтэрч хэрэглэгдэж буй шинэ технологийг манай улсад нутагшуулахад юу тулгамдаж байна вэ?
7.	Таны ажиллаж буй чиглэлд цаашид нэвтрүүлэх шаардлагатай ямар технологи байна вэ?
8.	Энэ технологийг ашиглаж үйлчилгээ үзүүлэх нь хэр хүндрэлтэй, ажиллагаа ихтэй байна вэ? Илүү хялбар үр дүнтэй технологи танай байгууллагад байдаг уу?
9.	Тухайн технологи нэвтэрснээр зардлыг хэмнэж чадсан уу?
10.	Тухайн технологийг ашиглахад хичнээн эмч, эмнэлгийн ажилчид шаардлагатай байдаг вэ? Ажиллах хүний нөөц хангалттай байж чаддаг уу?
11.	Үйлдлийн технологийг стандартын дагуу гүйцэтгэх явцад танд тулгамдсан асуудлууд гардаг уу? Гардаг бол ямар асуудлууд гардаг вэ?
12.	Таны ажлыг хөнгөвчилж чаддаг уу?
13.	Тухайн технологиор тусламж үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчдийг эргэн хянах тогтолцоо бий юу? /Бүртгэл тайлан мэдээ байдаг уу?/
14.	Шинэ технологийн үр дүнг юугаар хэмждэг вэ? /амьдралын чанар болоод амьдрах хугацаа хэрхэн өөрчлөгдсөн/

- Үйлчлүүлэгч эсвэл түүний ар гэрийн төлөөлөлтэй, тухайн шинэ технологийн зардал, үр дүнгийн талаар 10 асуулт бүхий ганцаарчилсан ярилцлага хийж, мөн утсаар мэдээлэл цуглуулсан.

№	Асуулт
1.	Овог, нэр
2.	Харьяа дүүрэг/аймаг
3.	ХСҮТ-д эмчилгээ хийлгэсэн огноо
4.	Хавдрын үе шат
5.	Эмнэлэгт хоносон хоног
6.	Эмчилгээнд гарсан зардал
7.	ЭМД-аас төлсөн төлбөр
8.	Хяналтад байгаа эсэх/хаана хяналтад байгаа/
9.	Бүрэн эдгэрсэн эсэх
10.	Тухайн эмчилгээний сэтгэгдэл

## 2.4 СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ АРГА

Цуглуулсан мэдээлэлд дескриптив шинжилгээ хийж тоон үр дүнг хүснэгт, графикаар илэрхийлж харин ярилцлагын мэдээг агуулгаар бүлэглэн үр дүнг шигтгээ байдлаар оруулсан.

CEA (Cost Effectiveness Analysis) аргаар зардал, үр ашгийн дүн шинжилгээ хийсэн (*CEA арга нь шинээр нэвтрүүлсэн технологийг аль хэдийн нэвтэрсэн суурь технологитой зардал, үр дүнг харьцуулан эдийн засгийн үнэлгээ хийх арга юм*). Үр дүнгийн үзүүлэлтийг тухайн технологийг ашигласан байдал, эмчилгээний үр дүн зэргийг, зардлыг тухайн технологийг нэвтрүүлэхэд гарсан зардал болоод үйлчлүүлэгчээс гарах зардал зэргийг харьцуулж дескриптив шинжилгээ хийсэн.

R studio програм ашиглан үйлчлүүлэгчдийн амьдрах чадамж, амьдарсан хугацааг тооцоолон судалсан. Статистик үнэн магадлалын ялгааг  $p < 0.05$  гэж тооцсон. Судалгааны үр дүнг хүснэгт, график, схемээр харуулан тайланд тусгав.

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 3.1 ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ШИНЭ ТЕХНОЛОГИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хорт хавдрын өвчлөлийн дэлхийн дундаж 100 000 хүн амд 9,3 байгаа бол Монгол улсад энэ үзүүлэлт 93,7 буюу түүнээс 10 дахин их байна. Мөн элэгний шалтгаант нас баралт дэлхийд 100 000 хүн амд дунджаар 8,5 бол манай улс 75,4 байгаа нь дэлхийд хамгийн өндөр үзүүлэлт юм. Монгол улсад 2014-2018 онд хорт хавдрын нийт 29397 тохиолдол бүртгэгдсэнээс хамгийн их буюу 40 хувийг элэгний хорт хавдар эзэлж байсан байна. Судалгааны энэ бүлэгт эмчилгээ, оношлогоонд нэвтрүүлсэн шинэ технологийн бүртгэл, мэдээлэл, тайлагналтын өнөөгийн байдлыг тоймлон оруулав.

Эрүүл мэндийн технологийн үнэлгээг дараах чиглэлээр хийн судалдаг. Үүнд:

- Эрүүл мэндийн технологийн чиг хандлагын үнэлгээ
- Эрүүл мэндийн технологийн хэрэгцээний үнэлгээ
- Шинээр нэвтрүүлж буй технологийн явцын үнэлгээ
- Эрүүл мэндийн үзүүлэлтэд гөлөөлөх байдлын үнэлгээ
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн үр нөлөөний үнэлгээ
- Технологийн сөрөг нөлөөний үнэлгээ
- Эрүүл мэндийн үр ашиг болон эдийн засгийн үнэлгээ
- Тоног төхөөрөмжийн технологийн үнэлгээ

Шинээр нэвтрүүлсэн технологийн үнэлгээний ач холбогдол нь шийдвэр гаргахад шаардлагатай орцыг бий болгох, нөөцийг үр ашиггүй зарахаас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шийдвэр гаргагчдад богино хугацаанд шаардлагатай мэдээллийг өгөх явдал юм.

#### **А. ЭМХТ-ийн шинэ технологийн бүртгэл, мэдээлэл, тайлагналтын өнөөгийн байдал.**

Харин ЭМХТ-д шинэ технологийн бүртгэл, мэдээллийг ЭМС-ын 2019 оны А/566 тоот тушаалын 7 зорилтын хүрээнд “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН”-д тусган Магадлан итгэмжлэлийн албанд магадлан итгэмжлэгдсэн хугацаандаа жил бүр илгээн тайлагнадаг. Мөн ЭМЭЗБСА-наас “Эрүүл мэндийн технологийн үнэлгээ, судалгаа” хийгдэн тайлагнадаг.


“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН” нь дараах 7 зорилтын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж ажилладаг.

1. Зорилт 1: Чанар аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжих сайжруулах
2. Зорилт 2: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх
3. Зорилт 3: Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
4. Зорилт 4: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх
5. Зорилт 5: Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх
6. Зорилт 6: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах
7. Зорилт 7: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах гэсэн долоон зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах



Тус тайлангийн зорилт 2-ын хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд шинээр нэвтрүүлсэн технологийн хөтлөлт мэдээллийг ЭМХТ-д хүргүүлэн үнэлгээ, дүгнэлт хийгдэн ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт тайлагнадаг.

2021 онд Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүдийн эмчилгээ, оношилгоо, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ орчин үеийн багаж тоног төхөөрөмж, шинэ технологи нэвтрүүлэн ажилласан эрүүл мэндийн байгууллагуудын хэрэгжилтийн үнэлгээ.



Зураг 2. Үйл ажиллагааны хэрэгжилт

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүдийн эмчилгээ, оношилгоонд шинэ технологи нэвтрүүлэн ажилласан хэрэгжилтийн үнэлгээнд Хавдар судлалын үндэсний төв, Улсын III төв эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвүүд хамгийн өндөр хувьтай буюу 100 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Эндээс харахад Эрүүл мэндийн технологи нь тухайн байгууллагын магадлан итгэмжлэлийн үзүүлэлт болон гарч байна. Түүнчлэн магадлан итгэмжлэлийн үзүүлэлт нь хэт ерөнхий буюу “шинэ технологийг түгээх дэлгэрүүлэх” хэмээн ерөнхий тусган тухайн байгууллагын өөрийн үнэлгээгээр тооцож, уг технологийн бүртгэл, зардал, үр дүн, үр нөлөөний судалгаа огт хийгдээгүй байна.

2021 онд ХСҮТ-өөс ЭМХТ-д хүргүүлсэн шинэ технологийн хөтлөлт, ашиглалт, үр дүнг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 7. ХСҮТ-ийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан.


№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хүрсэн үр дүн	Хувь
<b>2-р зорилтын хүрээнд: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлэх, хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх</b>				
1	Чанар сайжруулах “Сайн туршлагын сан-Шинэ технологи”-ийн хөтлөлтийг	2021 оны эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн оношлогоо, эмчилгээний шинэ арга дэвшилтэт технологийг чанарын мэдээллийн санд бүртгэсэн. Энэ онд 7 тасаг 14 шинэ технологи, шинэ эмчилгээний арга нэвтрүүлсэн бол 3 тасагт 5 эмчилгээний тоног	“Сайн туршлагын сан -Шинэ технологи”-ийн хөтлөлтийг сайжруулж эмнэлгийн хэмжээнд	100

тогтмолжуулах, сурталчлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлж түгээх

төхөөрөмжийг шинээр суурилуулан ашиглаж эхэлсэн байна.

### ЭЦНБМЗТ

1. Дурангийн мэс заслын үед Indocyanine green fluorescence imaging(эрүүл болон хавдартай хэсгийн заагийг тодруулж, ялгах) орчин үеийн шинэ технологи ашиглан элэг тайрах хагалгаа



2. Элэгний хагалгааны дараах үндсэн хүндрэл болох элэгний дутагдлын тохиолдлын тоог бууруулах зорилгоор өвчтөнд үлдэх элэгний үйл ажиллагааг үнэлэх орчин үеийн шинэ технологи болох **(Indocyanine green retention rate) ICG** сорил



### Туяа эмчилгээний тасаг

1. Хавдрын туяа эмчилгээнд Эрчмийг тохируулсан туяа эмчилгээ /IMRT/-г нэвтрүүлэх
  - Шаардлагатай Small field камеруудыг Олон улсын атомын энергийн агентлагийн MON6020 төслөөр захиалан хүлээн авсанаар хэмжилтэнд хэрэглэгдэх дозиметрийн багажуудаар хангагдсан.
  - 8 сарын 13-аас цацрагийн өгөгдлийг цуглуулах хэмжилт хийгдэж эхэлсэн. Хэмжилтээр 2 шугаман хурдасгуурын цацрагийн талбайн алдаа IMRT эмчилгээний шаардлагад нийцэхгүй байгаа тул cross hair window ийг сольж дахин тохируулга хийх шаардлагатай болсон. Солих сэлбэгийг захиалсан ба тээвэрлэгдэн ирэхийг хүлээж байгаа тул хэмжилтийг түр хугацаанд зогсоогоод байна.

сурталчилан таниулж үйл ажиллагаанд бүрэн нутагшуулж байна. Хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж тасралтгүй сайжирч байна.

- 6 сараас эхлэн сард 2 удаа Австралийн эмнэлгийн физикч нартай Эрчмийг тохируулсан туяа эмчилгээний коммишонинг чиглэлээр уулзалт зохион байгуулж зөвлөгөө авч байна.
- Олон улсын атомын энергийн агенлагийн MON6020 төслийн хүрээнд хөндлөнгийн аудит хийлгэх экспертийн захиалга өгсөн нь баталгаажсан.
- OCTAVIOUS, DIMOND, STARCHECK, Film Pro зэрэг чанарын хяналтын ашиглагдах дозиметрийн багажуудыг бэлтгэж байна.

2. Хавдрын туяа эмчилгээнд портал зургийн /EPID/ дүрс зургийн хяналтыг нэвтрүүлэх
  - ОУАЭА-ийн төслөөр 149900 Еврогийн худалдан авалт хийгдэж хүлээн авсан.

#### **ЦХМЗТ**

1. Хөх хадгалах хагалгааны үед шууд хөхний диффектийг нөхөн сэргээх



2. Хөх бүтэн авах мэс заслын үед шууд хөхийг нөхөн сэргээх

#### **ЕМЗТ:**

1. Хагалгаанд орж байгаа хэвтэн эмчлүүлэгч болгонд Мэс заслын зөвшөөрлийн хуудас болон American college of surgeon -risk calculator хэрэглэж хэвшсэн.

#### **НСМЗТ**


1. Нүүр өргөх хагалгаа
2. Сөрөг даралтат шархны эмчилгээ
3. Эд сунгагч ашигласан.

#### **ЭМЗТ**

1. "Hysteroscopy" Умайн хөндийн салст хуулах мэс засал



2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйд умайн хүзүүний өмөнгийн IA2 үе шатанд үтрээгээр умайн хүзүүг тайрч "Indocyanine green" бодисыг умайн хүзүүнд тарьж

		<p>хэвлийн дурангаар аарцгийн харуул тунгалагийн булчирхайн хамт авах мэс заслыг нэвтүүлсэн.</p> 		
2	Эмчилгээ үйлчилгээнд шинэ орчин үеийн багаж тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх	<p>1. PULMO VISTA 500 уушгины агааржилт, эзэлхүүн үнэлэх шинэ технологийн аппаратын 3 өвчтөнд амжилттай хэрэглэсэн.</p> <p>2. Prisma flex CRRT аппаратыг 5 хүнд амжилттай хэрэглэн сайн үр дүн гараад байна</p> <p>3. Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлэгдэж байсан элэг шилжүүлэх хагалгааны дараах дархлаа дарангуйлагдсан суурин дээр Ковид 19 халдвар аван, хүндэрсэн өвчтөн ECMO(уушги орлуулах аппарат) мөн CRRT (бөөр орлуулах аппарат) зэрэг амжилттай ажиллуулсан ICT, TENS хосолсон аппарат Сэргээн засах тасагт хэрэглэгдэж эхэлсэн.</p> <p><b>ЯТТ</b></p> <p>Яаралтай тусламжийн тасагт 2021 оны 09 дүгээр сард өндөр урсгалт хүчилтөрөгч эмчилгээг /High flow oxygen mask/ өвчтөнд хүчилтөрөгч өгөх шинэ технологи судалж, зориулалтын гуурсаар КОВИД-н дараах эрт үеийн 2 талын уушгины хатгалгааны ARDS-тай өвчтөнд хэрэглэж байна.</p> <p><b>ДОТ</b></p> <p>1. Багаж тоног төхөөрөмжийг сайжруулах хүрээнд хэт авиан оношилгооны төхөөрөмжүүдийг бүрэн шинэчилсэн, зөөврийн дижитал рентген аппарат, C-arm аппаратуудыг шинээр суурилуулан ажиллаж байна.</p> <p>2. Дүрс оношилгоонд DICOM систем шинээр суурилуулж, PACS системийг нэвтрүүлсэн.</p>	<p>Оношилгоо, эмчилгээний чадамж, үр дүн дээшилсэн. PACS системд бүх тасгуудыг холбосон нь үйлчлүүлэгчийн шинжилгээ, дүрс оношилгооны мэдээлэл солилцож цаг хэмнэх, үйлчилгээг хөнгөн шуурхай болгох боломжийг бүрдүүлэв.</p>	100
3	Өндөр үр дүнтэй шинэ технологи, эм, хэрэгслийг практикт шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2021 оны 12 сарын 01-ний А/57 тоот тушаалаар Шинэ технологийн хороог байгуулж шинэ технологи нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлсэн.</li> <li>2021 оны 03 сарын 01-нээс 8 нэр төрлийн хавдрын бай эмийг эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж байна. Шинээр меланома болон хөхний хавдрын эмүүд шинээр хэрэглэгдэж, 100% даатгалаас санхүүжүүлж байна.</li> <li>2022 онд бай эмчилгээнд 10 нэр төлийн эм оруулахаар төлөвлөж байна.</li> </ul>	<p>Шинэ багаж тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхдээ технологийн хорооны журмаар, эмчилгээний шинэ арга аргачлал, эм эмнэлгийн хэрэгслийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхдээ эмнэлзүйн хорооны</p>	100

			журмаар тус тус зохицуулав. Шинэ эм, техник хэрэгсэл, технологийг шинээр нэвтрүүлж эмчилгээний үр дүн нээгдсэн. Эмчлүүлэгчид илрэх химийн эмчилгээний гаж нөлөө буурсан.	
--	--	--	--	--

Тус тайлангийн хүрсэн үр дүнд “Сайн туршлагын сан-Шинэ технологи”-ийн хөтлөлтийг сайжруулж эмнэлгийн хэмжээнд сурталчилан таниулж үйл ажиллагаанд бүрэн нутагшуулж байна. Хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж тасралтгүй сайжирч байна, оношилгоо, эмчилгээний чадамж, үр дүн дээшилсэн, шинэ багаж тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхдээ технологийн хорооны журмаар, эмчилгээний шинэ арга аргачлал, эм эмнэлгийн хэрэгслийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхдээ эмнэлзүйн хорооны журмаар тус тус зохицуулсан, шинэ эм, техник хэрэгсэл, технологийг шинээр нэвтрүүлж эмчилгээний үр дүн нээгдсэн. Эмчлүүлэгчид илрэх химийн эмчилгээний гаж нөлөө буурсан үр дүн гарсан гэж дүгнэсэн ч үр дүнгээ ямар үзүүлэлтээр гарган үр дүнг тооцсонг цааш судлах шаардлагатай.

ЭМХТ-ийн ЭМЭЗБСА-наас “2015-2020 онд практикт нэвтрүүлсэн эрүүл мэндийн технологийн мэдээлэл”-д шинээр нэвтрүүлсэн технологийг дараах 9 үзүүлэлтээр бүртгэн дүн шинжилгээ хийсэн байна.

*Хүснэгт 8. 2015-2020 онд практикт нэвтрүүлсэн эрүүл мэндийн технологийн мэдээлэл”-ийн бүртгэлийн хуудас*

№	Технологийн төрөл	Нэвтрүүлсэн он	Нэвтрүүлсэн тасаг, нэгж	Технологийн үнэлгээ хийгдсэн эсэх		Удирдамж заавар, стандарт	Нэвтрүүлсэн ээс хойш байнага ашиглаж байгаа эсэх		Үр дүн	Тулгамдсан асуудал
				тийм	үгүй		тийм	үгүй		
1.										
2.										

Тус мэдээлэлд нийт 8 Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд хамрагдсан ба шинээр нэвтрүүлсэн технологийн 37 хувьд нь эрүүл мэндийн байгууллага үнэлгээ хийсэн, 84,3 хувийг нь байнга ашиглаж байгаа гэсэн үр дүн гарсан байна. Харин ХСҮТ 2015-2020 онд 40 шинэ технологи нэвтрүүлсэн ба үүнээс 3 буюу 7,5 хувьд нь л шинэ технологийн үнэлгээ хийсэн гэсэн үр дүн гарсан байна.

Эндээс харахад тухайн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын тухайн онд шинээр нэвтрүүлсэн илрүүлэг, оношлогоо, эмчилгээний шинэ технологийг бүртгэсэн

ч бүртгэлийн үзүүлэлт нь хэт ерөнхий уг технологийн үр дүн, үр нөлөөний судалгаа хомс байна.

*Шигтгээ ,,,*

*Эмчилгээ, оношилгооны нөлөө болоод үр дүнтэй эсэхийг олон улсад батлагдсан судалгааны үр дүн болон тухайн технологийг гардан ашиглаж буй тасгийн эмч нар л судалж гаргадаг.*

*Ярилцлага 1.*

## **Б. ХСҮТ-ийн хавдрын оношилгоо, эмчилгээнд нэвтэрсэн шинэ технологиуд.**

Бид 2018-2022 онд ХСҮТ –ийн оношилгоо, эмчилгээнд нэвтэрсэн шинэ технологиудыг уг төвийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны тайлангаас шинээр нэвтрүүлсэн технологиудыг судлахад шинэ технологийг бүртгэхдээ технологийн төрөл, зориулалт зэргээр салгаж бүртгээгүй, нэг технологийг дараа онд давхар бүртгэсэн байв.

*Хүснэгт 8. ХСҮТ-ийн шинээр нэвтрүүлсэн технологийг бүртгэсэн байдал*

<b>Үзүүлэлт</b>	<b>Байдаг</b>	<b>Байхгүй</b>
Технологийн нэр	✓	-
Нэвтэрсэн тасаг	✓	
Олон улсад нэвтэрсэн он		-
Монгол улсад нэвтрүүлсэн он	✓	
Шинэ технологи бүртгэх хуудас		-
Технологийн зориулалт, хэрэглээ		-
Онцлог		-
Давуу тал		-
Сул тал		-
Эсрэг заалт		-
Тус технологийн зардал		-
Тухайн технологийн үйлчилгээ авсан хүний тоо	✓	
Үр дүн		-
Хүндрэл		-
Тухайн технологийг ашиглаж буй зураг	✓	
Хяналт	-	-
Нэгдсэн сан		-

ХСҮТ нь шинээр нэвтрүүлсэн технологийн бүртгэлийг технологийн нэр, он, тасаг, тус технологийн эмчилгээ, оношилгоо, үйлчилгээ авсан хүний тоо, ашиглаж буй зураг гэсэн үзүүлэлтээр технологийн тайланг гаргадаг байна.

*Шигтгээ ,,*

*Шинээр нэвтрүүлсэн технологийн мэдээллийг үзүүлэлт бүрээр бүрэн гаргах боломжтой ч бид сайдын тушаалын дагуу ерөнхий байдлаар хөтлөн тайланд тусган мэдээллэж байна.*

*Ярилцлага 2.*

ХСҮТ-ийн хувьд шинэ технологийг бүртгэх, мэдээлэх, тайлагнах ажил хийгдэж байгаа хэдий ч энэ нь үр ашиг, үр нөлөөг үнэлэх боломжгүй, бүртгэх болон мэдээлэх хуудасгүй, тасаг, нэгжийн уялдаа сул байна. 2018-2021 онд ХСҮТ-ийн шинээр нэвтрүүлсэн технологийн хөтлөлтийг зарим төрлөөр салган бүртгэж дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 9. ХСҮТ-ийн 2018-2021 онд шинээр нэвтрүүлсэн технологийн бүртгэл*

Он	ХСҮТ-ийн тайланд	Төрөл						Нийт
		Эмчилгээ	Оношилгоо	Тонг төхөөрөмж	Нөхөн сэргээх	Эм	Бусад	
2018	Эмчилгээ, оношилгоонд 12 тасгийн 20 шинэ технологи бүртгэгдсэн байна.	5	2	2	2	3	4	19/20 1 технологи дутуу
2019	8 тасгийн 13 шинэ технологи бүртгэгдсэн байна.	7	3	1	-	-	-	11/13 өмнөх оны 2 технологи давтагдсан
2020	14 тасаг, албадын 21 төрлийн шинэ технологи бүртгэгдсэн байна	6	-	5	-	1	4	16/21 өмнөх оны 2 технологи давтагдсан. Мөн 1 стандарт үйл ажиллагааны заавар, 1 ариутгалын тасаг, 1 ерөөний засвар
2021	7 тасаг 14 шинэ технологи, шинэ эмчилгээний арга нэвтрүүлсэн бол 3 тасагт 5 эмчилгээний тоног төхөөрөмж шинээр суурилуулсан байна.	5	3	7	-	-	3	18/21 өмнөх оны 2 технологи давтагдсан. Мөн зөвшөөрлийн хуудас 1

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны тайлангаас шинээр бүртгэсэн технологийг шүүн үзэхэд нэвтрүүлсэн технологийг дутуу тоолсон, өмнөх онд бүртгэгдсэн технологийг дараагийн онд давхар бүртгэсэн, эрүүл мэндийн технологид хамаарахгүй үйл ажиллагааг оруулан мэдээлсэн байна. Жишээ нь: ерөөний засвар үйлчилгээ, стандарт үйл ажиллагааны заавар, үйлчлүүлэгчийн зөвшөөрлийн хуудсыг шинэ технологи хэмээн мэдээлж бүртгэсэн байна.

Шинээр нэвтрүүлсэн технологийн мэдээлэл нэгдсэн байдлаар гардаггүй, тухайн технологийг ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн тоо, эмчилгээ, оношилгооны үр дүн, хяналт хийгддэх эсэх нь тодорхойгүй, өмнөх нэвтэрсэн ижил төстэй технологиос юугаараа онцлог болон давуу талтай эсэх, тухайн технологийг зайлшгүй нэвтрүүлэх эрэлт, хэрэгцээ нь юу болох, технологи нэвтрүүлэхэд гарсан зардал, хүний нөөцийг сургах, мэргэшүүлэхэд гарах зардал зэргийг тайланд тусгаагүй байсан.

Харин хорт хавдрын бүртгэл тандалтыг Хавдар судлалын үндэсний төвийн Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн алба нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж хорт хавдрын өвчлөл, нас баралтын жилийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээллэн Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Хорт хавдрын өвчлөл, нас баралтын үндэсний хэмжээний мэдээний сан” үүсгэн ажилладаг.

## **БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

1. ЭМХТ-д Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын тухайн онд шинээр нэвтрүүлсэн илрүүлэг, оношилгоо, эмчилгээний шинэ технологийг бүртгэх албан ёсны маягт байхгүй, энэ нь улсын хэмжээнд нэгтгэгдэн гарах боломжгүй, зөвхөн тухайн байгууллагын магадлан итгэмжлэлийн үзүүлэлт болж тайланд тусгагддаг байна. Магадлан итгэмжлэлийн үзүүлэлт нь хэт ерөнхий, хэмжигдэх, үнэлэх боломжгүй, ЭМЭЗБСА-ны ЭМТҮ, дүн шинжилгээ нь тухайн технологийг ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн тоо, эмчилгээ, оношилгооны үр дүн, хяналт хийгддэх эсэх нь тодорхойгүй, өмнөх нэвтэрсэн ижил төстэй технологиос юугаараа онцлог болон давуу талтай эсэх, тухайн технологийг зайлшгүй нэвтрүүлэх эрэлт, хэрэгцээ нь юу болох, технологи нэвтрүүлэхэд гарсан зардал, хүний нөөцийг сургах, мэргэшүүлэхэд гарах зардал зэргийг судлаагүй ба 9 үзүүлэлтээр бүртгэл хийгдэн үр ашгийн судалгаа огт хийгдээгүй байна. Цаашид Монгол улсын хэмжээнд ЭМБ-ын оношилгоо, эмчилгээнд шинээр нэвтрүүлж буй технологийг дэлгэрүүлж бүртгэх, мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх буюу анхан шатны маягтыг боловсруулах, мэдээлэх урсгалыг тодорхой болгох нь нэн чухал байна.
2. ХСҮТ-ийн хувьд шинээр нэвтрүүлсэн технологийн нэгдсэн бүртгэл, маягт байдаггүй, технологийн үнэлгээ хийгддэггүй тул цаашид судалгаа шинжилгээ хийх, технологийг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах, бодлого шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангахад хангалтгүй байна. Мөн мэдээллийн урсгал тодорхойгүй, нэгдсэн сан үүсээгүй, бүртгэх, тайлагнах загвар, заавар,



журам тодорхойгүй байсан нь цаашид эрүүл мэндийн технологийг нэгдсэн нэг стандартаар бүртгэн үр дүнг хянах, мэдээллэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.

### 3.2 ЭЛЭГНИЙ ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭ, ОНОШЛОГООНД НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИЙН НАРИЙВЧИЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ХСҮТ-ийн 2018-2021 онд шинээр нэвтрүүлсэн технологиудыг судалж үзэхэд элэгний хавдрын эмчилгээ, оношилгоонд нэвтэрсэн технологиуд давамгайлж байсан тул бид элэгний хавдрын эмчилгээ, оношилгоонд нэвтэрсэн технологиудыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн.

ХСҮТ-д элэгний хавдрын мэс засал эмчилгээг Ерөнхий мэс заслын тасаг, Элэг шилжүүлэн суулгах мэс заслын тасаг, Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгуудад хийж гүйцэтгэдэг бол Ангиографийн тасагт дүрсийн хяналттай элэгний хавдрын жижиг мэс засал хийгддэг байна. Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг нь байгуулагдаад 14 жил өнгөрсөн ба элэгний анхдагч болон хоёрдогч хавдрын оношилгоо, мэс засал эмчилгээг тогтмол хийдэг ба элэгний хавдрын эмчилгээ, оношилгооны шинэ, дэвшилтэт технологийг дэлхийн жишигт нийцүүлэн нэвтрүүлж ашиглаж байгаа ч тэдгээр технологийн эмчилгээний дараах үр дүнг судалсан судалгаа хараахан бүрэн хийгдээгүй байна.

*Шигтгээ ,,,*

*Олон улсад эмчилгээний үд дүнг тооцон дүгнэхдээ 1,3 жил болон 5 жилийн амьдрах чадварыг судлан дүгнэдэг тул одоогоор 5 жилийн амьдрах чадамжийг судалсан бүрэн хэмжээний судалгаа, үр дүн цаг хугацааны хувьд гарах боломжгүй байна.*

#### Ярилцлага 3.

*Хүснэгт 10. 2018-2021 онд шинээр нэвтрүүлсэн мэс засал эмчилгээний технологи*

Элэгний мэс засал (50.0-50.6,50.09) хийгддэг тасгууд	2018	2019	2020	2021
<b>Ангиографийн тасагт</b>	Элэгний хавдрыг бичил зүүгээр түлэх <b>MWA</b> эмчилгээ		<b>“Angio Pack”</b> дотор ажилбарын нэг удаагийн багц	
<b>Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг</b>	Элэгний анхдагч өмөнтэй өвчтөнд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал	Дээд гэдсээр ампул тайрах мэс засал <b>Transduodenal ampulectomy</b>		Элэг тайрах хагалгаанд <b>Indocyanine green fluorescence imaging</b> нэвтрүүлсэн.  Элэгний үйл ажиллагааг үнэлэх <b>Indocyanine green retention rate ICG</b> сорил нэвтрүүлсэн.

**Ерөнхий мэс  
заслын тасаг**

Шулуун  
гэдэсний  
булчинг  
хадгалан,  
тайрагдсан  
гэдсийг шулуун  
гэдэсний  
амсартай  
залгах

Мэс заслын  
зөвшөөрлийн  
хуудас болон  
American college of  
surgeon risk  
calculator-ыг  
хэрэглэж эхэлсэн

ХСҮТ-ийн элэгний хавдрын мэс засал эмчилгээ хийгддэг 3 тасаг 2018-2021 онд 8 шинэ технологи нэвтрүүлснээс 4 нь элэгний хавдрын эмчилгээний технологи байна. Эдгээр шинэ технологиудаас зонхилон тохиолдох элэгний хавдрын оношилгоо, эмчилгээний шинэ технологийн үнэлгээ, судалгааг хийсэн.

Бидний судалгааны үр дүнг судлах хэсэгт шаардлагатай гол мэдээлэл болох 2018 онд Бичил долгионоор түлэх (MWA) эмчилгээ хийлгэсэн хүний тоог ижил төстэй технологи болох Радио долгионоор түлэх (RFA) эмчилгээтэй хамт бүртгэсэн тул статистик мэдээллийг авахад хүндрэл учирч Ангиографийн тасгийн үйл ажиллагааны тайлангаас тус эмчилгээг 2018 онд хийлгэсэн өвчтөнүүдийн мэдээллийг шүүн авсан.


**A. Microwave Ablation (MWA)**

Microwave Ablation (MWA) - Бичил долгионоор түлэх эмчилгээ. Уг мэс засал эмчилгээний мэдээллийг нэгтгэн доорхи хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 11. Бичил долгионоор түлэх шинэ технологи*

<b>I. Бичил долгионоор түлэх эмчилгээ</b>		
<b>Үзүүлэлт</b>		<b>Тайлбар</b>
<b>1.</b>	<b>Нэршил</b>	Microwave Ablation (MWA)
<b>2.</b>	<b>Нэвтэрсэн он</b>	Анх Япон улсад нэвтрүүлж Хятад улс түгээн дэлгэрүүлсэн. Одоогоор дэлхийн 30 гаран оронд албан ёсоор эмчилгээнд нэвтэрсэн. Манай оронд 2018 оны 4 сараас ХСҮТ-д нэвтрүүлсэн.
<b>3.</b>	<b>Хийгдсэн хүн</b>	Уг эмчилгээг одоогийн байдлаар 33-87 насны 375 өвчтөнд хийж гүйцэтгэсэн.
<b>4.</b>	<b>Онцлог</b>	Бичил долгионоор түлэх (MWA) нь электрон соронзон аргачлалаар керамик зүүний тусламжтай 900-2450 MHz давтамжаар 100-150C хэм халж хавдрын эсийг түлж эмчилдэг.
<b>5.</b>	<b>Давуу тал</b>	<ul style="list-style-type: none"><li>• Дүрсийн хяналттай арьсны гаднаас хатгалт хийнэ</li><li>• Өвчтөнд гэмтэл бага учруулдаг /зовуурь бага, шарх сорви бага үүснэ/</li><li>• Эмнэлэгт олон хоног хэвтэх шаардлагагүй</li><li>• Эрт үедээ оношлогдсон жижиг хавдрыг нээлттэй мэс засал хийлгүйгээр бүрэн авах боломжтой</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Үр дүн сайтай, давтан хийгдэх боломжтой</li> <li>• Судасны хажууд байрлалтай хавдрын талбайг бүрэн хамрах боломжтой</li> <li>• Зөвхөн бай эдэд нөлөөлдөг тул энергийн алдагдал, арьсны түлэгдэлт үүсгэдэггүй</li> <li>• 5-7,5 см хүртлэх хэмжээтэй хавдрыг түлэх боломжтой /RFA нь хавдрын тоо 3, хэмжээ 3 см /</li> <li>• Хийгдэх хугацаа хавдрын хэмжээнээс шалтгаалж 3-10 минут</li> <li>• Элэгний хавдраас бусад уушги, яс, бамбай булчирхай, бөөрний хавдар, метастаз-д хийх боломжтой</li> <li>• Биопси авах, цус алдалт бөглөх, хавдрын задрал зэрэгт хийгдэх боломжтой</li> </ul>
6.	<b>Сул тал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Орчны эд ноцтойгоор гэмтэх</li> <li>• Олон антенаар нэгэн зэрэг том хавдрыг түлэх үед антенн хол байрласнаас антенн хоорондын зайд хавдрын эд түлэгдэхгүй үлдэх зэрэг сул талтай</li> </ul>
7.	<b>Монголд нэвтрүүлсэн байдал</b>	<p>Уг технологийг ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018 оны 4 сард албан ёсоор нэвтрүүлж уг технологийг нэвтрүүлсэн 31 дэх орон болсон. Анх эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлдэг Санчир-Ундрах компани тус технологийн талаар мэдээлэл хүргэн Ангиографийн тасгийн эмч нарыг тусламжаар Хятад улсруу 4 удаагийн сургалтад хамруулан мөн БНХАУ-аас эмч урин 5 хүний эмчилгээний материал бэлдэн /тоног төхөөрөмждөө дагалдаж ирсэн/ хамгийн анх 5 хүнд мэс засал хийсэн. ХСҮТ-д тоног төхөөрөмжийг нь тус компани хандивласан байна.</p> <p>Тус технологи нь Дэлхийд нэвтрээд 10 гаран жил болж байгаа ба зөвхөн элэгний хавдраас гадна уушги, яс, бамбай булчирхай, бөөрний хавдар, метастазууд, хавдрын задрал, цус алдалт зэрэгт ашиглагддаг. Биопси авах, цус алдалт бөглөх, хавдрын задрал зэрэгт хийгдэх боломжтой.</p> <p>Өвчтөнд ээлтэй , зовуурь багатай, шарх сорви бага үүсгэдэг, эмнэлэгт олон хоног хэвтэх шаардлагагүй зэрэг ач холбогдолтойгоос гадна хавдар эрт оношлогдсон тохиолдолд/3 см-ээс дотогш хэмжээтэй / мэс засал хийлгүйгээр хавдрыг түлэх эмчилгээг хийдэг болсон.</p>
8.	<b>Нэвтрүүлэхэд гарсан зардал</b>	<p>Ангиографийн тасгийн эмч нарыг Хятад улсруу 4 удаагийн сургалтад хамруулан мөн БНХАУ-аас эмч урин 5 хүний эмчилгээний материал бэлдэн /тоног төхөөрөмждөө дагалдаж ирсэн/ хамгийн анх 5 хүнд мэс засал хийсэн.</p>
9.	<b>Эмчилгээний баг</b>	<p>ХСҮТ-ийн Ангиографийн тасагт MWA бичил долгионоор түлэх эмчилгээний баг 5-6 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг байна. Тус тасаг нь 16 ортойгоор үйл ажиллагаа явуулдаг. Яаралтай мэс засал болон тухайн өвчтөний биеийн байдал, өвдөлтийн зэрэг, мэс заслын хамрах хүрээ зэргээс шалтгаалж зарим ховор тохиолдолд Унтуулгын эмч нэмж ажилладаг байна.</p>

		№	Мэс заслын багийн бүрэлдэхүүн	Тоо
		1	Эмч	1
		2	Туслах эмч	1
		3	Техникч	1
		4	Сувилагч	2
		5	Унтуулгын эмч /Яаралтай болон бусад мэс засалтай хамт хийгдэх үед/	1
	<b>Эмчилгээний төлбөр</b>	2,557,000 төгрөг ЭМД-аас нэхэмжилдэг.		
10.	<b>Тоног төхөөрөмж /зураг/</b>			
11.	<b>Үр дүн</b>	<p>ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018.4 сараас элэгний хавдар, уушгины үсэрхийлэл, бүдүүн гэдэсний хавдар, бамбай булчирхайн хавдар, бөөрний хавдар болон бусад эрхтний метастазад хийгдсэн. Өвчтөнд ээлтэй, эмч нарын ажлыг хөнгөвчилсөн, ор хоног ашиглалт богино, олон төрлийн эмчилгээнд ашиглах боломжтой технологи ба УНТЭ-т 2020.04.01-нд ХСҮТ-ийн MWA бичил долгионоор түлэх эмчилгээний баг тус технологийг нэвтрүүлэн мэс засал хийсэн байна. Мөн Нийслэлийн Өргөө амаржих газарт тус технологиор миом түлэх мэс заслыг хийсэн ба Эрдэнэт хотод хавдрын задрал болон цус алдалтад судас бөглөн, цус алдалт тогтоох мэс заслыг хийж тус технологийг танилцуулсан.</p> <p>“Уушгины хавдрыг түлэх эмчилгээ” ОУ-ийн хуралд оролцон илтгэл тавьсан ба Тайланд, Солонгос, Япон улсуудад очиж тус технологийн мэс заслыг хийж байжээ.</p> <p>Тус технологийн үр дүн 10 ба түүнээс дээш жил хийгдэж байж үр дүн баттай гарах ч одоогоор хавдар түлсэн хэсэгт дахилт өгсөн тохиолдол гараагүй, нас баралт тохиолдоогүй ба үйлчлүүлэгчид хагалгаанаас хойш 45-2,5 сар тутам СТ, MRI, ЭХО, хавдрын маркерын шинжилгээ өгөн хяналт хийгддэг.</p> <p>Цаашид Монгол улсад дүрсийн хяналттай мэс заслыг хөгжүүлэх, түгээх, нээлттэй болон дурангийн мэс заслаас ялгах, салгах, тогтсон нэршил олгох, бичил долгиогоор түлэх эмчилгээг үргэлжлүүлэн хийж урт болон богино хугацааны дараах амьдрах тавиланг судлах шаардлагатай байна.</p>		

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт хавдрыг түлэх эмчилгээ хийгддэг бөгөөд Бичил долгионоор түлэх (MWA) болон Өндөр давтамжит радио долгионоор түлэх (RFA) гэсэн хоёр төрлөөр түлэх эмчилгээ хийгддэг.

Тус хоёр эмчилгээ нь Дүрсийн хяналт дор дулааны аргаар хавдрыг түлж эмчилдэг ижил төстэй мэс заслууд хэдий ч доорх хэдэн онцлог ялгаатай./хүснэгт/

RFA	MWA
<ul style="list-style-type: none"><li>• Хавдрын тоо 3, хэмжээ 3 см хүртлэх хавдрыг түлнэ.</li><li>• Монголд нэвтрээд 14-15 жил болж байгаа ба хавдар дахих магадлалыг 30-35 хувиар бууруулсан.</li><li>• Тусгай тоног төхөөрөмж шаардахгүй ба түлэх зүү дүрсийн хяналтад сайн харагддаг тул ХОН-т нэвтрүүлэхэд хамгийн тохиромжтой.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>• 5-7,5 см хүртлэх хэмжээтэй хавдрыг түлэх боломжтой.</li><li>• Монголд нэвтрээд 4-5 жил болж байгаа.</li><li>• Одоогоор хавдрын дахилт, нас баралт, бүртгэгдээгүй</li><li>• Зүү нь керамик гадаргуутай тул зарим СТ, ЭХО-д сайн харагддаггүй.</li></ul>

Солонгос болон Хятад улсуудад тус дулааны аргуудын аль нь илүү үр дүнтэй болох талаар судалгаа хийгдэж байгаа бол ХСҮТ-д хавдрын байрлал эрсдэлтэй үед уг 2 эмчилгээний алийг нь сонгон хийх, эдийн эсэргүүцлийн ялгаа зэргийг судалж байна.

*Шигтгээ ,,,*

*Олон улсад хавдар эрт үедээ оношлогдсон болон хавдрын хэмжээ 3 см-ээс дотогш бол мэс засал хийлгүйгээр шууд түлэх эмчилгээг хийдэг болсон. Хятад, Солонгос, Японд MWA, RFA дулааны аргуудын аль нь шилдэг арга болохыг тогтоох судалгаа хийгдэж байгаа ч бидний туршлагаас бол MWA түлэх эмчилгээ нь хавдрын байрлал эгзэгтэй үеийн болон хэмжээ том үеийн эмчилгээний сонголт болдог.*

*Ярилцлага 4.*

ХСҮТ-д элэгний хавдрын мэс засал эмчилгээг Ерөнхий мэс заслын тасаг, Элэг шилжүүлэн суулгах мэс заслын тасаг, Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгуудад хийж гүйцэтгэдэг бол Ангиографийн тасагт дүрсийн хяналттай элэгний хавдрын мэс заслууд хийгддэг байна. Эдгээр дүрсийн хяналтат мэс заслыг дүрс оношилгооноос салгах, албан ёсоор нэршил өгөх шаардлагатай байна.

*Шигтгээ ,,,*

*RFA эмчилгээний зүү нь ЭХО аппаратад тод харагддаг тул хөдөө орон нутагт нэвтрүүлэхэд хамгийн тохиромжтой, зардал ч багатай эмчилгээ. Энэ технологийг зөвхөн элэгний хавдар түлэхээс гадна бусад эрхтний хавдрыг түлэх, хавдрын задрал, цус алдалтын үед судас түлж цус алдалтыг зогсоох, биопси авах гээд олон хэлбэрээр хэрэглэх боломжтой тул хөдөө орон нутагт нэвтрүүлж эмч нараа дадлагажуулвал их л ач холбогдолтой доо.*

*Ярилцлага 5.*

*Шигтгээ ,,,*

*Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ийм шинэ технологийн судалгаа хийгдэж байгаад маш их талархуштай байна. Цаашид аль эмнэлэгт ямар сүүлийн үеийн шинэ технологи нэвтэрч байна, хаана ямар ур чадвартай эмч, эмнэлгийн ажилчид байна гэдгийг байнга судалж хүний нөөцийн сургалтыг тийш чиглүүлж, эрүүл мэндийн салбарыг тасралтгүй хөгжүүлж байгаасай л гэж хүсч байна.*

*Ярилцлага 6.*

### **Б. Indocyanine green fluorescence imaging (IGFI)**

Элэг тайрах мэс засалд ИЦН флюоресценст дүрслэлийн шинэ арга технологи нэвтрүүлсэн байдлыг доорхи хүснэгтэд харуулав.


*Шигтгээ ,,,*


*Энэ арга бол мэс заслын гүйцэтгэлийг төгс хянах боломж юм.*

*Ярилцлага 7.*

*Хүснэгт 13. ИЦН флюоресценст дүрслэлийн шинэ арга технологи*

<b>II. Индоцианин ногоон (ИЦН) флюоресценст шинэ арга технологи</b>		
1.	<b>Нэршил</b>	Indocyanine green fluorescence
2.	<b>Нэвтэрсэн он</b>	1957 оноос I.J.Fox нь Mayo clinic анагаах ухааны туршилтанд нэвтрүүлж байсан. 1959 оноос элэгний үйл ажиллагааг үнэлэх, зүрхний практикт ашиглахыг зөвшөөрсөн бол ХСҮТ-д 2021 онд тус технологийг нэвтрүүлэн элэгний үйл ажиллагаа үнэлэх, элэг шилжүүлэн суулгах, элэг тайрах мэс засалд ашиглаж эхэлсэн.
3.	<b>Хийгдсэн хүн</b>	20 орчим хүнд тус технологийг ашиглан элэг тайрах мэс засал хийсэн
4.	<b>Онцлог</b>	ИЦН нь цөсний замаар дамжин биеэс ялгардаг бөгөөд элгэнд байрлалтай хавдрыг илрүүлэхэд ач холбогдолтой. Эрүүл элэг нь ИЦН-ыг шингээх болон ялгаруулах хугацаа бага байдаг бол элэгний хатуурал болон хавдартай тохиолдолд уг үйл ажиллагаа удааширсан байдаг. Иймд элэгний хавдар нь тусгай дурангийн тусламжтай хэт улаан туяанд орчны эрүүл эдээс бүрэн болон хэсэгчилсэн байдлаар тод ялгарч харагддаг. ИЦН-ы эдгээр өвөрмөц шинж чанаруудыг ашиглан хортой хавдар болон үсэрхийлсэн хавдрыг бусад хоргүй үүсвэрүүдээс ялгах боломжтой. Өндөр түвшний мэс заслын технологи юм.

		
5.	Давуу тал	<ul style="list-style-type: none"> <li>• ИЦН флюоресценст дүрслэл нь хэрэглэхэд энгийн, хурдан, харьцангуй хямд өртөгтэй, гаж нөлөө багатай</li> <li>• Дан ганц хэвлийн хөндийн болон элэг цэсний замын хорт хавдрыг эмчлэхэд төдийгүй цэсний замын бүтцийг тодорхойлох, цэсний хүүдий авах мэс заслын үед ихээхэн ач холбогдолтой</li> <li>• Судасны бүтэц болон цэсний замын бүтцийг тодруулан дүрсэлснээр дурангийн мэс засал ба бусад төвөгтэй мэс заслуудын үед давуу талтай</li> <li>• Эмч нарын ажлыг хөнгөвчилж мэс заслын гүйцэтгэлийг илүү сайжруулсан.</li> <li>• Хагалгааны явцад давхар оношилгоо хийгдэх боломжтой</li> <li>• Хавдрын илэрцийг сайжруулсан.</li> </ul>
6.	Сул тал	<ul style="list-style-type: none"> <li>• Уг 6 тохиолдолд ИЦН-ыг захын судсаар тарих үед болон хэрэглэсний дараа ямар нэгэн гаж нөлөө бүртгэгдээгүй.</li> <li>• Цуснаас элгэнд метаболизмд орж цэсний сувгаар ялгардаг, бөөрөөр ялгардаггүй, гэдэсний салстаар эргэн шимэгддэггүй хоруу чанар багатай.</li> </ul> <p>Хоруу чанар багатай ч 2007 оны 9 сараас хойш эрдэмтэд ИЦН-ыг хэт ягаан туяаны нөлөөн дор хэд хэдэн төрлийн хоруу чанар бүхий бодис үүсгэдэг болохыг тодорхойлсон. Уг бодисыг судсаар тарихад туршилтын амьтдад үхлийн тун хулганад 60мг/кг, харханд 87мг/кг байсан. Харин эмнэл зүйн туршилтад 42000-н тохиолдолд 1 удаа хоолой сэрвэгэнэх болон халуу дүүгэх зэрэг гаж нөлөө илэрсэн. Ховор тохиолдолд анафилаксийн шок, даралт унах, тахикарди, амьсгаадах болон тууралт гарах зэрэг хүнд хэлбэрийн гаж нөлөө илэрдэг байна.</p>
7.	Монголд нэвтрүүлсэн байдал	<p>ХСҮТ 2021 оноос анх тухайн шинэ технологийн талаар мэдэж судлан Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын тасгийн эмч Япон улсруу хувийн зардлаар очин суралцсан ба үүнд Монголын Элэг Цэс Нойр Булчирхайн Нийгэмлэгээс туслалцаа үзүүлсэн байна. Уг технологийг 2020 оноос ХСҮТ нь Индоцианин ногоон (ИЦН)-ыг элэгний үйл ажиллагаа үнэлэхэд хэрэглэж эхэлсэн ба 2021 оноос элэг, цэсний замын мэс заслын практикт анх нэвтрүүлсэн. Уг технологи бүхий дурангийн мэс заслын үед ашигладаг багажийг ХСҮТ-д нээлттэй хагалгааны үед мөн давхар ашиглаж байгаа ба нээлттэй хагалгааны үед ашигладаг багаж нь ХСҮТ-д байхгүй үнэ өртөг өндөртэй байдаг тул дурангийн мэс заслын үед ашигладаг төхөөрөмжөө нээлттэй хагалгаанд мөн ашигладаг байна. 2022 оноос уг технологийг ХСҮТ-ийн Элэг шилжүүлэн суулгах мэс заслын тасагт хавдартай өвчтөнд амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засалд нэвтрүүлсэн байна</p>

8.	Эмчилгээний баг	<p>ХСҮТ-ийн Элэг цес, нойр булчирхайн мэс заслын тасаг. Багийн бүрэлдэхүүн.</p> <table border="1" data-bbox="758 246 1260 548"> <thead> <tr> <th>Элэгний засалд</th> <th>мэс</th> <th>Элэгний ажиллагаа үнэлэх тест /ICG-test/</th> <th>үйл</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Мэс заслын эмч</td> <td>4</td> <td>Эмч</td> <td>1</td> </tr> <tr> <td>Хагалгааны сувилагч</td> <td>3</td> <td>Сувилагч</td> <td>1</td> </tr> </tbody> </table>	Элэгний засалд	мэс	Элэгний ажиллагаа үнэлэх тест /ICG-test/	үйл	Мэс заслын эмч	4	Эмч	1	Хагалгааны сувилагч	3	Сувилагч	1
Элэгний засалд	мэс	Элэгний ажиллагаа үнэлэх тест /ICG-test/	үйл											
Мэс заслын эмч	4	Эмч	1											
Хагалгааны сувилагч	3	Сувилагч	1											
9.	Эмчилгээний төлбөр	<p>Тус шинэ технологийг ашиглан хавдрын мэс засал эмчилгээ хийлгэхэд өвчтөн хувиасаа 250 000 төгрөгөөр ИЦН бодис худалдан авч хийлгэдэг. Одоогоор ЭМД-д хамрагдаагүй байна.</p>  <p>ИЦН 25 мг хуурай бодис нь 776 дальтон жинтэй, усанд уусдаг анион ба захын судсанд тарьсны дараагаар сийвэнгийн уурагтай (альбумин) хурдан холбогддог. Тусгай дурангийн тусламжтайгаар хэт улаан туяаны нөлөөн дор флюоресценсийн дохиог хүлээж авч тодрол өгдөг.</p>												
10	Тоног төхөөрөмж /зураг/	<p>Аливаа дурангийн мэс заслын тоног төхөөрөмж бүрт хэт улаан туяаны эх үүсвэр байдаггүй тул тусгай тоноглогдсон дурангийн багажийг ашиглах шаардлагатай байдаг.</p>												
11	Үр дүн	<p>ИЦН флюоресценст дүрслэл нь хэрэглэхэд энгийн, хурдан, харьцангуй хямд өртөгтэй, гаж нөлөө багатай арга бөгөөд дан ганц хэвлийн хөндийн болон элэг цесний замын хорт хавдрыг эмчлэхэд төдийгүй цесний замын бүтцийг тодорхойлох, хүндрэлтэй цесний хүүдий авах мэс заслын үед ихээхэн ач холбогдолтой. Мөн судасны бүтэц болон цесний замын бүтцийг тодруулан дүрсэлснээр дурангийн мэс засал ба бусад төвөгтэй мэс заслуудын үед давуу талтай юм.</p> <p>ХСҮТ-ийн Элэг, цес, нойр булчирхайн мэс заслын тасагт ИЦН флюоресценст дүрслэл ашигласан мэс заслын 20 тохиолдлуудад хийгдсэн ИЦН-ыг захын судсаар тарих үед болон хэрэглэсний дараа ямар нэгэн гаж нөлөө бүртгэгдээгүй. ИЦН флюоресценст дүрслэлийн давуу тал нь тухайн мэс заслын гүйцэтгэл болоод аюулгүй байдлыг нэмэгдүүлж, хавдрын илэрцийг сайжруулснаар өмнөх хагалгаануудын дундаж хугацаа болон цус алдалттай харьцуулахад эерэг үр дүнтэй байсан байна.</p> <p>Цаашид Монгол улсад ИЦН-ыг эмнэл зүйд нэвтрүүлэх заалтуудыг нэмэгдүүлэхээс гадна давуу болон сул талуудыг илүү тодорхой болгох шаардлагатай ба тус шинэ технологийг хэрэглэхэд нэгдсэн удирдамж, стандарт батлуулах шаардлагатай.</p> <p>Тус технологийн хувьд үр дүн нь шууд харагддаг төвөгтэй мэс заслын үед эмчийн ажлыг хөнгөвчилж гүйцэтгэлийг</p>												



		сайжруулдаг, мэс заслын явцад давхар оношилгоо, үйл ажиллагааг үнэлэх боломжтой тул элэгний мэс засал хийгддэг бүх эмнэлгүүдэд нэвтрүүлж болох юм.
--	--	--

ИЦН флюоресценст дүрслэл нь тухайн мэс заслын гүйцэтгэл болон аюулгүй байдлыг нэмэгдүүлж, хавдрын илэрцийг сайжруулснаар өмнөх хагалгаануудын дундаж хугацаа болон цус алдалттай харьцуулахад эерэг үр дүнтэй байдаг байна.

*Шигтгээ ,,,*

*Цаашид энэ технологийг эмнэлзүйд нэвтрүүлэх заалтуудыг нэмэгдүүлэн давуу болон сул талыг илүү тодорхой болгон ЭМД-д хамруулах шаардлагатай байгаа. Бид энэ технологийг элэг тайрах нээлттэй болон дурангийн мэс засалд ашиглахын тулд өвчтөнд мэдээлэл хүргэн ач холбогдлыг маш сайн тайлбарлаж байж өвчтөнөөс хувиас нь уг ИЦН бодисыг худалдан авахуулж байж эмчилгээнд ашиглан мэс засал хийдэг.*

*Ярилцлага 8.*

### **B. Liver transplantation surgery**

Амьд донороос хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний шинэ технологийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 14. Элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний шинэ арга технологи*

III. Элэг шилжүүлэн суулгах мэс засал		
1.	Нэршил	Liver Transplantation
2.	Нэвтэрсэн он	Дэлхий дахинд эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал 1960 оноос хийгдэж эхэлсэн, 2016 оны байдлаар 34 854 орчим хүн хийлгэсэн ба үүнээс 27 962 нь амьгүй донороос, 6 892 нь амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгасан байна. ХСҮТ-д 2018 оны 1 сараас эхлэн уг мэс засал хийгдэж эхэлсэн.
3.	Хийгдсэн хүн	Тус мэс заслыг 2018- 2022.5-р сарын байдлаар нийт 52 өвчтөнд хийж гүйцэтгэсэн.
4.	Онцлог	Элэгний хавдрын хамгийн төгс эмчилгээнд ордог ба элэгний хатуурал болон хавдартай хүнд амьд донороос эрхтэн шилжүүлэн хийгддэг. Үргэлжлэх хугацаа 4-10 цаг
5.	Давуу тал	<ul style="list-style-type: none"> <li>• Элэг тайрах мэс засалтай харьцуулахад 1 жилийн дараах амьд үлдэх хувь 90% 5 жилийн дараах нь 70% байдаг.</li> <li>• Элэг тайрах мэс заслын дараа 5 жилийн дараах амьд үлдэх хувь 25% байдаг.</li> <li>• Вирусын шалтгаант хатуурлыг хамт цогцоор нь шийдэх боломжтой</li> <li>• Гадагшаа эмчилгээнд явах зардлыг хэмнэж байгаа</li> </ul>

6.	<b>Сул тал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Өртөг өндөртэй</li> <li>• Эм тарианы олдоц муу/дархлаа дарангуйлах эм/</li> <li>• Хүн хүч их шаарддаг</li> <li>• Эсрэг заалт ихтэй хүнд хагалгааны төрөлд ордог</li> <li>• Хавдрын тоо хэмжээ харгалзана</li> <li>• Бусад эрхтний үйл ажиллагааг харгалзана</li> </ul>
7.	<b>Монголд нэвтрүүлсэн байдал</b>	<p>Монгол улсад нэвтрүүлсэн байдал.</p> <p>Тус шинэ технологийг ЭМЯ “Элэг бүтэн Монгол төслийн хүрээнд”, ЭМХТ, Гадаадын хөрөнгө оруулалтаар ХСҮТ-ийн баг бүрэлдэхүүнийг 2011-2018 он хүртэл 7 жилийн хугацаанд БНСУ-ын Samsung эмнэлэгтэй хамтран давхардсан тоогоор 60 орчим хүний нөөцийг 7 хоногоос 1 сар хүртлэх хугацаанд үе шаттай сургалтад хамруулан ХСҮТ-д 2018 оны 1 сараас Амьд донороос хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хийж эхэлсэн.</p>
8.	<b>Эмчилгээний баг</b>	<p>Уг мэс заслын эмчилгээг хагалгааны үед 40 орчим эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан, хагалгааны дараах хяналт, тусламж үйлчилгээг 50 орчим эмнэлгийн ажилтан хариуцан нийлээд 90 орчим хүний бүрэлдэхүүнтэй хийгддэг.</p>
9.	<b>Эмчилгээний төлбөр</b>	<p>Тус шинэ технологийг ашиглан мэс засал эмчилгээ хийхэд 110-130.000.000 төгрөг.</p> <p>Өндөр өртөгтэй эмчилгээ тул 0-18 насны хүүхэд, нийгмийн халамж асаргаа шаардлагатай хүмүүс, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд, ял эдэлж байгаа ялтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хугацаат цэргийн албан хаагч, хүүхдээ асарч байгаа эх зэрэг 7 бүлгийн хүн амын эмчилгээг ЭМД-аас төлбөрийг 100% төлнө. Бусад иргэд даатгалын сангаас 70 хувь, өөрсдөө 30 хувь төлөх зохицуулалттай.</p>
10.	<b>Тулгамдсан асуудал</b>	<p>Мэргэшсэн хүний нөөц, тэр дундаа Сүрьеэ болон эмнэлгийн халдвар хариуцсан мэргэжилтэн болоод эм тарианы олдоц муу байна.</p>
11	<b>Үр дүн</b>	<p>Эрүүл хүн хагалгаанд орж амьд донор болж байгаа учраас түүнд гарч болзошгүй хүндрэл, сэтгэл зүйн асуудлууд, мөн элэгний үйл ажиллагаа алдагдаж амьдралынхаа төгсгөлийн шатанд орсон хүнийг эмчлэх асар хүнд, цогц хагалгаа бөгөөд донор болон өвчтөний бүх үзүүлэлтийг хянаж байх ёстой маш нарийн технологи. Элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих зардлыг дотооддоо барьж 2018-2022 оны Луирлын байдлаар 53 хүний гадаадад хийгдэх нэг хүний мэс заслын зардал 200-400,000,000 төгрөг болох 1,6-2,1 тэр бум төгрөгийг дотоодын эдийн засагт тогтоон барьсан байна.</p> <p>Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих урсгал 2018 оноос хойш буурсан эсэхийг судлах, элэг шилжүүлэн суулгах мэс заслын үр дүнг перспектив судалгааны аргаар судлан амьдрах чадамж, чанартай амьдралын жилийг судлах, үр дүнг олон нийтэд мэдээллэх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай.</p>

Элэг шилжүүлэн суулгах мэс заслын тасаг нь уг эмчилгээний үр дүнгийн гол үзүүлэлт болох амьдрах чадамжийн судалгааг 3 сар, 1 жил болон 3 жилээр тооцоолон хийж үнэлсэн байна. Судалгааны үр дүнд амьдрах чадамж 6 сар 91,3 хувь, 1 жил 87 хувь, 3 жил 81 хувьтай гарсан байна.

Элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих зардлыг дотооддоо барьж 2018-2022 оны I улирлын байдлаар 53 хүний гадаадад хийгдэх нэг хүний мэс заслын зардал 200-400,000,000 төгрөг болох 1,6-2,1 тэр бум төгрөгийг дотоодын эдийн засагт тогтоон барьсан байна.

#### *Шигтгээ ,,,*

*Хүн хүч их шаардсан мэс засал тул бидэнд ажиллах хүний нөөц, боловсон хүчин хамгийн их тулгамдсан асуудал болж байна. Мөн эм тарианы олдоц муу, цөөн тоотой, мэс засал хийгдэх орчмы хүндрэл зэрэг асуудлууд тулгамддаг.*

*Ярилцлага 9.*


Элэг шилжүүлэн суулгах мэс засалд эрүүл хүн хагалгаанд орж амьд донор болж байгаа учраас түүнд гарч болзошгүй хүндрэл, сэтгэл зүйн асуудлууд, мөн элэгний үйл ажиллагаа алдагдаж амьдралынхаа төгсгөлийн шатанд орсон хүнийг эмчлэх асар хүнд, цогц хагалгаа юм.



*Зураг 3. Дархлаа дарангуйлах эм хэрэглэж буй хүний тоо. 2021 он*

Эрхтэн шилжүүлэн суулгуулсан үйлчлүүлэгчдийн дархлаа дарангуйлах эмийн хэрэглээ 2021 оны байдлаар улсын хэмжээнд 644 хүн, үүнээс орон нутагт 180, нийслэлд 494 хүн тус тус ууж хэрэглэж байна.

Элэгний мэс засал эмчилгээнүүдээс хамгийн төгс элэгний хавдрын мэс засал эмчилгээнд элэг шилжүүлэн суулгах мэс засал ордог байна.



Зураг 4. Элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүлээх жажсаалтад байгаа хүний тоо. 2021 он

2021 оны байдлаар эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр хүлээх жажсаалтад бүртгүүлсэн өвчтөнүүдийн 363 нь бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх шаардлагатай, 242 нь элэгний хатуурал, элэгний хавдар, цөсний ерөнхий сувгийн төрөлхийн битүүрэл шалтгаант элэг шилжүүлэн суулгах мэс засал шаардлагатай тул тус эмчилгээг хийлгэхээр бүртгүүлсэн байна.

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

**Бичил долгионоор түлэх эмчилгээ MWA** нь өвчтөнд ээлтэй, эмч нарын ажлыг хөнгөвчилсөн, ор хоног ашиглалт богино, хийгдэх хугацаа бага, олон төрлийн эмчилгээнд ашиглах боломжтой технологи ба хавдрын задрал болон цус алдалтад судас бөглөн, цус алдалт зогсоох, эдийн шижилгээ авах зэрэг олон ажилбарт ашиглах боломжтой үр дүн сайтай арга байна.

Цаашид Монгол улсад дүрсийн хяналттай мэс заслыг хөгжүүлэх, хөдөө орон нутагт түгээх, дэлгэрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, дүрсийн хяналттай мэс заслыг дүрс оношлогооноос салгах, тогтсон нэршил олгох, бичил долгиогоор түлэх эмчилгээг үргэлжлүүлэн хийж урт болон богино хугацааны дараах амьдрах тавиланг судлах шаардлагатай байна

**Б. ИЦН флюоресценст дүрслэл** нь хэрэглэхэд энгийн, хурдан, харьцангуй хямд өртөгтэй, гаж нөлөө багатай арга бөгөөд дан ганц хэвлийн хөндийн болон элэг цөсний замын хорт хавдрыг эмчлэхэд төдийгүй цөсний замын бүтцийг тодорхойлох, хүндрэлтэй цөсний хүүдий авах мэс заслын үед ихээхэн ач холбогдолтой технологи байна.

Цаашид Монгол улсад ИЦН-ыг эмнэл зүйд нэвтрүүлэх заалтуудыг нэмэгдүүлэхээс гадна давуу болон сул талуудыг илүү тодорхой болгох, ЭМД-д хамруулах шаардлагатай ба тус шинэ технологийг хэрэглэхэд нэгдсэн удирдамж, стандарт батлуулах шаардлагатай байна.

Тус технологийн хувьд үр дүн нь шууд харагддаг төвөгтэй мэс заслын үед эмчийн ажлыг хөнгөвчилж гүйцэтгэлийг сайжруулдаг, мэс заслын явцад давхар оношилгоо, үйл ажиллагааг үнэлэх боломжтой тул элэгний мэс засал хийгддэг бүх эмнэлгүүдэд нэвтрүүлж болох юм.

**В. Амьд донороос хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний шинэ технологи** нь донор болон өвчтөний бүх үзүүлэлтийг хянаж байх ёстой маш нарийн технологи байна.

Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих урсгал 2018 оноос хойш буурсан эсэхийг судлах, элэг шилжүүлэн суулгах мэс заслын үр дүнг проспектив судалгааны аргаар судлан амьдрах чадамж, чанартай амьдралын жилийг судлах, үр дүнг олон нийтэд мэдээллэх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай.

### **3.3 БИЧИЛ ДОЛГИОНООР ТҮЛЭХ ЭМЧИЛГЭЭ (MWA) ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Шинээр нэвтэрсэн технологийн үнэлгээг өмнөх ижил төстэй аль хэдийн нэвтэрсэн технологитой харьцуулан судалж үр дүн болоод зардлыг судлан эдийн засгийн үнэлгээ хийгддэг тул ХСҮТ-ийн Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслыг тасагт хийгддэг Элэгний хавдартай хэсгийг тайрч авах мэс заслыг сонгон 2018 онд ХСҮТ-ийн Ангиографийн тасагт нэвтэрсэн Бичил долгионоор түлэх (MWA) эмчилгээтэй үр дүн болоод зардлыг харьцуулан судалсан. Оношийн бүлгийг сонгохдоо ӨОУА-10 ангиллын дагуу зөвхөн С 22 буюу “Элэгний хорт хавдар” оношлогдсон өвчтөнүүдийг сонгон авсан.

Судалгаандаа бид өвчтөний амьдрах чадамжийг мэс засал хийлгэсний дараах, элэгний хавдрын үе шат, хүйсээр мөн дундаж амьдарсан хугацааг сараар тооцон амьдарсан хугацаатай нь уялдуулан судалсан. Өвчтөний амьдарсан хугацааг мэс засалд орсон өдрөөс нас баралт бүртгэгдсэн өдрөөр тооцон авсан.

Мөн мэс заслын дараах хяналт, бүртгэл, мэдээллийг ретроспектив аргаар гүйцэтгэхэд мэдээлэл бүрэн бус, ажиллагаа ихтэй, тасаг болон албадууд хоорондын уялдаа холбоо тааруу байсан нь манай судалгааг хүндрэлтэй болгож байсан бөгөөд судалгааны үр дүнд эдгэрсэн болон дахилт өгсөн зэрэг үзүүлэлтийг тооцох боломжгүй байсан. Бид шинэ технологийн бүртгэл болон уг технологийн үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг ХСҮТ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг, Ангиографийн тасаг, Санхүү бүртгэлийн хангамжийн алба, Хорт хавдар, бүртгэл, тандалтын эрт илрүүлгийн алба, Эдийн засаг төлөвлөлт, мониторингийн албадуудаас шүүн авсан.

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт хавдрыг түлэх эмчилгээ хийгддэг бөгөөд Бичил долгионоор түлэх (MWA) болон Өндөр давтамжит радио долгионоор түлэх (RFA) гэсэн хоёр төрлөөр түлэх эмчилгээ хийгддэг ч Статистик бүртгэлд MWA эмчилгээ болон RFA эмчилгээг нэг үйлдлийн кодоор 99.85 тэмдэглэдэг ба 2018-2020 онд тус 2 эмчилгээг салгаж тэмдэглээгүй тул эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн мэдээллийг салган авч дүн шинжилгээ хийх боломжгүй байсан ба 2021 оноос H-info Эрүүл мэндийн мэдээллийн системд шинэчлэл хийгдэн уг 2 эмчилгээг тус тусад нь салган авч бүртгэдэг болсон байна. Тиймээс бид 2018 онд Ангиографийн тасагт MWA эмчилгээнд орсон өвчтөнүүдийн тоо болон мэдээллийг Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-1 Өвчний түүхээс шүүн авч тус эмчилгээг хийлгэсэн 38 хүний мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн ба нас баралтын мэдээллийг ЭМХТ-ийн ЭММА-наас шүүн авч судалсан.

*Шигтгээ ,,,  
Тухайн үед /2018 онд/ уг хоёр RFA, MWA эмчилгээг нэг үйлдлийн кодтой, ижил төстэй хавдрыг түлэх эмчилгээ учраас нэгтгэн бүртгэсэн байх... Яагаад салгаагүй юм бол сайн мэдэхгүй байна...*

*Ярилцлага 10.*

Эрүүл мэнд, спортын сайдын 2016.01.29-ний өдрийн дугаар 29 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ЗААВАР”-т элэгний хорт хавдрын эмчилгээг дараах 3 төрлөөр ангилдаг байна.

*Хүснэгт 15. Элэгний хорт хавдрын эмчилгээний төрөл*

Мэс засал эмчилгээ	Хэсэг газрын эмчилгээ	Адьювант, системт эмчилгээ
1. Элэг тайрч хавдар авах	1. Элэгний хавдрын тэжээгч судас бөглөх (TACE)	1. Молекул бай эмчилгээ
2. Элэг шилжүүлэн суулгах	2. Өндөр давтамжит долгионоор түлэх (RFA)	2. Хими эмчилгээ
	3. Этанолоор тарилга хийн аргаар эмчилгээ (PEIT)	3. Хөнгөвчлөх эмчилгээ
	4. Элэгний үүдэн венийг бөглөх (PVE)	

**А. Эмчилгээний үр дүн**

*Хүснэгт 16. Элэгний хавдрын эмчилгээний үр дүн тооцох*

Үр дүн тооцох Олон улсын стандарт	Үр дүнгийн үзүүлэлт
<ul style="list-style-type: none"> <li>• 1-3 жил болон 5 жил амьдрах чадамж болон чанартай амьдралын жилээр</li> <li>• Дахилт өгсөн эсэх / 1 сар хүртлэх хугацаанд <ul style="list-style-type: none"> <li>✓ Элэгний эсийн гаралтай</li> <li>✓ Бусад хавдрын үсэрхийллээс дахилт өгсөн эсэх</li> </ul> </li> <li>• Нас баралт / 1 сар хүртлэх хугацаанд <ul style="list-style-type: none"> <li>-Элэгний хавдрын шалтгаант,</li> <li>-Бусад эрхтний гаралтай</li> </ul> </li> </ul>	<p>Эмчилгээний дараа 3 сар тутам CT, MRI, ЭХО дүгнэлтээр</p> <p>AFP болон хавдрын маркерын шинжилгээгээр дүгнэдэг</p>

Олон улсад эмчилгээний үр дүнг тооцоолон судлахад 1-3 болон 5 жил түүнээс дээш амьдрах чадварыг болон чанартай амьдралын жилээр тооцон судлах зарчим баримталдаг тул идэвхтэй хяналтын үр дүн, өвчтөнүүдийн тавиланг цааш судлах шаардлагатай.


*Хүснэгт 17. MWA, RFA эмчилгээ хийлгэсэн  
үйлчлүүлэгчдийн өвчний төгсгөл болон зарим үзүүлэлт*

№	Технологийн нэр	Он	Хийгдсэн хүний тоо	Хүйс		Өвчний төгсгөл		
				Эр n (%)	Эм n (%)	Үзүүлэлт	n (тоо)	Хувь (%)
1.	<b>MWA</b> болон <b>RFA</b> эмчилгээ	<b>2018</b>	474	<b>202</b> (42.6%)	<b>272</b> (57.4%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	- 469 5	- 98.9% 1.1%
		<b>2019</b>	401	<b>170</b> (42.4%)	<b>231</b> (57.6%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	11 386 4	2.7% 96.3% 1%
		<b>2020</b>	299	<b>122</b> (40.8%)	<b>177</b> (59.2%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	19 279 1	6.4% 93.3% 0.3%
2.	<b>MWA</b> буюу бичил долгионоор түлэх эмчилгээ	<b>2021</b>	71	<b>25</b> (35.7%)	<b>46</b> (64.3%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	17 53 1	23.9% 74.6% 1.5%
		<b>2022 (I улирал)</b>	23	<b>13</b> (55.6%)	<b>10</b> (44.4%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	- 23 -	- 100% -
3.	<b>RFA</b> буюу өндөр давтамжит радио долгионоор түлэх эмчилгээ	<b>2021</b>	163	<b>92</b> (56.2%)	<b>71</b> (43.8%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	16 147 -	9.9% 90.1% -
		<b>2022 (I улирал)</b>	61	<b>25</b> (41.2%)	<b>36</b> (58.8%)	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	2 58 2	2.4% 95.2% 2.4%

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018-2022 оны I улиралд RFA болон MWA эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн өвчний төгсгөл “Сайжирсан” 95.1 хувь, “Эдгэрсэн” 6.4 хувь, “Хэвэндээ” 1.8 хувийг эзэлж байна.

Хүйсээр эр:эм 44.9:55.1 хувь буюу тус эмчилгээнд эмэгтэй өвчтөн эрэгтэй хүйсийн өвчтөнөөс 10.2 хувиар илүү орсон бол тус эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна.

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018 онд Бичил долгионоор түлэх эмчилгээг нийт 38 хүн хийлгэсэн ба өвчтөнүүдийн эмнэлгээс гарах үеийн өвчний төгсгөлийг доорхи зурагт үзүүлэв.



Зураг 5. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн өвчний төгсгөл

Тус эмчилгээг хийлгэсэн үйлчлүүлэгчдийн эмнэлгээс гарах үеийн өвчний төгсгөлд эдгэрэлт, нас баралт бүртгэгдээгүй бол 97,4 хувь нь сайжирсан, 2,6 хувь нь хэвэндээ гэсэн оношоор эмнэлгээс гарсан байна.

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018 онд Бичил зүүгээр түлэх эмчилгээ хийлгэсэн 38 хүн байсан ба тус 38 үйлчлүүлэгчийн эмчилгээний дараах эргэн хянах тогтолцоо ойлгомжгүй, эдгээр хүмүүсийн хэд нь амьд, хэд нь нас барсан тухай мэдээллийг ХСҮТ-өөс мэдээллэдэггүй, бүртгэдэггүй байна.

Хүснэгт 18. Нас барсан үйлчлүүлэгчдийн дундаж амьдарсан хугацаа

Үзүүлэлт	Мэс засал хийлгэсэн хүн (n)	Нас барсан		Дундаж амьдарсан хугацаа /сараар/ (n)	Амьдарсан хугацаа		
		(n)	(%)		1 хүртлэх жил	1-3 жил	4-5 жил /48-53 сар/
<b>Нийт</b>	38	7	18.4%	22.1	5%	13%	-
<b>Хүйс Эр</b>	22	5	13%	21.4	2.6%	10.5%	-
<b>Эм</b>	16	2	5%	24.0	2.6%	2.6%	-

ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018 онд Бичил зүүгээр түлэх эмчилгээ хийлгэсэн 38 үйлчлүүлэгчээс 2022 оны байдлаар нас барсан 7, дундаж амьдарсан хугацаа 22.1 сар байна. Нас барсан үйлчлүүлэгчдээс 1 хүртлэх жил амьдарсан нь 5 хувь, 1-3 жил амьдарсан хүмүүс 13 хувийг эзэлж байна.

Бид элэгний хавдраар өвчлөгсдийн амьдрах чадварыг тооцоходоо тухайн эмчилгээ хийлгэн эмнэлэгт хэвтсэн өдөр, элэгний хавдраар нас барсан өдрийг эмчилгээ хийлгэх үеийн хавдрын үе шат, эмчилгээний төрөл, эмнэлгээс гарах үеийн өвчний төгсгөл, нас баралт, амьдрах чадамж, амьдарсан хугацаа зэрэг олон үзүүлэлтээр тооцон судалсан.



*Хүснэгт 19. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн амьдрах чадамж*

Он	Тохиолдол	Хасагдсан тохиолдол	Тухайн жилд нас барсан хувь	Тухайн жилд амьд үлдсэн хувь	Амьдрах чадамж
2018	38	2	5.2%	94.8%	94.8%
2019	36	1	2.7%	97.3%	86.9%
2020	35	2	5.7%	94.3%	73.9%
2021	33	2	6.0%	94.0%	58.3%
2022	31	-	-	-	-

Судалгаанд хамрагдсан Бичил долгионоор түлэх эмчилгээнд орсон үйлчлүүлэгчдийн 5,2 хувь нь нэг жил хүрэхгүй хугацаанд нас барж 94,7 хувь нь амьд үлдэж амьдрах чадвар 94,7 хувьтай байсан. Эхний жилд 2,6 хувь нь нас барж 97,3 хувь амьд үлдсэн, амьдрах чадвар 86,9 хувьтай, харин 3 дахь жилд 5,7 хувь нас барсан ба 94,3 хувь амьд үлдэж амьдрах чадвар 73,9 хувь болж буурсан үзүүлэлттэй байв.

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдээс 2022 оны 5-р сарын байдлаар нас барсан тохиолдол байхгүй байлаа.

Бид судалгаандаа элэгний хорт хавдрын өвчлөл болон нас баралт хорт хавдраас шалтгаалсан амьдрах чадвар нь хавдрын үе шатаас хамааралтай эсэхийг тодруулж үзсэн.

*Хүснэгт 20. 2018 онд MWA эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн хавдрын үе шат*

Үе шат	Нас барсан		Амьд үлдсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
I үе шат	0	-	11	28.9	11	28.9
II үе шат	1	2.6	13	34.2	14	36.9
III үе шат	3	7.8	7	18.4	10	26.4
IV үе шат	3	7.8	0	-	3	7.8
<b>Нийт</b>	<b>7</b>	<b>100</b>		<b>100</b>	<b>38</b>	<b>100</b>

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн бодит тоон үзүүлэлтийг үе шатаар нь тооцож үзэхэд I үе шатанд 11 (28,9 хувь), II үе шатанд 14 (36,9 хувь), III үе шатанд 10 (26,4 хувь), IV үе шатанд 3 тохиолдол буюу (7,8 хувь) тус тус оношлогдон тус эмчилгээг хийлгэсэн байна.

Судалгаанд оролцогсдын нас барсан тохиолдлыг үзвэл 1 үе шатанд нас барсан тохиолдол байхгүй байна. Харин II үе шатанд (2,6 хувь), III үе шатанд 3 (7,8 хувь), IV үе шатанд 3 (7,8 хувь) нас барсан байв.

Тус технологийг цаашид өөр төрлийн хавдрын эмчилгээнд хэрэглэх, хэрэглээг нэмэгдүүлэн оношилшоо /биопси/ болон цус алдах үед хэрэглэх хөдөө орон нутагт нэвтрүүлэх, нутагшуулах, хүний нөөцийг бэлдэх зэргээр судалгаа шинжилгээ хийх шаардлагатай. Мөн амьдрах чадварт эмчилгээний аруудын сонголт нь нөөлөлдөг эсэхийг илүү нарийвчлан судлах шаардлагатай.

### Элэг тайрах мэс засал

Бид элэгний хавдраар өвчлөгсдийн амьдрах чадварыг тооцохдоо тухайн эмчилгээ хийлгэн эмнэлэгт хэвтсэн өдөр, элэгний хавдраар нас барсан өдрийг эмчилгээ хийлгэх үеийн хавдрын үе шат, эмчилгээний төрөл, эмнэлгээс гарах үеийн өвчний төгсгөл, нас баралт, амьдрах чадамж, амьдарсан хугацаа зэрэг олон үзүүлэлтээр тооцон судалж шинээр нэвтэрсэн “Бичил долгионоор түлэх эмчилгээний технологи”-ийг аль хэдийн нэвтэрсэн өмнөх технологи болох “Элэг тайрах мэс засал”-тай үр дүн болоод зардлыг харьцуулан судалсан нь манай улсад өмнө нь огт хийгдэж байгаагүй шинэлэг, онцлог давуу талтай судалгаа байлаа.

Бид ХСҮТ-ийн Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын тасагт 2018 оноос элэгний анхдагч өмөн оношоор элэг тайрах мэс засал эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн мэдээллийг ийн Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын тасаг, Статистик, дүн бүртгэлийн алба, нас баралтыг ЭМХТ-ийн АМ-7 бүртгэл ашиглан өвчтөний амьдрах чадамж, үе шат болон амьдарсан хугацаатай уялдуулан судалсан. Өвчтөний амьдарсан хугацааг мэс засалд орсон өдрөөс нас баралт бүртгэгдсэн өдрөөр тооцон авсан.

*Хүснэгт 21. Элэг тайрах мэс заслын дараах зарим үзүүлэлт.*

Он	Хийгдсэн хүний тоо	Хүйс		Өвчний төгсгөл		
		Эр n (%)	Эм n (%)	Үзүүлэлт	n (тоо)	Хувь (%)
<b>2018</b>	261	156 59,8	105 40,2	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	14 245 2	5,4 93,9 0,8
<b>2019</b>	185	119 64,3	66 35,7	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	2 183 -	1,1 98,9 -
<b>2020</b>	193	114 59,1	79 40,9	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	1 189 3	0,5 97,9 1,6
<b>2021</b>	139	88 63,3	51 36,7	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	24 114 1	17,3 82,0 0,7
<b>2022 I улирал нийт</b>	42	24 57,1	18 42,9	Эдгэрсэн Сайжирсан Хэвэндээ	21 21 -	50 50
	820	<b>501</b>	<b>319</b>			

Элэг тайрах мэс засалд 2018-2022 оны I улирлын байдлаар нийт 820 өвчтөн орсон байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон уг мэс засал эмчилгээг хийлгэсэн байна.


*Хүснэгт 22. Элэг тайрах эмчилгээний амьдрах чадамжийг зарим үзүүлэлтээр*

Үзүүлэлт	Мэс засал хийлгэсэн хүн (n)	Дундаж амьдарсан хугацаа /сараар/	Амьдрах /хувиар/			P утга	
			1 хүртлэх жил	1 жил	3 жил		
<b>Нийт</b>	261	29,8	71,9	69,7	63,2	-	
<b>Хүйс</b>	Эр	144	28,4				
	Эм	117	31,2				
<b>Үе шат</b>	1	3	52 сар ба түүнээс дээш	100	100	100	<0.05
	2	104	29,9	86,4	72,1	62,1	
	3	136	23,6	67,8	56,9	50,3	
	4	17	20,8	90,2	25	0	

Элэгний хавдрын оношоор элэг тайрах мэс засалд орсон өвчтөнүүдийн дундаж амьдарсан хугацаа 29,8 сар байв. Амьдрах чадамж 1 хүртлэх жил 71,9 хувь, 1 жил 69,7 хувь, 3 жил 63,2 хувь байлаа.

Хавдрын үе шатаар амьдрах чадамжийг үнэлэхэд I шатанд оношлогдон элэг тайрах мэс засал хийлгэсэн өвчтөний 3 жил амьдрах чадамж 100 хувь байсан бол( 2022 оны 4-р сарын байдлаар нас баралт тохиолдоогүй байна) III шатанд оношлогдон мэс засал хийлгэсэн өвчтөнүүдийн амьдрах чадамж 50,3 хувьтай байна.

R studio программ ашиглан регрессийн шинжилгээ хийн статистик үнэн магадлалын ялгааг  $p < 0.05$  гэж тооцон дүгнэхэд P утга  $< 0,05$  буюу харьцуулж буй бүлгүүд хоорондын ялгаатай гэсэн үр дүн гарсан. Энэ нь тухайн эмчилгээний үр дүнд хавдрын үе шат нөлөөлж байна гэсэн таамаглалыг батлан харуулсан.




*Зураг 6. MWA болон элэг тайрах мэс заслын дараах өвчний төгсгөл*

MWA эмчилгээг Элэгний хавдартай хэсгийг тайрах мэс засал эмчилгээний дараах өвчний эдгэрэлтийн үзүүлэлттэй харьцуулан судлахад MWA эмчилгээний дараах өвчтөний биеийн байдал сайжирсан 81,9 хувь бол элэг тайрах эмчилгээний дараа биеийн байдал сайжирсан хувь 70,4 хувь байна.

Харин эдгэрэлтийн хувь элэг тайрах мэс засал эмчилгээний хувь MWA түлэх эмчилгээнээс 7,3 хувиар өндөр байна.

Мэс заслын дараах хүндрэл нь эмнэлгийн ор хоногийг 7-10 хоногоор нэмэгдүүлдэг байна.



Зураг 7. MWA болон элэг тайрах мэс заслын дараах хүндрэл

Судалгаанд оролцогсдын эмчилгээний дараах хүндрэлийг судлан үзэхэд MWA түлэх эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдэд хагалгааны дараах хүндрэл тохиолдоогүй бол элэг тайрах мэс заслын дараа будад эрхтэн системээс гарах хүндрэл 1,9 хувьтай, шархны үрэвсэлт нэвчдэс 1,5 хувьтай, цус алдалт 0,8 хувьтай тохиолдсон байна.

## **Б. Технологийн зардлын шинжилгээ**

Бид судалгаандаа Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 264/А/293 “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” тушаал болон ХСҮТ-ийн Ерөнхий захирлын А/56 тоот” Жагсаалт, журам батлах тухай” тушаал, ЭМДҮЗ-ийн 01,02-р тогтоолыг ашиглан тооцоолол хийлээ.

Хүснэгт 23. Шинэ технологи нэвтрүүлэлтийн зардал

Тусламж үйлчилгээ	Хүний нөөц бэлтгэх зардал	Тоног төхөөрөмжийн зардал	Нийт
MWA буюу бичил долгионоор түлэх эмчилгээ	Санчир-Ундрах ХХК-аас БНХАУ-с эмч урин ХСҮТ-д 5 хүнд мэс засал хийсэн. ХСҮТ-ийн эмч нарыг 4 удаа БНХАУ-руу сургалтад хамруулсан. <b>Зардал 10.000 \$</b>	ECO MICROWAVE аппарат <b>25.000\$</b> дол Тээврийн зардал <b>2500\$</b> дол Гааль 15,5% <b>Нийт 31.625\$</b> -Бичил долгион үүсгэгч аппарат <b>7.000\$</b>	<b>101.148.750₮</b> /2018 оны ханшаар бодов./

MWA мэс засал эмчилгээг шинээр нэвтрүүлэхэд хүний нөөцийг мэргэшүүлэх, сургах болон тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд 101,148,750 ₮ төгрөгийн зардал гарсан байна.

Хүснэгт 24. MWA мэс засал эмчилгээний зардал

№	Үзүүлэлт	Үйлдэл	ЭМД-аас төлөх	Иргэнээс төлөх	Нийт төлбөр
1.	Багаж хэрэгсэл	Зүүний сет <b>2.250.000₮</b> /Хавдрын хэмжээ том үед 2 зүүгээр зэрэг түлдэг/ Үйлдлийн код: 99.86	2,557,000₮	-	<b>2,557,000</b>
2.	Эм, бүтээгдэхүүн	эмийн Тайвшруулах, өвчин намдаах, цус алдалтын эсрэг эм Шаардлагатай үед нойрсуулах, мэдээ алдуулах эм тариа	100,000	-	<b>100,000</b>
3.	Тусгай засвар үйлчилгээ	орчны шаардахгүй	-	-	-
4.	Тусгай хамгаалах хэрэгсэл	хувийн шаардахгүй	-	-	-
5.	Ариутгал халдваргүйжүүлэлт	1 удаагийн зүү тул шаардлагагүй	-	-	-
6.	Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	Санчир-Ундрах ХХК-аас улиралд 1 удаа хэвийн үйл ажиллагаа хангах хяналт, засвар үйлчилгээ хийгддэг. Улсын төсөвт тусгагдаагүй.	-	-	-
Нийт					<b>2,657,000 төг</b>

Тус мэс заслын багаж хэрэглэгдэхүүн болох түлэх зүү нь 2,250,000 төгрөг бол мэс заслын ЭМД-аас нэхэмжлэх мөнгөн дүн 2,557,000 төгрөг.

ХСҮТ-ийн Ангиографийн тасаг нь 16 ортой үүнээс төлбөрт орны тоо 3 байдаг бол Элэг, цөс нойр булчирхайн мэс заслын тасаг нь 15 ортой ба төлбөртэй орны тоо 2 байдаг байна.

*Хүснэгт 25. MWA болон элэг тайрах эмчилгээний дундаж ор хоног, ор хоногийн төлбөр*

Эмчилгээ	Тоо	Дундаж ор хоног	Ор хоногийн төлбөр /даатгалтай ЭМД-аас төлөгдөнө/ иргэдэд төлбөр	Ор хоногийн дундаж зардал
MWA түлэх эмчилгээ	38	1,6	30,000	30,000-60,000
Элэг тайрах мэс засал	261	10,6	30,000	318,000

MWA Бичил долгионоор түлэх мэс засал эмчилгээний дундаж ор хоног 1,6 бол элэг тайрах мэс засал эмчилгээний дундаж ор хоног 10,6 байна.

#### **Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлага**

Бид судалгаандаа ХСҮТ-д 2018 онд Бичил долгионоор түлэх MWA эмчилгээ хийлгэсэн 38 үйлчлүүлэгчдээс 9 үйлчлүүлэгчийг сонгон биеийн байдлыг утсаар асуун ярилцлага хийсэн.

*Хүснэгт 26. Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагын үр дүн*

Үзүүлэлт	Хүний тоо	Тайлбар
Биеийн байдал сайжирсан	5	Биеийн байдал сайжирч эдгэсэн, ямар нэгэн зовуурь байхгүй, эмчийн хяналтад байх шаардлагагүй гэж хариулсан.
Биеийн байдал хэвэндээ	2	Биеийн байдал хэвэндээ үе үе хатгах зэрэг зовуурьтай, эмчийн хяналтад байдаггүй.
Биеийн байдал муудсан	2	Биеийн байдал муудсан, ХСҮТ-д эмчийн хяналтад байдаг.
Зовиургүй	5	-
Хатгах, зовуурьтай	2	-
Эмчийн хяналтад байгаа	2	-
Эмчийн хяналтад байдаггүй	7	-
Эмнэлгийн ор хоног	9	Тус 9 үйлчлүүлэгчийн дундаж ор хоног 1,6
Эмчилгээний төлбөр	9	ЭМД-аас төлбөр хийгдсэн.

#### **Хавдрын хяналт, эргэн дуудах тогтолцоо**

Хорт хавдрын бүртгэл тандалтыг Хавдар судлалын үндэсний төвийн Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн алба нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж хорт хавдрын өвчлөл, нас баралтын жилийн тайланг Эрүүл

мэндийн хөгжлийн төвд мэдээллэн Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Хорт хавдрын өвчлөл, нас баралтын үндэсний хэмжээний мэдээний сан” үүсгэн ажилладаг.

Бид ХСҮТ-д эмчилгээ оношилгоо хийлгэсэн үйлчлүүлэгчдийн одоогийн биеийн байдлын талаарх мэдээллийг тухайн тасгийн эмч, эмнэлгийн ажилчдаас асуухад Чанарын алба болон статистик дүн бүртгэлийн албанаас авна, манайхаас тийм мэдээлэл гарахгүй гэж хариулсан. Гэвч Статистик дүн бүртгэлийн албанаас манайх сайдын тушаалын дагуу үйлчлүүлэгчийн өвчний түүхээс мэдээллийг авч H-info program-д шивж оруулдаг. Үйлчлүүлэгчийн одоогийн биеийн байдал болон нас барсан мэдээлэл тасгаас болон Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн албанаас хяналт хийгддэг тул тус мэдээллийг өгөх боломжгүй гэж хариулсан.

Харин Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн албанаас: Манай алба нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр IARC /offline/ program болон Screening.gov.mn /online/ програм гэсэн батлагдсан 2 программаар ЭМС-ын A/611 тушаалын дагуу AM-5 Хорт хавдрыг мэдээлэх хуудсын дагуу мэдээний сан үүсгэн 21 аймаг 9 дүүргээс мэдээ авч нэгтгэн дүгнэж ЭМХТ-рүү хүргүүлдэг. Тус мэдээний сан нь:

1. Улсын хэмжээнд хорт хавдрын шинэ тохиолдлын тоо
2. Улсын хэмжээнд хорт хавдрын шалтгаанд нас баралтын тоо
3. Үлдсэн буюу одоо амьд байгаа хүмүүсийг хяналтад байгаа өвчлөгсдийн тоо/ хяналтын мэдээний тоо / гэсэн мэдээний сан үүсгэн мэдээлдэг.

Хяналтын мэдээний сан нь амьд байгаа хүмүүсийн тоо болохоос өвчлөгсдийн эмчилгээ, оношилгооны дараах хяналт хийгдэж буй хүмүүсийн тоо болон мэдээлэл биш юм.

*Шигтгээ ,,,*

*Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн алба гэсэн нэртэй ч тандалт, эрт илрүүлгийн мэдээ алга. Бүртгэлийн хэдэн тоотой л сууж байна. Улсын хэмжээнд хавдар оношлогдсон өвчтөнүүдийн хяналтыг хийж болдог, нэг дор мэдээллээр зэрэг хангах боломжтой, эмчилгээ, оношилгоо, шинжилгээний хариу нэг дор байрласан программтай болоод хавдрын хяналт хийгддэг болчихвол мөрөөдөл биеллээ л гэсэн үг юм даа...*

*Ярилцлага 11.*

## **БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

1. Монгол оронд элэгний хорт хавдраар өвчлөгсдийн дунд амьдрах чадварын талаар хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд цөөн байсан нь өөрийн орны судлаачдын ижил төстэй судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд бэрхшээлтэй байлаа. ХСҮТ-д эмчилгээ, оношилгоо хийлгэсэн үйлчлүүлэгчдийн эмчилгээний дараах болон эмчилгээний үеийн хяналтын бүртгэл, мэдээллийг цуглуулахад бүрэн бус, ажиллагаа ихтэй, тасаг, алба хоорондын харилцаа, уялдаа холбоо тааруу, дата мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байсан.
2. ХСҮТ-ийн Ангиографийн тасагт 2018 онд Бичил зүүгээр түлэх эмчилгээ хийлгэсэн 38 хүн байсан ба тус 38 үйлчлүүлэгчийн эмчилгээний дараах эргэн хянах

тогтолцоо ойлгомжгүй, эдгээр хүмүүсийн хэд нь амьд, хэд нь нас барсан тухай мэдээллийг ХСҮТ-өөс мэдээллэдэггүй, бүртгэдэггүй байна.

3. MWA Бичил долгионоор түлэх эмчилгээ нь цаг хугацаа бага шаардсан, үйлчлүүлэгчид ээлтэй тэр тусмаа эрт шатандаа оношлогдсон элэгний хавдрыг эмчлэхэд үр дүнтэй, эдийн засгийн хувьд элэг тайрах хагалгаа болон бусад мэс заслуудаас зардлыг хэмнэсэн эмчилгээний технологи байлаа.
4. Улсын хэмжээнд эмчилгээний дараах хяналтыг хийдэг болох, өвчлөгсдийн эмчилгээ, оношилгооны дараах хяналтыг бүртгэн мэдээлэх гарц гаргалгааг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## ДӨРӨВ. ХЭЛЦЭМЖ

1. ХСҮТ-ийн Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанаас шинээр нэвтрүүлсэн технологийн хөтлөлт, мэдээллийг авсан ч эрүүл мэндийн байгууллагуудад шинээр нэвтрүүлсэн технологийн нэгдсэн бүртгэл, маягт байдаггүй, технологийн үнэлгээ хийгддэггүй тул тайланд шинэ технологи нэвтрүүлсэн тасаг, он, технологийн нэр, тухайн технологийг ашиглаж буй зураг зэрэг мэдээлэл л тусгагдсан байсан нь цаашид судалгаа шинжилгээ хийх, технологийг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах, бодлого шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангахад хангалтгүй байна.
2. Шинээр нэвтрүүлсэн технологийн мэдээлэл нэгдсэн байдлаар гардаггүй, тухайн технологийг ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн тоо, эмчилгээ, оношилгооны үр дүн, хяналт хийгддэх эсэх нь тодорхойгүй, өмнөх нэвтэрсэн ижил төстэй технологиос юугаараа онцлог болон давуу талтай эсэх, тухайн технологийг зайлшгүй нэвтрүүлэх эрэлт, хэрэгцээ нь юу болох, технологи нэвтрүүлэхэд гарсан зардал, хүний нөөцийг сургах, мэргэшүүлэхэд гарах зардал зэргийг тайланд тусгаагүй байсан ба мэдээллийн урсгал тодорхойгүй, нэгдсэн сан үүсээгүй, бүртгэх, тайлагнах загвар, заавар, журам тодорхойгүй байсан нь цаашид эрүүл мэндийн технологийг нэгдсэн нэг стандартаар бүртгэн үр дүнг хянах, мэдээллэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.
3. **А. Бичил долгионоор түлэх эмчилгээ MWA** нь өвчтөнд ээлтэй, эмч нарын ажлыг хөнгөвчилсөн, ор хоног ашиглалт богино, хийгдэх хугацаа бага, олон төрлийн эмчилгээнд ашиглах боломжтой технологи ба хавдрын задрал болон цус алдалтад судас бөглөн, цус алдалт зогсоох, эдийн шижилгээ авах зэрэг олон ажилбарт ашиглах боломжтой үр дүн сайтай арга байна. Цаашид Монгол улсад дүрсийн хяналттай мэс заслыг хөгжүүлэх, хөдөө орон нутагт түгээх, дэлгэрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, дүрсийн хяналттай мэс заслыг дүрс оношлогооноос салгах, тогтсон нэршил олгох, бичил долгиогоор түлэх эмчилгээг үргэлжлүүлэн хийж урт болон богино хугацааны дараах амьдрах тавиланг судлах шаардлагатай байна.
4. **ИЦН флюоресценст дүрслэл** нь хэрэглэхэд энгийн, хурдан, харьцангуй хямд өртөгтэй, гаж нөлөө багатай арга бөгөөд дан ганц хэвлийн хөндийн болон элэг цэсний замын хорт хавдрыг эмчлэхэд төдийгүй цэсний замын бүтцийг тодорхойлох, хүндрэлтэй цэсний хүүдий авах мэс заслын үед ихээхэн ач холбогдолтой технологи байна.



Мөн судасны бүтэц болон цөсний замын бүтцийг тодруулан дүрсэлснээр дурангийн мэс засал ба бусад төвөгтэй мэс заслуудын үед давуу талтай юм.

ИЦН флюоресценст дүрслэлийн давуу тал нь тухайн мэс заслын гүйцэтгэл болоод аюулгүй байдлыг нэмэгдүүлж, хавдрын илэрцийг сайжруулснаар өмнөх хагалгаануудын дундаж хугацаа болон цус алдалттай харьцуулахад эерэг үр дүнтэй байсан байна.

Цаашид Монгол улсад ИЦН-ыг эмнэл зүйд нэвтрүүлэх заалтуудыг нэмэгдүүлэхээс гадна давуу болон сул талуудыг илүү тодорхой болгох, ЭМД-д хамруулах шаардлагатай ба тус шинэ тенологийг хэрэглэхэд нэгдсэн удирдамж, стандарт батлуулах шаардлагатай байна.

Тус технологийн хувьд үр дүн нь шууд харагддаг төвөгтэй мэс заслын үед эмчийн ажлыг хөнгөвчилж гүйцэтгэлийг сайжруулдаг, мэс заслын явцад давхар оношилгоо, үйл ажиллагааг үнэлэх боломжтой тул элэгний мэс засал хийгддэг бүх эмнэлгүүдэд нэвтрүүлж болох юм.

5. **Амьд донороос хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээний шинэ технологи** нь эрүүл хүн хагалгаанд орж амьд донор болж байгаа учраас түүнд гарч болзошгүй хүндрэл, сэтгэл зүйн асуудлууд, мөн элэгний үйл ажиллагаа алдагдаж амьдралынхаа төгсгөлийн шатанд орсон хүнийг эмчлэх асар хүнд, цогц хагалгаа бөгөөд донор болон өвчтөний бүх үзүүлэлтийг хянаж байх ёстой маш нарийн технологи байна.
6. Элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих зардлыг дотооддоо барьж 2018-2022 оны I улирлын байдлаар 53 хүний гадаадад хийгдэх нэг хүний мэс заслын зардал 200-400,000,000 төгрөг болох 1,6-2,1 тэр бум төгрөгийг дотоодын эдийн засагт тогтоон барьсан байна. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр гадны орныг зорих урсгал 2018 оноос хойш буурсан эсэхийг судлах, элэг шилжүүлэн суулгах мэс заслын үр дүнг перспектив судалгааны аргаар судлан амьдрах чадамж, чанартай амьдралын жилийг судлах, үр дүнг олон нийтэд мэдээллэх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай.
7. Монгол оронд элэгний хорт хавдраар өвчлөгсдийн дунд амьдрах чадварын талаар хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд цөөн байсан нь өөрийн орны судлаачдын ижил төстэй судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд бэрхшээлтэй байлаа.
8. Бид элэгний хавдраар өвчлөгсдийн амьдрах чадварыг тооцохдоо тухайн эмчилгээ хийлгэн эмнэлэгт хэвтсэн өдөр, элэгний хавдраар нас барсан өдрийг эмчилгээ хийлгэх үеийн хавдрын үе шат, эмчилгээний төрөл, эмнэлгээс гарах үеийн өвчний төгсгөл, нас баралт, амьдрах чадамж, амьдарсан хугацаа зэрэг олон үзүүлэлтээр тооцон судалж шинээр нэвтэрсэн “Бичил долгионоор түлэх эмчилгээний технологи”-ийг аль хэдийн нэвтэрсэн өмнөх технологи болох “Элэг тайрах мэс засал”-тай үр дүн болоод зардлыг харьцуулан судалсан нь манай улсад өмнө нь огт хийгдэж байгаагүй шинэлэг, онцлог давуу талтай судалгаа байлаа.
9. Бид судалгаандаа элэгний хорт хавдрын өвчлөл болон нас баралт хорт хавдраас шалтгаалсан амьдрах чадвар нь хавдрын үе шатаас хамааралтай эсэхийг тодруулж үзэхэд хавдрын үе шатаар амьдрах чадамжийг үнэлэхэд I шатанд

оношлогдон элэг тайрах мэс засал хийлгэсэн өвчтөний 3 жил амьдрах чадамж 100 хувь байсан бол( 2022 оны 4-р сарын байдлаар нас баралт тохиолдоогүй байна) III шатанд оношлогдон мэс засал хийлгэсэн өвчтөнүүдийн амьдрах чадамж 50,3 хувьтай байна.

10. Регрессийн шинжилгээ хийн статистик үнэн магадлалыг дүгнэхэд P утга  $<0,05$  буюу харьцуулж буй бүлгүүд хоорондын ялгаатай гэсэн үр дүн гарсан. Энэ нь тухайн эмчилгээний үр дүнд хавдрын үе шат нөлөөлж байна гэсэн таамаглалыг батлан харуулсан.
11. MWA Бичил долгионоор түлэх эмчилгээ нь цаг хугацаа бага шаардсан, үйлчлүүлэгчид ээлтэй тэр тусмаа эрт шатандаа оношлогдсон элэгний хавдрыг эмчлэхэд үр дүнтэй, эдийн засгийн хувьд зардлыг хэмнэсэн эмчилгээний технологи байлаа. Тус технологийг цаашид өөр төрлийн хавдрын эмчилгээнд хэрэглэх, хэрэглээг нэмэгдүүлэн оношилшоо /биопси/ болон цус алдах үед хэрэглэх хөдөө орон нутагт нэвтрүүлэх, нутагшуулах, хүний нөөцийг бэлдэх зэргээр судалгаа шинжилгээ хийх шаардлагатай. Мөн амьдрах чадварт эмчилгээний аруудын сонголт нь нөөлөлдөг эсэхийг илүү нарийвчлан судлах шаардлагатай.
12. ХСҮТ-д эмчилгээ, оношилгоо хийлгэсэн үйлчлүүлэгчдийн эмчилгээний дараах болон эмчилгээний үеийн хяналтын бүртгэл, мэдээллийг цуглуулахад бүрэн бус, ажиллагаа ихтэй, тасаг, алба хоорондын харилцаа, уялдаа холбоо тааруу, дата мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байсан.
13. IARC /offline/ program нь offline учраас 21 аймаг 9 дүүрэгт тухайн өвчтөний биеийн байдлыг хянан тус програмд оруулах боломжгүй. Иймээс эдгээр программуудыг нэгтгэх эсвэл хооронд нь хөрвүүлж болдог эмчилгээ хяналтын сан үүсгэх эсвэл IARC /offline/ program-ийг online болгон улсын хэмжээнд хавдар судлаач эмч нар хавдар бүртгэгч, хавдрын эмч нарт эрхийг нь нээж өгөн эмчилгээний хяналтыг хийдэг болох, өвчлөгсдийн эмчилгээ, оношилгооны дараах хяналтыг бүртгэн мэдээлэх гарц гаргалгааг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

### **Бодлогын түвшинд:**

1. Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлсэн илрүүлэг, оношилгоо, эмчилгээний технологийг бүртгэх албан ёсны маягт бий болгон ЭМБ-аас мэдээлэл цуглуулж, улсын хэмжээний бүртгэл мэдээллийн системийг бий болгох.
2. Шинэ технологийн үр ашиг, үр нөлөөний судалгаа хийх, тайлагнах чиглэлээр ЭМБ-ын хяналт, шинжилгээ үнэлгээний болон мэргэжлийн багийг бүрдүүлэх, арга зүйгээр хангах.
3. Цаашид төрөлжсөн мэргэжлийн тэргүүлэх, хэрэгцээт чиглэлээр Монгол улсад шинээр нэвтрүүлэх, нутагшуулах шаардлагатай эмнэлэгийн тусламж (оношилгоо, эмчилгээн)-ийн жагсаалтыг мэргэжлийн багтай хамтран шинэчлэн тогтоож, салбарын бодлогод тусган, хэрэгжилтийг хангах.

### **Эрүүл мэндийн байгууллагын түвшинд:**

1. Тухайн эмнэлэг, нэгж дээр шинээр нэвтрүүлсэн технологийг бүртгэх, мэдээлэх байгууллага дахь урсгалыг тодорхой болгон нэгжүүдийн уялдаа, чиг үүргийг тодорхой болгох.

2. Шинэ технологийн үнэлгээ, үр дүнг даган судлах, нотолгоо бүрдүүлэх буюу эргэн дуудах тогтолцоог бий болгох.
3. ЭМБ-ын тусламж үйлчилгээний хүрээ, чиг үүргийн хүрээнд ашиглаж буй эмчилгээ, оношлогооны технологийн өнөөгийн түвшин, дэлхийн чиг хандлага, шинэ технологийг нутагшуулах чиглэлээр бодлого, төлөвлөгөө боловсруулах ажиллах, үр дүнг тооцох.
4. Шинэ технологийн зардал, үр ашиг, үр нөлөөний судалгааг тогтмол хийх.

## **ЗУРГАА. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

1. ЭМХТ-д шинээр нэвтрүүлсэн илрүүлэг, оношилгоо, эмчилгээний шинэ технологийг бүртгэх албан ёсны маягт байхгүй ба МИА-ны үнэлгээ болон ЭМЭЗБСА-ны шинэ технологийн мэдээлэл, тайлан, дүн шинжилгээ нь ЭМТҮ хийхэд хангалтгүй байна.
2. ХСҮТ-д элэгний хавдрын мэс засалд шинээр нэвтрүүлсэн технологиуд нь ач холбогдол сайтай орчин үеийн технологиуд байна. Цаашид Монгол улсад хавдрын мэс заслыг хөгжүүлэх, хөдөө орон нутагт түгээх, дэлгэрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, эмчилгээг үргэлжлүүлэн хийж урт болон богино хугацааны дараах амьдрах тавиланг судлан үр дүнг мэдээллэж байх шаардлагатай байна.
3. MWA Бичил долгионоор түлэх эмчилгээ нь цаг хугацаа бага шаардсан, үйлчлүүлэгчид ээлтэй тэр тусмаа эрт шатандаа оношлогдсон элэгний хавдрыг эмчлэхэд үр дүнтэй, эдийн засгийн хувьд элэг тайрах хагалгаа болон бусад мэс заслуудаас зардлыг хэмнэсэн эмчилгээний технологи байлаа. Улсын хэмжээнд эмчилгээний дараах хяналтыг хийдэг болох, өвчлөгсдийн эмчилгээ, оношилгооны дараах хяналтыг бүртгэн мэдээлэх гарц гаргалгааг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Олон улсад хийгдсэн судалгааны ажил:**

Олон улсад хийгдсэн Бичил долгионоор түлэх эмчилгээний дараах 1,3 болон 5 жилийн амьдрах чадамжийн судалгаанд:

Судалгаа хийгдсэн газар – Хятад

- Судалгаанд нийт 1007 эмчлүүлэгч хамрагдсан

Элэгний анхдагч хавдрын үед:

- 1-жилийн дараа 91.2%
- 3-жилийн дараа 72.5%
- 5-жилийн дараа болон 59.8%

Элгэнд үсэрхийлсэн хавдрын үед:

- 1-жилийн дараа 73%
- 3-жилийн дараа 30%
- 5-жилийн дараа 16% байсан судалгааны үр дүн гарсан байна.

Солонгос улсын Сөүлийн их сургуульд хийгдсэн Элэгний анхдагч өмөнгийн үед хийгдсэн элэг тайрах эмчилгээний дараах амьдрах чадамж тодорхойлсон судалгаанд:

<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2687566/#:~:text=In%20this%20study%2C%20the%201,%2C%20and%2050.2%25%2C%20respectively.>

Амьдрах чадамж

- 1-жилийн дараа 85,7%
- 3-жилийн дараа 69.8%
- 5-жилийн дараа болон 57.0% гэсэн судалгааны үр дүн гарсан байна.

## Ном зүй

1. Cost-Effectiveness Analysis of Local Ablation and Surgery for Liver Metastases of Oligometastatic Colorectal Cancer.  
<https://www.mdpi.com/2072-6694/13/7/1507/htm>
2. Cost-Effectiveness Analysis of Local Ablation and Surgery for Liver Metastases of Oligometastatic Colorectal Cancer. <file:///C:/Users/dell/Downloads/cancers-13-01507.pdf>
3. The Actual Five-year Survival Rate of Hepatocellular Carcinoma Patients after Curative Resection  
<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC2687566/#:~:text=In%20this%20study%2C%20the%201,%2C%20and%2050.2%25%2C%20respectively>
4. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2021.ЭМХТ
5. Эрүүл мэндийн үндэсний тооцоо. ЭМХТ
6. “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” үндэсний хөтөлбөр.  
Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл ихээхэн хийгдэн шинэ дэвшилтэт техник, технологи хурдацтай нэвтэрч байгаагийн хэрээр оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн бүтэц, үйл ажиллагаа улам бүр нарийсаж байгаа тул хүний нөөцийн мэдлэг чадвар, хүрэлцээ, үйл ажиллагааг ханган ажиллах шаардлага тулгарч байна. Үүний сацуу эрүүл мэндийн салбарын төрөл бүрийн мэргэжлийн нарийсалт ба эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийн мэдлэг, үйл ажиллагааны ялгарал, ялангуяа мэдлэгийн талбар дахь өргөжилт болон практик дахь хэрэглээний хүрээ өдөр ирэх тутам өргөжин тэлсээр байна.

2021 оны байдлаар Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 1533 их эмч, 2256 сувилагч, 725 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан ажиллаж байна.

Иймээс Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, эрэлт хэрэгцээнд нийцсэн тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн тогтолцооны нэг гол багана болох эрүүл мэндийн салбарт ажиллагсад, хүний нөөцийн хангамж, ачаалал ихээхэн чухал ач холбогдолтой байгаа тул өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтыг хүний нөөцийн хангамж, хэрэгцээ, ачаалалтай нь уялдуулан судлах, Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтны хүний нөөцийн асуудалд дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн хангамж, ачааллыг тодорхойлон цаашид нэгдсэн төлөвлөлт хийх зайлшгүй шаардлага тулгараад байна.

## **1.2 ЗОРИЛГО**

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд ашиглаж буй өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтыг хүний нөөцийн хангамжтай нь уялдуулан судлах

## **1.3 ЗОРИЛТ**

1. Оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй хүний нөөцийн хангамж, хэрэгцээ, ачааллыг судлах
2. Өндөр өртөг бүхий оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээг түүний төрлөөр, төв эмнэлгээр судлах

## **1.4 ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**


Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн асуудалд дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн хангамж, хэрэгцээг тодорхойлон цаашид нэгдсэн төлөвлөлт хийх, хэрэгцээг хангахад нотолгоот мэдээлэл болно.

## **1.5 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- Судалгааны арга аргачлалыг багаараа боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн судалгааг эхлүүлсэн
- Судалгааны арга аргачлалыг 2022 оны 9-10 сард боловсруулан батлуулж 11 сард дата мэдээлэл цуглуулан судалгааны тайланг 12 сард бичиж гүйцэтгэсэн.
- Энэхүү судалгаанд Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.
- Судалгааны үр дүн хэсэг нь 3 дэд бүлэгтэй ба А дэд бүлэгт Хүний нөөцийн хангамж, Б дэд бүлэгт Хүний нөөцийн ачаалал, В. Оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалт гэсэн бүлгүүдээс тогтоно.

## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ЗАГВАР

### 2.1 СУДАЛГААНЫ ЗАГВАР



Зураг 1. Судалгааны загвар

### 2.2 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Баримтын судалгаанд Өндөр өртөг бүхий оношилгооны тоног төхөөрөмжтэй ЭМЯ-ны харъяа төрөлжсөн төв, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ, ижил чиг үүрэг бүхий хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдийн статистик мэдээ, 2020-2022.11 сар хүртэлх хугацааны хүний нөөцийн тайлан мэдээг болон өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын тайлан мэдээг хамруулав.

Өндөр өртөгтэй оношилгоонд ЭМДҮЗ-ийн 2022 оны 1-р тогтоолд заасан MRI оношилгоо, КТ оношилгоо, Дурангийн оношилгоо, Дурангаар хийх ажилбар, Судсан дотуур хийгдэх оношилгооны ажилбар, Цөмийн оношилгоо, ПЭТ-КТ оношилгоо, лабораторийн оношилгоо, шинжилгээнүүдийг хийдэг MRI, Рентген, ЭХО, Дурангийн иж бүрдэл, Spect/CT, Ангиографийн аппарат, Лабораторийн анализатор зэрэг өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжүүдийг хамруулсан.

Агшингийн судалгаанд Өндөр өртөг бүхий оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй төрөлжсөн төв, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдийн тухайн тассагт ажиллаж буй бүх ажилчдыг сонгон оролцуулав.

### 2.3 СУДАЛГААНД ХАМРАГДАХ НЭГЖ ТҮҮВЭРЛЭЛТИЙН ТОО

#### А. Баримтын судалгааны материал

- Төрөлжсөн төв, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдийн үйл ажиллагааны тайлан
  - Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжөөр үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн 3 жилээр
  - Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжүүдийн мэдээлэл

- “Эрүүл мэндийн үзүүлэлт - 2021” ЭМХТ

## Б. Судалгаанд хамрагдсан хүний нөөцийн мэдээлэл

Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдийн өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажилладаг 5 тасгийн 514 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд судалгаанд хамрагдсан. Үүнээс их эмч 195, сувилагч 50, техникч 121, оператор инженер 6, био-анагаахын мэргэжилтэн 12, лаборант 103, бусад 26 эмч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн.

*Хүснэгт 1. Судалгаанд хамруулсан эрүүл мэндийн байгууллагууд*

Төрөлжсөн төв, тусгай мэргэжлийн төвүүд,	БОЭТ-үүд	Хувийн хэвшлийн ЭМБ
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	Мөнгөн гүүр эмнэлэг
Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	
Улсын гуравдугаар төв эмнэлэг	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	
Гэмтэл согог судлалын үндэсний төв	Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	
Хавдар судлалын үндэсний төв		
Халдварт өвчин судлалын үндэсний төв		
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв		
7	4	1
<b>Нийт 12</b>		

*Хүснэгт 2. Судалгаанд хамруулсан тасаг, нэгж, тоног төхөөрөмж, хүний нөөц*

№	Тасаг, нэгж	Тоног төхөөрөмж	Хүний нөөц
1.	Дүрс оношилгооны тасаг	СТ MRI Рентген ЭХО	Тухайн тасаг нэгжид ажиллаж буй бүх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд
2.	Дурангийн тасаг	Дурангийн иж бүрдэл	
3.	Цөмийн оношилгооны тасаг	Spect/CT	

4.	Ангиографийн тасаг	Ангиографийн аппарат	
5.	Лабораторийн тасаг	<ul style="list-style-type: none"> <li>• Биохимийн анализатор</li> <li>• Цус бүлэгнэлтийн анализатор</li> <li>• Гематологийн анализатор</li> <li>• Шээсний анализатор</li> <li>• Иммунологийн анализатор</li> <li>• Бактериологийн бүрэн автомат анализатор</li> </ul>	

## 2.4 СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД

Судалгааны мэдээллийг тоон болон чанарын аргаар цуглуулав.

А. Баримтын судалгаа:

- Төрөлжсөн төв, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдийн үйл ажиллагааны тайлан.
  - Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжөөр үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн 3 жилээр.
  - Өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжүүдийн мэдээлэл.
- “Эрүүл мэндийн үзүүлэлт - 2021” ЭМХТ

В. Асуумж судалгаа:

- Үйлчлүүлэгчдээс хүний нөөцийн нарийвчилсан судалгааны асуумж 3 бүлэг, 21 асуулт бүхий асуумжаар мэдээлэл цуглуулсан.
- Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнээс 6 асуулт бүхий асуумжаар судалгааны мэдээлэл авсан.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерээс 2 бүлэг 16 асуулт бүхий өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн мэдээллийг цуглуулсан.

## 2.5 СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ АРГА

Мэдээллийг Microsoft Office Excel програм дээр датаг оруулж, ашиглан боловсруулалт хийсэн. Үр дүнгийн үзүүлэлтийг тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн дундаж утга, эзлэх хувь зэргийг харьцуулан гаргаж дескриптив шинжилгээ хийсэн. Үр дүнг хүснэгт, зураг, схемээр харуулан тайланд тусгав.



## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### А. Хүний нөөцийн хангамж


2021 оны байдлаар эрүүл мэндийн салбарт нийт 58.7 мянган ажиллагчид Монгол Улсад оршин суугаа 3.312.3 мянган хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Эрүүл мэндийн ажилчдын тоо сүүлийн 10 жилийн дунджаас 8.3 мянгаар буюу 10 000 хүн амд 13.5-аар, өмнөх онтой харьцуулахад 2.1 мянгаар буюу 10 000 хүн амд 3.6-оор тус тус нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдын 92.6 хувь нь эрүүл мэндийн салбарын, 7.4 хувь нь бусад салбарын эрүүл мэндийн ажилчид эзэлж байна.

Хүснэгт 3. Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын тоо. 2021 он

Мэргэжил	2020	2021
<b>Бүгд</b>	<b>56502</b>	<b>58696</b>
Эмэгтэй	46379	48163
Эрэгтэй	10123	10533
Эмнэлгийн удирдах ажилтан	1277	1320
Эм зүйчид	2639	2913
<b>Их эмч бүгд</b>	<b>12431</b>	<b>12970</b>
Эмэгтэй	9518	9920
Эрэгтэй	2913	3050
Ерөнхий мэргэжлийн	1973	2198
Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн	7895	8006
Дотрын	1200	1313
Хүүхдийн	725	721
Мэс заслын ба гэмтэл, согог заслын	868	885
Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний	453	489
Эх барих, эмэгтэйчүүд	862	876
Хавдрын	83	85
Мэдрэлийн	378	383
Сэтгэцийн	171	174
Нүдний	182	200
Чих хамар хоолойн	194	216
Арьс харшлын	192	171
Халдвартын	382	369
БЗДХ/ДОХ	16	85
Сүрьеэгийн	120	109
Сэргээн засахын	161	176
Эмгэг судлалын	67	66
Дүрс оношилгооны	420	449
Лабораторийн	227	250


Бусад мэргэжлийн	<b>342</b>	<b>989</b>
Уламжлалт анагаахын	<b>1015</b>	<b>1142</b>
Нүүр амны	<b>1548</b>	<b>1624</b>

2021 оны байдлаар Эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын 82 хувь нь эмэгтэй, 18 хувь нь эрэгтэй байна. Монгол улсын хэмжээнд 12970 их эмч ажиллаж байгаагаас 449 буюу 3,4% хувийг Дүрс оношилгооны эмч, 250 буюу 1.9% хувийг Лабораторийн эмч тус тус эзэлж байна.




*Зураг 2. Оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажиллах хүч.*

Төрөлжсөн төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажиллах хүчний 92,4% нь ажиллаж байна.




*Зураг 3. Ажиллах хүчний хангамж*

Эрүүл мэндийн байгууллагуудын өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажилчдын 37.9 хувийг их эмч, 23,5 хувийг техникч, 20,0 хувийг лаборант, 9.7 хувийг сувилагч, 2.3 хувийг биоанагаахын мэргэжилтэн, 1.2 хувийг оператор инженер тус тус эзэлж байна.




Зураг 4. Ажиллах хүч эмнэлэг, тасгаар

Өндөр өртөгтэй оношилгоо хийж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажиллах хүчийг эмнэлэг тус бүрээр харьцуулан үзэхэд УНТЭ-ийн Радиологийн тасаг болон Лабораторийн тасаг хамгийн их ажиллах хүч, хүний нөөцтэй байна.




Зураг 5. Хүний нөөцийн зэрэн, цол

Судалгаанд оролцогсдын 24% хувь нь Тэргүүлэх зэрэгтэй, 15.5% хувь нь Ахлах зэрэгтэй, 17.2% хувь нь магистрын зэрэгтэй бол үлдсэн 43.3 хувь нь ямар нэг зэрэг, цолгүй байна.




*Зураг 6. Ажиллах хүчний насны бүлэг*

Тус судалгаанд оролцосдыг насыг бүлэглэн авч үзэхэд хамгийн өндөр буюу 31 хувийг 30-39 насны ажиллагсад, 29.3 хувийг 29 хүртлэх насны ажиллагсад, 20.6 хувийг 40-49 насны ажиллагсад, 6.8 хувийг 50-54 насны ажиллагсад, 1.7 хувийг 55-60 насны ажиллагсад эзэлж байна.



*Зураг 7. Ажиллах хүчний насны бүлэг тасгаар*

Харин судалгаанд оролцогчдын насны бүлгийг 2 тасгаар харьцуулахад Лабораторийн тасагт ажиллаж буй 29 хүртлэх насны хүний нөөц хамгийн өндөр 56.5 хувийг эзэлж байсан бол Радиологийн тасагт ажиллаж буй 29 хүртлэх насныхан 12.5 хувийг эзэлж байна. 55-60 насны ажиллаж буй хүний нөөц Радиологийн тасагт 4.2 хувийн эзэлж байгаа бол Лабораторийн тасагт 55-60 насны хүний нөөц ажиллаагүй байна.



*Зураг 8. Ажиллах хүчийг ажилсан жилээр*

Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хамгийн өндөр буюу 34.5 хувь нь 11-20 жил ажилласан бол 25.9 хувь нь 1-5 жил, 15.5 хувь нь 6-10 жил ажилласан туршлагатай бол 31-ээс дээш жил ажилласан хүний нөөц судалгаанд орлцогчдын 6.9 хувийг эзэлж байна.

## **Б. Хүний нөөцийн ачаалал**

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ГССҮТ, ХСҮТ, ЭХЭМҮТ-ийн өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээрх өдөрт, сард, жилд үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн дунджийг тоног төхөөрөмж бүрээр тооцоолов.

*Хүснэгт 4. Үйлчлүүлэгчийн тоо*

№	Тоног төхөөрөмжийн нэршил	Үйлчлүүлэгчийн тоо				
		Өдөрт	Сард	Эхний 10 сар /2022 /	2021	2020
1.	Ангиографийн аппарат	14	395	3946	3895	4243
2.	Соронзон резонанст томографийн аппарат	9	250	2500	2134	1843
3.	Компьютерт томографийн аппарат	35	1036	10356	9396	5678
4.	Рентген аппарат	117	3500	34997	31246	20448
5.	Эхо аппарат	60	1784	17838	18509	16330
6.	Дурангийн төхөөрөмж	24	701	7008	3915	4564
7.	Биохимийн бүрэн	143	4274	42741	42936	37752


	автомат анализатор					
8.	Бүлэгнэлтийн шинжилгээний анализатор	45	1362	13623	17465	11160
9.	Иммунологийн анализатор	41	1221	12210	14891	13204
10.	Цусан дахь хийг хэмжих анализатор	9	259	2590	3552	13542

2022 оны эхний 10 сарын байдлаар судалгаанд хамрагдсан ЭМБ-уудын дүрс оношилгооны тоног төхөөрөмжүүдээс Рентген аппарат өдөрт, сард, жилд хамгийн их үйлчлүүлэгчтэй байгаа бол Лабораторийн оношилгооны тоног төхөөрөмжүүдээс Биохимийн бүрэн автомат анализатор өдөрт, сард, жилд хамгийн их үйлчлүүлэгчтэй байдаг байна.

*Хүснэгт 5. Үйлчлүүлэгчийн байршил*


	Үйлчлүүлэгчийн байршил					
	2020		2021		2022	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Ангиографийн аппарат	2970	1273	2727	1169	2762	1184
Соронзон резонанст томографийн аппарат	1290	553	1494	640	1750	750
Компьютерт томографийн аппарат	3975	1703	6577	2819	7249	3107
Рентген аппарат	14314	6134	21872	9374	24498	10499
Эхо аппарат	11431	4899	12956	5553	12487	5351
Дурангийн төхөөрөмж	3195	1369	30055	12881	4906	2102
Биохимийн бүрэн автомат анализатор	26426	11326	30055	12881	29919	12822
Бүлэгнэлтийн шинжилгээний анализатор	7812	3348	12226	5240	9536	4087
Иммунологийн анализатор	9243	3961	10424	4467	8547	3663
Цусан дахь хийг хэмжих анализатор	9479	4063	2486	1066	1813	177

2022 оны эхний 10 сарын байдлаар судалгаанд хамрагдсан ЭМБ-уудад Улаанбаатар хот дахь үйлчлүүлэгчийн тоо хөдөө орон нутгийн үйлчлүүлэгчдээс их байна.




*Зураг 9. Хүний нөөцийн хангамж*

Судалгаанд оролцогчдийн 92,3% нь тухайн оношилгоо, шинжилгээг хийж гүйцэтгэхэд хүний нөөц хангалтгүй буюу дутмаг, 7,7 хувь нь хангалттай байж чаддаг гэж хариулсан байна.




*Зураг 10. Ажиллах хүчний илүү цагаар ажиллах байдал*

Тухайн тасагт ажиллаж буй хүний нөөцөөс илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэхийг тодруулахад 89.7 хувь нь илүү цагаар ажиллах шаардлагатай байдаг гэж хариулсан бол 10.3 хувь нь үгүй буюу илүү цагаар ажиллах шаардлага гардаггүй гэж хариулсан байна.



*Зураг 11. Илүү цагаар ажиллах шаардлагатай нөхцөл*


Илүү цагаар ажиллах шаардлагатай байдаг гэж хариулсан хүний нөөцийн 89.7 хувиас ямар үед илүү цагаар ажиллах шаардлага тулгардаг талаар тодруулахад 8.2 хувь нь Баяр ёслолын үеэр, 34.2 хувь нь Хүний нөөц дутагдалтай үед, 57.5 хувь нь үйлчлүүлэгч ихтэй үед гэж хариулсан байна.



*Зураг 12. Ажиллах хүчний дутагдал мэргэжлээр*

Хүний нөөцийн дутагдлыг мэргэжлээр ангилж үзэхэд 38.3%-ийг Лаборант дутагдалтай, 21.3 % хувийг сувилагч, 12.8% хувийг техникч дутагдалтай гэж хариулсан байна.






*Зураг 13. Ажиллах хүчний дутагдал эмнэлгээр*


УХТЭ оношилгооны тоног төхөөрөмжүүд дээр ажиллах хүний нөөц 100% буюу бүх тоног төхөөрөмж дээр дутагдалтай гэсэн бол УГТЭ тоног төхөөрөмжийн 42.8% -д нь хүний нөөц дутагдалтай, ХСҮТ 14.2%-д нь хүний нөөц дутагдалтай, харин УНТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ бүх төхөөрөмж дээр хүний нөөцийн дутагдал байхгүй гэж хариулсан байна.

## **В. Оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглал**



*Зураг 14. Оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хувь*

Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хувь 95.8% хувьтай байна.



*Зураг 15. Тоног төхөөрөмжийн ашиглагдахгүй байгаа шалтгаан*

Эрүүл мэндийн байгууллагуудад өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хувь 95.8% хувьтай байгаа бол ашиглагдахгүй байгаа (4.2% хувь) шалтгааны 20% хувийг ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмж, 40% хувийг программын гэмтэлтэй тоног төхөөрөмж, мөн үлдсэн 40 % хувийг эвдэрсэн тоног төхөөрөмжүүд эзэлж байна.

## **ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ**

- 2021 оны байдлаар Эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын 82 хувь нь эмэгтэй, 18 хувь нь эрэгтэй байна. Монгол улсын хэмжээнд 12970 их эмч ажиллаж байгаагаас 449 буюу 3,4 хувийг Дүрс оношилгооны эмч, 250 буюу 1.9 хувийг Лабораторийн эмч тус тус эзэлж байна.
- Төрөлжсөн төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажиллах хүчний 92,4% нь ажиллаж байна.
- Эрүүл мэндийн байгууллагуудын өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажилчдын 37.9 хувийг их эмч, 23,5 хувийг техникч, 20,0 хувийг лаборант, 9.7 хувийг сувилагч, 2.3 хувийг биоанагаахын мэргэжилтэн. 1.2 хувийг оператор инженер тус тус эзэлж байна.
- Судалгаанд оролцогсдын 24% хувь нь Тэргүүлэх зэрэгтэй, 15.5% хувь нь Ахлах зэрэгтэй, 17.2% хувь нь магистрын зэрэгтэй ажиллах хүч эзэлж байна.
- Тус судалгаанд оролцогсдыг насыг бүлэглэн авч үзэхэд хамгийн өндөр буюу 31 хувийг 30-39 насны ажиллагсад, 29.3 хувийг 29 хүртлэх насны ажиллагсад, 20.6 хувийг 40-49 насны ажиллагсад, 6.8 хувийг 50-54 насны ажиллагсад, 1.7 хувийг 55-60 насны ажиллагсад эзэлж байна.
- Судалгаанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хамгийн өндөр буюу 34.5 хувь нь 11-20 жил ажилласан бол 25.9 хувь нь 1-5 жил, 15.5 хувь нь 6-10

жил ажилласан туршлагатай бол 31-ээс дээш жил ажилласан хүний нөөц судалгаанд орлцогчдын 6.9 хувийг эзэлж байна.

- 2022 оны эхний 10 сарын байдлаар судалгаанд хамрагдсан ЭМБ-уудын дүрс оношилгооны тоног төхөөрөмжүүдээс Рентген аппарат өдөрт, сард, жилд хамгийн их үйлчлүүлэгчтэй байгаа бол Лабораторийн оношилгооны тоног төхөөрөмжүүдээс Биохимийн бүрэн автомат анализатор өдөрт, сард, жилд хамгийн их үйлчлүүлэгчтэй байдаг байна.
- Судалгаанд оролцогчдийн 92,3% нь тухайн оношилгоо, шинжилгээг хийж гүйцэтгэхэд хүний нөөц хангалтгүй буюу дутмаг, 7,7 хувь нь хангалттай байж чаддаг гэж хариулсан байна.
- Тухайн тасагт ажиллаж буй хүний нөөцөөс илүү цагаар ажиллах шаардлага гардаг эсэхийг тодруулахад 89.7 хувь нь илүү цагаар ажиллах шаардлагатай байдаг гэж хариулсан бол 10.3 хувь нь үгүй буюу илүү цагаар ажиллах шаардлага гардаггүй гэж хариулсан байна.
- Хүний нөөцийн дутагдлыг мэргэжлээр ангилж үзэхэд 38.3%-ийг Лаборант дутагдалтай, 21.3 % хувийг сувилагч, 12.8% хувийг техникч дутагдалтай гэж хариулсан байна.
- УХТЭ оношилгооны тоног төхөөрөмжүүд дээр ажиллах хүний нөөц 100% буюу бүх тоног төхөөрөмж дээр дутагдалтай гэсэн бол УГТЭ тоног төхөөрөмжийн 42.8% -д нь хүний нөөц дутагдалтай, ХСҮТ 14.2%-д нь хүний нөөц дутагдалтай, харин УНТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ бүх төхөөрөмж дээр хүний нөөцийн дутагдал байхгүй гэж хариулсан байна.
- Төрөлжсөн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хувь 95.8% хувьтай байна.
- Эрүүл мэндийн байгууллагуудад өндөр өртөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтын хувь 95.8% хувьтай байгаа бол ашиглагдахгүй байгаа (4.2% хувь) шалтгааны 20% хувийг ашиглалтын хугацаа дууссан тоног төхөөрөмж, 40% хувийг программын гэмтэлтэй тоног төхөөрөмж, мөн үлдсэн 40 % хувийг эвдэрсэн тоног төхөөрөмжүүд эзэлж байна.

**Хүний нөөцийн судалгааны бүртгэл**

**Судалгааны зорилго:** Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд ашиглаж буй өндөр ертөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтыг хүний нөөцийн хангамжтай нь уялдуулан судлах

**Тус асуумжийг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн бөглөнө үү!!!**

<p><b>1. Эмнэлгийн нэр /Сонгоно уу/</b></p> <p><input type="checkbox"/> Улсын нэгдүгээр төв эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Улсын хоёрдугаар төв эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Улсын гуравдугаар төв эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Гэмтэл согог судлалын үндэсний төв</p> <p><input type="checkbox"/> Хавдар судлалын үндэсний төв</p> <p><input type="checkbox"/> Халдварт өвчин судлалын үндэсний төв</p> <p><input type="checkbox"/> Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв</p> <p><input type="checkbox"/> Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</p> <p><input type="checkbox"/> Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</p> <p><input type="checkbox"/> Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</p> <p><input type="checkbox"/> Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</p> <p><input type="checkbox"/> Интермед эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> УБ Сонгдо эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Мөнгөн гүүр эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Гурван гал эмнэлэг</p> <p><input type="checkbox"/> Бриллиант эмнэлэг</p>	<p><b>2. Тасаг, нэгжийн нэр /Сонгоно уу/</b></p> <p><input type="checkbox"/> Ангиографийн тасаг</p> <p><input type="checkbox"/> Дүрс оношилгооны тасаг</p> <p><input type="checkbox"/> Дурангийн тасаг</p> <p><input type="checkbox"/> Цөмийн оношилгооны тасаг</p> <p><input type="checkbox"/> Лабораторийн тасаг</p> <p><b>3. Тасагт ажиллах шаардлагатай нийт эмч, мэргэжилтний тоо /бичнэ үү/</b></p> <p>.....</p> <p><b>4. Үүнээс одоо ажиллаж байгаа эмч, мэргэжилтний тоо /бичнэ үү/</b></p> <p>.....</p> <p><b>5. Үүнээс:</b></p> <p>Их эмчийн тоо .....</p> <p>Сувилагчийн тоо .....</p> <p>Техникчийн тоо .....</p> <p>Бионанагаахын мэргэжилтэн .....</p> <p>Лаборант .....</p> <p>Оператор инженер .....</p> <p>Бусад .....</p>
---	---

<b>6. Тус тасагт ажиллагсдийн тоо</b>					
<b>2020</b>		<b>2021</b>		<b>2022</b>	
Тасгийн эрхлэгч	Тасгийн эрхлэгч	Тасгийн эрхлэгч	Тасгийн эрхлэгч	Тасгийн эрхлэгч .....	
.....	.....	.....	.....	Их эмчийн тоо .....	
Их эмчийн тоо	Их эмчийн тоо	Их эмчийн тоо	Их эмчийн тоо	Сувилагчийн тоо .....	
.....	.....	.....	.....	Техникчийн тоо .....	
Сувилагчийн тоо	Сувилагчийн тоо	Сувилагчийн тоо	Сувилагчийн тоо	Лаборант .....	
.....	.....	.....	.....	Оператор инженер .....	
Техникчийн тоо	Техникчийн тоо	Техникчийн тоо	Техникчийн тоо	Бусад .....	
.....	.....	.....	.....		
Лаборант	Лаборант	Лаборант	Лаборант		
.....	.....	.....	.....		
Оператор инженер	Оператор инженер	Оператор инженер	Оператор инженер		
.....	.....	.....	.....		
Бусад .....	Бусад .....	Бусад .....	Бусад .....		

**Хүний нөөцийн нарийвчилсан судалгааны асуумж**

**Судалгааны зорилго:** Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ-үүд, хувийн хэвшлийн томоохон эмнэлгүүдэд ашиглаж буй өндөр ертөгтэй оношилгооны тоног төхөөрөмжийн ашиглалтыг хүний нөөцийн хангамжтай нь уялдуулан судлах

**Асуумжийг дараахи тасгуудад ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бөглөнө үү!!!**

- Ангиографийн тасаг
- Дүрс оношилгооны тасаг
- Дурангийн тасаг
- Цөмийн оношилгооны тасаг
- Лабораторийн тасаг

<b>НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ</b>	
<p><b>1.1 Эмнэлэг /сонгоно уу/</b></p> <ul style="list-style-type: none"> <li><input type="checkbox"/> Улсын нэгдүгээр төв эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> Улсын хоёрдугаар төв эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> Улсын гуравдугаар төв эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> Гэмтэл согог судлалын үндэсний төв</li> <li><input type="checkbox"/> Хавдар судлалын үндэсний төв</li> <li><input type="checkbox"/> Халдварт өвчин судлалын үндэсний төв</li> <li><input type="checkbox"/> Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв</li> <li><input type="checkbox"/> Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</li> <li><input type="checkbox"/> Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</li> <li><input type="checkbox"/> Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</li> <li><input type="checkbox"/> Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв</li> <li><input type="checkbox"/> Интермед эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> УБ Сонгдо эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> Мөнгөн гүүр эмнэлэг</li> <li><input type="checkbox"/> Гурван гал эмнэлэг</li> </ul>	<p><b>1.2 Тасаг нэгжийн нэр /сонгоно уу/</b></p> <ul style="list-style-type: none"> <li><input type="checkbox"/> Ангиографийн тасаг</li> <li><input type="checkbox"/> Дүрс оношилгооны тасаг</li> <li><input type="checkbox"/> Дурангийн тасаг</li> <li><input type="checkbox"/> Цөмийн оношилгооны тасаг</li> <li><input type="checkbox"/> Лабораторийн тасаг</li> </ul> <p><b>1.3 Албан тушаал /сонгоно уу/</b></p> <ul style="list-style-type: none"> <li><input type="checkbox"/> Тасгийн эрхлэгч</li> <li><input type="checkbox"/> Их эмч</li> <li><input type="checkbox"/> Бионагаахын мэргэжилтэн</li> <li><input type="checkbox"/> Сувилагч</li> <li><input type="checkbox"/> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч</li> <li><input type="checkbox"/> Лаборант</li> <li><input type="checkbox"/> Оператор, инженер</li> <li><input type="checkbox"/> Бусад</li> </ul>

<input type="checkbox"/> Бриллиант эмнэлэг	
<b>1.4 Овог нэр:</b> ..... .....	<b>1.5 Хүйс:</b> <input type="checkbox"/> эрэгтэй <input type="checkbox"/> эмэгтэй
<b>1.6 Нас /сонгоно уу/</b> <input type="checkbox"/> 29 хүртлэх <input type="checkbox"/> 50-54 <input type="checkbox"/> 30-39 <input type="checkbox"/> 55-60 <input type="checkbox"/> 40-49 <input type="checkbox"/> 61 ба түүнээс дээш	<b>1.7 Мэргэжил:</b> <input type="checkbox"/> Их эмч <input type="checkbox"/> Сувилагч <input type="checkbox"/> Биоанагаахын мэргэжилтэн <input type="checkbox"/> НЭМ-ийн мэргэжилтэн <input type="checkbox"/> Эм зүйч <input type="checkbox"/> Эх баригч, бага эмч <input type="checkbox"/> Лаборант <input type="checkbox"/> Эм найруулагч <input type="checkbox"/> Мэдээлэл технологийн инженер <input type="checkbox"/> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер <input type="checkbox"/> Техникч <input type="checkbox"/> Оператор инженер <input type="checkbox"/> Бусад дээд мэргэжилтэн <input type="checkbox"/> Бусад ажилтан
<b>ХОЁР. БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЭЛ</b>	
<b>2.1 Төгссөн сургууль</b> ..... ..... ..... .....	<b>2.2 Ажилласан жил</b> ..... ..... .....
<b>2.3 Зэрэг, цол</b> ..... ..... ..... ..... ..... ..... ..... .....	<b>2.4 Мэргэшсэн байдал / мэргэшлийн байдлаа он тус бүрээр тоочин бичнэ үү/</b> ..... ..... ..... ..... ..... ..... ..... .....
<b>ГУРАВ. АЖЛЫН АЧААЛАЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАМЖ</b>	
<b>3.1 Ажиллавал зохих цаг /Өдөрт/</b> .....	<b>3.2 Ажилласан цаг /Өдөрт/</b> .....

<p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p>
<p><b>3.3 Үйлчлүүлэгчийн тоо /Цагт/</b></p> <p>.....</p> <p>.....</p>	<p><b>3.4 Үйлчлүүлэгчийн тоо /Өдөрт/</b></p> <p>.....</p> <p>.....</p>
<p><b>3.5 Танд илүү цагаар ажиллах шаардлага гардаг уу?</b></p> <p><input type="checkbox"/> Тийм</p> <p><input type="checkbox"/> Үгүй</p>	<p><b>3.6 Тийм бол хэзээ илүү цагаар ажиллах шаардлага гардаг вэ?</b></p> <p><input type="checkbox"/> Өдөр бүр</p> <p><input type="checkbox"/> Заримдаа</p>
<p><b>3.7 Ямар тохиолдолд илүү цагаар ажиллах шаардлага гардаг вэ?</b></p> <p><input type="checkbox"/> Үйлчлүүлэгч ихтэй үед</p> <p><input type="checkbox"/> Баяр ёслолын үеэр</p> <p><input type="checkbox"/> Хүний нөөц дутагдалтай үед</p>	<p><b>3.8 Тухайн оношилгоо, шинжилгээг хийж гүйцэтгэхэд хүний нөөц хангалттай байж чаддаг уу?</b></p> <p><input type="checkbox"/> Хангалттай байж чаддаг</p> <p><input type="checkbox"/> Хангалтгүй буюу дутмаг</p>
<p><b>3.9 Хангалтгүй буюу дутмаг бол ямар мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байдаг вэ?</b></p> <p><input type="checkbox"/> Их эмч</p> <p><input type="checkbox"/> Сувилагч</p> <p><input type="checkbox"/> Биоанагаахын мэргэжилтэн</p> <p><input type="checkbox"/> Лаборант</p> <p><input type="checkbox"/> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер</p> <p><input type="checkbox"/> Техникч</p>	<p><b>3.10 Та холбогдох утасны дугаараа үлдээнэ үү.</b></p> <p>.....</p>

**Танд баярлалаа!**



## Тоног төхөөрөмжийн бүртгэлийн хуудас

Эмнэлэг: .....

Тасаг: .....

Тоног төхөөрөмжийн төрөл: .....

Нэг. Тоног төхөөрөмжийн бүртгэл											
№	Оноши лгоон ы тоног төхөөр өмжийн нэршил	Марк	Нэвтр үүлсэн он	Ашиг гласан хугацаа	Тус тоног төхөөрөмж өмнө нь ашиглагдаж байсан эсэх /second hand/	Тоног төхөөрөмж ийн өртөг	Нийт тоног төхөөрөмж ийн тоо	Гэмтэлтэй байгаа тоног төхөөрөмж	Илүүдэлтэй байгаа тоног төхөөрөмж	Хүний нөөц дутагдалтай байгаа тоног төхөөрөмж	Ашиглагдахгүй байгаа шалтгаан
1.											
2.											
3.											
4.											
5.											
Хоёр. Тоног төхөөрөмжийн ашиглалт											
№	Тоног төхөөрөмжийн нэршил	Үйлчлүүлэгчийн тоо				Үйлчлүүлэгчийн байршил			Засвар үйлчилгээ тогтмол хийгддэг эсэх	Тоног төхөөрөмжийг ашиглахад тулгамдаж буй асуудал	
		Өд	Са	Жи	2021	202	2020	2021			2022

		өрт	рд	лд /2022 /	0	Хот	Хөдө	Хот	Хөдө	Хот	Хөдө	Тийм		Үгүй	
1.															
2.															
3.															
4.															

**Танд баярлалаа!**

СУДАЛГААНЫ НЭР

ТАРХИНЫ ЦУС ТАСАЛДАХ ХАРВАЛТЫН ЭМГЭГ  
ЗАГВАРТ ХҮДРИЙН ЗААРЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

СУДЛААЧ

Г.РАДНАА

(АУ-ны доктор, Магадлан итгэмжлэлийн  
албаны мэргэжилтэн)

## ТОВЧ ХУРААНГУЙ

**Түлхүүр үг:** хүдэр, хүдрийн заар, тархины ишеми-реперфузийн эмгэг загвар

### НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн улс орнуудын насанд хүрсэн хүн амын дунд тархины судасны өвчин өргөн тархалттай тохиолдож байгаа бөгөөд Монголын насанд хүрсэн 100.000 хүн амын дунд тархины харвалтын давтамж 290, нас баралт 130 тохиолдол бүртгэгдэж байгаа нь бусад орны өвчлөл, нас баралттай харьцуулахад нэн өндөр үзүүлэлт юм. Иймд тархины судасны гаралтай өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэлт нь тулгамдсан асуудал болж буй өнөө цагт гараг адын (саа) өвчний үед өргөн хэрэглэгдэж ирсэн эмийн үнэт түүхий эд болох хүдрийн заарыг судалж үр дүнг тооцох нь чухал ач холбогдолтой гэж үзлээ.

### ХОЁР. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Туршилтын амьтанд үүсгэсэн тархины цус тасалдах харвалтын эмгэг загварын үед уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж ирсэн Монгол орны Баданга хүдэр (*Moschus moschiferus* L.)-ийн заарын үзүүлэх нөлөөг судлах

### ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

Бид судалгааг сорил туршилтын загвараар АШУҮИС, УАУТХ-ийн Эрдэм Шинжилгээний Төвийн эм судлалын лаборатори, ӨМӨЗО-ы Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн Эм зүй, эм судлалын лабораторийг түшиглэн явууллаа. Туршилтад УАУТХ-ийн виварт үржүүлж буй харьцангуй эрүүл 25-33 гр жинтэй 20 толгой эр, эм лабораторийн цагаан хулгана, БНХАУ-ын Ляонин мужийн Шэнжан амьтан үржүүлгийн газраас 180-220 гр жинтэй, 300 толгой, Вистар үүлдрийн эр харх авч ашигласан. Гачууртын Шар хоолойн аманд байрлах УАУТХ-ийн харьяа Хүдрийн эрдэм шинжилгээний станцад үржүүлж буй гирээнээс (эр хүдэр) заарыг саах аргаар авч ямааны хатаасан элгээр баяжуулан судалгааны дээжийг бэлтгэсэн.

Туршилтыг хийхдээ эрүүл хяналт, плацебо, эмгэг хяналт, хүдрийн заар 50 мг/кг, хүдрийн заар 100 мг/кг, нимодипин 10 мг/кг гэсэн бүлгүүдэд хуваан эрүүл хяналтаас бусад бүлэгт тархины дунд артерийг 90 минут бөглөх замаар шигдээс-реперфуз үүсгээд туршилтын бүлэг тус бүрд эмийг 7 хоног амаар өгч үр дүнг тооцлоо. Туршилтын хархны тархины дунд артерийг бөглөх (MCAO/R) замаар үүсгэсэн тархины ишеми-реперфузийн эмгэг загварын үед цусны ийлдэс ба тархины эдэд агуулагдах TNF- $\alpha$ , IL-6, IL-1 $\beta$ , IL-10 үрэвслийн цитокины агууламжийг фермент холбоот урвалын арга, тархины эдэд *BDNF*, *TrkB*, *NGF*, TGF- $\beta$  зэрэг мэдрэлийн эсийн өсөлтийн хүчин зүйлсийн mPHX экспрессийг бодит хугацааны урвуу транскрипцийн полимеразын гинжин урвалын арга, тархины эдийн Arg-1, Iba1, Bcl-2 микроглий эсэд хамааралтай үзүүлэлтүүдийг иммунофлюоресцент гистохимийн

шинжилгээ зэрэг орчин үеийн молекул биологийн аргуудаар тодорхойлж, Монгол орны Баданга хүдрийн заарын үзүүлэх үйлдлийн нөлөөг судаллаа.

## **ДӨРӨВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН**

Туршилтын амьтанд ишеми-реперфуз эмгэг загвар үүсгэснээс хойш 7 хоногийн турш хүдрийн заарыг 50, 100 мг/кг тунгаар уулгахад 3, 7 дахь хоногуудад тунгийн шууд хамааралтай, статистикийн хувьд магадлалтайгаар цусны ийлдсийн IL-1 $\beta$ , TNF- $\alpha$ , IL-6 цитокины агууламж буурч, IL-10 цитокины агууламж ( $p < 0.05$ ) ихэссэн үр дүн гарсан. Харин эмгэг загвар үүсгэснээс хойш 7 хоногийн турш хүдрийн заарыг 50, 100 мг/кг тунгаар уулгахад 3, 7 дахь хоногуудад, статистикийн хувьд магадлалтайгаар тархины эдэд агуулагдах IL-1 $\beta$ , TNF- $\alpha$ , IL-6 цитокины агууламж буурч, IL-10 цитокины агууламж ( $p < 0.05$ ) нэмэгдсэн үр дүн гарлаа.

Бидний судалгаагаар харханд үүсгэсэн тархины ишеми-реперфуз эмгэгийн үед эмгэг хяналтын бүлэгтэй харьцуулахад туршилтын 3 ба 7 дахь хоногт хүдрийн заар 50, 100 мг/кг бүлгүүдийн тархины *BDNF*, *NGF*, *TGF- $\beta$*  нейропротектор факторууд болон *TrkB* рецепторын мРНХ экспресс статистик ач холбогдол ( $p < 0.05$ ) бүхий ялгаатай нэмэгдсэн байна.

Эмгэг загвар үүссэнээс хойш 7 хоногийн турш хүдрийн заарыг 50 мг/кг тунгаар уулган Arg-1, Vcl-2 уургийг хэмжихэд 1 ба 3 дахь хоногт эмгэг хяналтын ба туршилтын бүлэгт ( $p > 0.05$ ) ялгаа илрээгүй, харин 7 дахь хоногт Arg-1, Vcl-2 уургийн илрэл статистикийн ( $p < 0.05$ ) үнэн магадлалтайгаар ихэссэн. Эмгэг хяналт үүссэн бүлэгтэй харьцуулахад хүдрийн заарыг 100 мг/кг тунгаар уулгасан бүлэгт Arg-1 уургийн илрэл 1, 3, 7 дахь хоногт статистикийн үнэн магадлалтайгаар ( $p < 0.001$ ) ихэссэн үр дүн гарсан бол Vcl-2 уургийн илрэл 1 ба 3 дахь хоногт статистик ач холбогдол ( $p < 0.05$ ) бүхий бага зэрэг ихэссэн, харин 7 дахь хоногт статистикийн үнэн магадлалтайгаар ихэссэн үр дүн гарсан. Хүдрийн заарыг өндөр тунгаар буюу 100 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлэгт 1, 3, 7 хоногт Arg-1, Vcl-2 уургийн агууламж нэмэгдсэн.

Тархины ишеми-реперфузийн эмгэг загвар үүсгэх мэс заслын дараа харханд шигдээс үүссэн эсэхийг хөдөлгөөний тестээр үнэлэхэд туршилтын бүлгийн амьтдад их биеийн баруун талд саа үүссэн буюу их тархины зүүн тал бөмбөлөгт шигдээс үүссэн. Хүдрийн заар 50, 100 мг/кг бүлэг болон нимодипин 10 мг/кг бүлгийн 1, 3, 7 хоногийн хархны хөдөлгөөний тестийн үнэлгээг эмгэг хяналтын бүлгийн үнэлгээтэй харьцуулахад статистик ач холбогдол ( $p < 0.05$ ) бүхий ялгаатай үр дүн гарсан. Хүдрийн заар нь 50, 100 мг/кг тундаа тархины шигдээсийн талбайг эмгэг хяналтын бүлэгтэй харьцуулахад 3.3-6.2 дахин ( $p < 0.05$ ) бууруулсан.

## **ТАВ. ДҮГНЭЛТ**

Хүдрийн заар 50, 100 мг/кг тундаа тархины ишеми-реперфузийн эмгэг загварын үед IL-1 $\beta$ , IL-6, TNF- $\alpha$  цитокиныг бууруулан, IL-10 цитокиныг нэмэгдүүлэх замаар үрэвслийн эсрэг үйлдэл үзүүллээ. Мөн *BDNF*, *NGF* нейропротектор

факторууд, *TGF-β* цитокины болон *TrkB* рецепторын мРНХ экспрессийг нэмэгдүүлсэн нь Монгол орны баданга хүдрийн заар мэдрэлийн эсийн өсөлтийн хүчин зүйлийг дэмжих үйлдэлтэй болохыг илтгэж байна. Хүдрийн заар 100 мг/кг тунгаар тархины ишеми-реперфузийн эмгэг загварын үед тархины эдэд агуулагдах Arg-1, Bcl-2 уургийн илрэлийг нэмэгдүүлэн, Iba-1 уургийн илрэлийг бууруулснаар мэдрэлийн эсийг хамгаалах, мэдрэлийн эсийн үхжилээс сэргийлэх, шигдээсийн талбайг бууруулж, хөдөлгөөний үйл ажиллагааг нэмэгдүүлэх нөлөөтэй байна.

## SUMMARY

**Keywords:** musk, musk deer, rat model of cerebral ischemia/reperfusion

**Title:** The effect of musk (*Moschus moschiferus* L.) on pathologic model of ischemic stroke

## BACKGROUND

Cerebrovascular disease is a leading cause of serious long-term disability, and the second leading cause of death worldwide. There are 290 strokes and 130 deaths among 100000 adults in Mongolia, which is very high compared to that of other countries. Therefore, the treatment and prevention of cerebrovascular diseases are becoming a pressing issue in Mongolia. Thus, in this study, we ought to examine the neuroprotective effects of musk, a valuable medicinal raw material that has widely been used for the treatment of stroke in traditional medicine.

## AIM

To examine the effect of musk of (*Moschus moschiferus* L.) on rat ischemia/reperfusion injury induced by occlusion of the middle cerebral artery.

## MATERIALS AND METHODS

The study was carried out in the laboratories of Mongolian National University of Medical Sciences, Institute of Traditional Medicine and Technology (ITMT), Mongolia, and Inner Mongolia University of Nationalities, China.

Twenty male white mice weighing 25-33 g were obtained from the Animal house of ITMT. Three hundred male Wistar rats weighing 180-200 g were obtained from the Xinjiang animal house, Liaoning, China. Musk was taken by stripping from musk deer located in musk deer breeding area of ITMT in Shar hooloi, Gachuurt district, and then supplemented with a dried liver of goat.

Wistar rats were allocated into 6 groups namely normal, placebo, control, musk 50 mg/kg, musk mg/kg, and nimodipine 10 mg/kg. In all animal groups except normal,

ischemic stroke was induced via occlusion of the middle cerebral artery. Medicines were given orally to rats for 7 consecutive days. Serum and brain tissue levels of TNF- $\alpha$ , IL-6, IL-1 $\beta$ , and IL-10 were measured using enzyme-linked immunosorbent assay. Brain tissue levels of *TGF- $\beta$* , *BDNF*, *TrkB*, and *NGF* were determined by real-time polymerase chain reaction. Levels of Arg-1, Iba1, and Bcl-2 in rat brain tissues were determined by immunofluorescence histochemistry.

## RESULTS

Musk at doses of 50 and 100 mg/kg significantly reduced serum and brain tissue levels of IL-1 $\beta$ , TNF- $\alpha$ , and IL-6 3 and 7 days after the induction of cerebral ischemia/reperfusion ( $p < 0.05$ ). While IL-10 levels in the serum and brain tissue were significantly increased by musk treatments ( $p < 0.05$ ).

Musk at doses of 50 and 100 mg/kg significantly increased mRNA expressions of *BDNF*, *NGF*, *TGF- $\beta$* , and *TrkB* at the 3rd and 7th days after induction of cerebral ischemia/reperfusion ( $p < 0.05$ ).

Musk at a dose of 50 mg/kg significantly reduced Arg-1 and Bcl-2 protein levels at the 7th day after induction of cerebral ischemia/reperfusion ( $p < 0.05$ ). Musk at a dose of 100 mg/kg significantly increased Arg-1 ( $p < 0.001$ ) 1, 3, and 7 days after induction of cerebral ischemia/reperfusion. While, Bcl-2 protein levels were significantly increased by musk (100 mg/kg) treatment 1, 3, and 7 days after induction of cerebral ischemia/reperfusion injury ( $p < 0.05$ ).

After induction of cerebral ischemia/reperfusion, right-sided paralysis was occurred in rats indicating that ischemia was developed in the right hemisphere of the brain. The movement score of rats was found to be  $> 2$ . Musk at doses of 50 and 100 mg/kg and nimodipine at a dose of 10 mg/kg significantly improved movement score compared to control ( $p < 0.05$ ). Musk at all doses significantly reduced ischemic area ( $p < 0.05$ ).

## CONCLUSION

Musk exhibits anti-inflammatory effects in rats with cerebral ischemia/reperfusion via inhibiting pro-inflammatory cytokines such as IL-1 $\beta$ , TNF- $\alpha$ , and IL-6 and promoting anti-inflammatory cytokines such as IL-10.

Moreover, musk increases mRNA expressions of neuroprotective factors such as *BDNF*, *NGF*, *TGF- $\beta$* , and *TrkB* in rats with cerebral ischemia/reperfusion. This suggests that musk of *Moschus moschiferus* promotes neurogenesis.

Musk increases Arg-1 and Bcl-2 protein levels and decreases Iba-1 protein expressions in the rat model of cerebral ischemia/reperfusion. These results suggest that musk protects neurons and decreases neuronal cell death and reduces ischemic zone in the rat model of cerebral ischemia/reperfusion.

## СУДАЛГААНЫ НЭР

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫГ СУДЛАН, ЗУРАГЛАЛЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

КОВИД-19 ХАЛДВАРЫН ҮЕД ҮЗҮҮЛЖ БУЙ АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСЛАМЖ, ТУЛГАМДСАН  
АСУУДЛЫГ ТОГТООХ НЬ

## СУДАЛГААНЫ БАГ

Судалгааны зөвлөх:

**Б.ДАШЛХҮМБЭ** (АШУҮИС, АУ-ны доктор)

Судлаачид:

**Г.ОДОНЧИМЭГ** (АШУҮИС – Эрдмийн сургууль)  
**Г.ТУНГАЛАГТАМИР** (ЭМХТ - Эрүүл мэндийн эдийн засаг,  
бодлогын судалгааны албаны  
мэргэжилтэн)  
**Б.МӨНХБАТ** (ЭМХТ – Магадлан итгэмжлэлийн  
албаны мэргэжилтэн)  
**Я.БАДАМСҮРЭН** (ЭМХТ – Эс, эд, эрхтэн шилжүүлэн  
суулгах үйл ажиллагаа зохицуулан  
албаны мэргэжилтэн)



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ БА ХЭРЭГЦЭЭ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ЗАГВАР

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН АРГУУД

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ДҮГНЭЛТ

**СУДАЛГАА ЯВУУЛСАН ХУГАЦАА: 2021.12.17 ~ 2022.01.24**

## **ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ**

ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМХЗА	Эрүүл мэнд хөгжлийн зуун ассоциац
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
АӨЭМТ	Аймгийн өрхийн эрүүл мэндийн төв
АШЭМБ	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. ЭМТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүн ам, их эмч, сувилагч

Хүснэгт 2. Ковид-19 өвчний дэгдэлтийн үеийн эмч, сувилагчийн ажлын ачаалал

Хүснэгт 3. Пульс оксиметр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, рентген ашиглалт

Хүснэгт 4. Өвчтөний биеийн байдал үнэлэх

Хүснэгт 5. Вирусийн эсрэг эмийн нөөц, хангалт

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Өдөрт илрэх тохиолдлын тоо, хүний нөөцийн хомсдол

Зураг 2. Гэрийн идэвхтэй эргэлтийн хэлбэр

Зураг 3. Хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, хангалт

Зураг 4. Хүндэвтэр, хүнд өвчтөн шилжүүлэх хугацаа

Зураг 5 . Өвчтөн шилжүүлэхэд үүсэх хүндрэлүүд

Зураг 6. Өвчтөн өөрийн унаагаар дараагийн шатлалд зорчих

Зураг 7. Аюулгүй тээвэрлэх, шилжүүлэх заавар боловсруулан хэрэгжүүлэлт

Зураг 8. Багц хүргэлт

Зураг 9. Гэрийн хяналтад буй өвчтөний эмчилгээ

Зураг 10. Анхан шатны тусламж үйлчилгээний тулгамдсан асуудал

Зураг 11. Эмч нар сургалтад хамрагдалт

Зураг 12. Хүндэвтэр тохиолдолд авах арга хэмжээнд өөртөө итгэх итгэлийн үнэлгээ

Зураг 13. Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийн үнэлгээ

## **НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ БА ХЭРЭГЦЭЭ**

### **1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ**

Улирлын томуугийн дэгдэлт, КОВИД-19 мутацилагдсан хувилбар тархах нь эрүүл мэндийн салбарын ачааллыг нэмэгдүүлж эмнэлэгүүдэд орны хомсдол үүсгэн нас баралтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймд эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, уялдаа холбоог сайжруулж халдварын тохиолдлуудыг эрт илрүүлэн, зөв эрэмблэн ангилж, тохирсон тусламж үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай үзүүлэх асуудал туйлын өндөр ач холбогдолтой байна.

Коронавирусын мутацилагдсан хувилбар улс даяар дахин тархах үед эмнэлгүүдэд хүний нөөцийн хомсдол үүсч халдвар авсан иргэд хүндрэх, нас барах эрсдэл нэмэгдэх хандлагатай байна.

Иймд КОВИД-19-ийн халдвар авсан өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зураглалыг цахим технологид суурилан шинэчлэн боловсруулж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хомсдолыг бууруулахад чухал ач холбогдолтой.

### **1.2 ЗОРИЛГО**

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас КОВИД-19 цартахлын эсрэг үзүүлж буй эмнэлзүйн тусламж үйлчилгээний менежментийг сайжруулах тогтолцооны зураглалыг шинэчлэн боловсруулах

### **1.3 ЗОРИЛТ**

1. Эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардагдах хүний нөөцийн хүрэлцээ тэдний мэдлэг, чадвар болон түүнд нөлөөлөх хүчин зүйлийг (эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэлийн хангалт, хүрэлцээ) үнэлэх

2. Батлагдсан тохиолдлуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ тусгаарлалт, эрэмблэн ангилалт, тээвэрлэлт оновчтой цаг хугацаандаа хийгдэж буйг үнэлэх

3. Анхан шатны зарим эрүүл мэндийн байгууллагын Ковид-19 халдварын үед үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохиолдож байсан бэрхшээлүүдийг илрүүлэх

## **ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ**

### **2.1 СУДАЛГААНЫ ЗАГВАР БА АРГАЧЛАЛ**

Эрүүл мэндийн байгууллагад суурилсан агшингийн (facility based cross-sectional), шууд ажиглалт, тойм судалгааны загваруудыг уг судалгаанд ашигласан.

### **2.2 СУДАЛГААНЫ НЭГЖ, ТҮҮВЭРЛЭЛТ**

Анхан шатны тусламж үзүүлж буй 8 дүүргийн ӨЭМТ, алслагдсан дүүргээс тус тус 1-ийг, аймаг бүрээс 2-5 СЭМТ-ийг сонгон судалгаанд хамруулсан.

Эрүүл мэндийн байгууллагууд		Хамрагдсан төвүүд
Улаанбаатар хот	8 дүүрэг	23 ӨЭМТ
Хөдөө орон нутаг	21 аймаг	86 АНЭ, СЭМТ

## 2.3 СУДАЛГААНЫ МЭДЭЭ МАТЕРИАЛ ЦУГЛУУЛАХ

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тусламжийн чанарын үнэлгээг хийхэд эрүүл мэндийн байгууллагын төрөл, зэрэглэл төдийгүй ачаалал, хүртээмж, лавлагаа шатлалаас алслагдалт, төвийн бүс болон захын бүсүүд зэргийг төлөөлөх нийт 108 ӨЭМТ, СЭМТ-ийг хамруулан асуумжийн дагуу мэдээллийг 2021.12.17-2022.12.24 хүртлэх хугацаанд цуглуулсан.

Аймаг бүрээс 1-2 СЭМТ, ЭМТ сонгон КОВИД - 19 үед үзүүлж буй арга хэмжээний, эмнэлгийн тусламжийн чанар хүртээмж, ачааллын мэдээллийг биеэр цаасан хэлбэрээр болон цахимаар асуумж илгээж хариултыг авсан. Энэ судалгааны хүрээнд хүрц ба хүртээмжийг 13, эрэмбэлэн ангилалтыг 5, шилжүүлэлт ба тээвэрлэлт 5, эмчилгээ-хяналт 10 асуултын хүрээнд судалсан.

## 2.4 МЭДЭЭГ НЭГТГЭН, БОЛОВСРУУЛАХ

Мэдээллийг Microsoft Office Excel програм дээр датаг оруулж, STATA 15 програм ашиглан боловсруулалт хийсэн. Үр дүнгийн үзүүлэлтийг дундаж утга, эзлэх хувь зэргийг харьцуулан гаргаж дескриптив шинжилгээ хийсэн. Үр дүнг хүснэгт, зураг, схемээр харуулан тайланд тусгав.

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 3.1 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОЛОН ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮРЦ, ХҮРТЭЭМЖ

Судалгаанд нийт 108 АШЭМБ хамрагдсан ба 62% нь СЭМТ, 15% нь АӨЭМТ, 23% нь ӨЭМТ байна.

*Хүснэгт 1. АШЭМБ-дын эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байдал*

Үзүүлэлт	Үйлчлэх хүрээний хүн ам	Нийт ажилтан	Их эмч	Сувилагч	Ноогдох хүн	
					Их эмчид	Сувилагчид
ӨЭМТ	11750	16	6	5	1958	2350
АӨЭМТ	13314	21	8	7	1664	1902
СЭМТ	2935	22	3	4	978	734

“Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-д 1800-2000 хүн тутамд 1 их эмч, 1 их эмчид 2-3 сувилагч ноогдон ажиллана.


“Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-д үйлчлэх хүрээний хүн амаас хамааруулан 3 000 хүртэл хүнтэй бол нэгдүгээр зэрэглэл, 3 000-аас дээш хүнтэй бол хоёрдугаар зэрэглэл, 8 000-аас дээш хүнтэй бол гуравдугаар зэрэглэлд хувааж 1000-1200 хүн ам тутамд 1 их эмч, 1 их эмчид 2-3 сувилагч оногдуулахаар заасан. Дээрхи стандартын дагуу тооцвол ажиллавал зохих тооны их эмч ажилласан хэдий ч ажиллавал зохих сувилагчийн тоо хангалтгүй байна. **ӨЭМТ-д 1958, АӨЭМТ 1664, СЭМТ 978 хүн ноогдож байна.** ЗАРИМ НЭГ БАЙГУУЛЛАГУУДАД ИХ ЭМЧ ХАНГАЛТГҮЙ БАЙН Ж/нь:

ЭМХТ-ийн “Эрүүл мэндийн үзүүлэлт 2020”-ны үзүүлэлтээр жилд өрхийн эмчийн 5,478,300 үзлэг хийгдсэн ба өрхийн нэг их эмчид ногдох үзлэгийн тоо Улаанбаатар хотод 6,083 аймгийн түвшинд 5,226 байсан байна.

*Хүснэгт 2. Ковид-19 өвчний дэгдэлтийн үеийн эмч, сувилагчийн ажлын ачаалал*

Үзүүлэлт	Ковидын халдварын тохиолдол	Гэрийн идэвхтэй хяналт	Ажиллавал зохих		Ажилласан		Нэг эмчид ноогдсон үзлэгийн тоо	
			Их эмч	Сувилагч	Их эмч	Сувилагч	Ковидын халдварын тохиолдол	Гэрийн идэвхтэй хяналт
ӨЭМТ	106681	30961	6	12	6	5	711	206
АӨЭМТ	44756	13330	7	14	8	7	350	104
СЭМТ	17792	7423	2	4	3	4	89	37

Эмчийн өдөрт үзэх үзлэгийн тоо 20 байдаг бол судалгаанд оролцсон ӨЭМТ-ийн нэг их эмч зөвхөн коронавирусийн тусламж үйлчилгээг өдөрт 5, аймаг, сумын ЭМТ-ийн их эмч өдөрт 4 халдвартай өвчтөнд үзлэг хийсэн байна.




*Зураг 1. Өдөрт илрэх тохиолдлын тоо, хүний нөөцийн хомсдол*

Судалгаанд оролцогчдоос өдөрт илрэх тохиолдлын тоо хэд хүрэхэд хүний нөөцийн хомсдол үүсдгийг тодруулахад 83,1 % нь өдөрт илрэх тохиолдлын тоо 10-30 хүрэхэд хүний нөөцийн хомсдол үүсдэг гэж хариулсан бол нэмэлтээр 8,7 % нь эмнэлгийн ажилчид өөрсдөө өвдсөн болон чөлөө авсан үед хүний нөөцийн хомсдол үүсдэг гэжээ.

1-2 их эмчтэй СЭМТ-үүд өдөрт илрэх тохиолдлын тоо 10-20 хүрэхэд хүний нөөцийн хомсдол үүсдэг гэж хариулсан байна. Үйлчлэх хүрээний хүн амын 1% дээш тохиолдолд Ковид-19 батлагдсан тохиолдолд хүний нөөцийн хомсдол бодитоор үүсэж байна.


Хүний нөөцийн хомсдол хүргэх хүчин зүйл:

Судалгаанд оролцсон ЭМТ-үүд Коронавируст халдварын 30 хувийг гэрийн идэвхтэй хяналтад хамруулан тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.



*Зураг 2. Гэрийн идэвхтэй эргэлтийн хэлбэр*

Гэрийн идэвхтэй эргэлтийг өөрийн биеэр эмчийн бодит үзлэгээр 80,2% нь хийсэн бол 11,6% нь өөрийн биеэр, 7% нь утсаар идэвхтэй эргэлтийг хийсэн байна.



*Зураг 3. Хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, хангалт*

Хувийн хамгаалах хэрэгслийн нөөц, хангалт 1 буюу дутагдалтай гэж 4,7% нь, 5 буюу хангалттай гэж 35,8% нь хариулсан байна. 2 БҮЛЭГ БОЛГООД ХАНГАЛТТАЙ болон ХАНГАЛТ МУУ гэж хуваах

Цахимаар хяналт хийсэн АШЭМБ-дад хүний нөөцийн хомсдол үүсээгүй гэж хариулсан ба хүний нөөцийн хомсдол үүсэх босгыг хүн амын 2% хүрж тархах үед бодит хомсдол үүсдэг гэж үзсэн байна.

*Хүснэгт 3. Пульс оксиметр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, рентген аппаратын хангалт, ашиглалт*

	пульс оксиметр			хүчилтөрөгч өтгөрүүлэгч			рентген		
	* (+) %	(-) %	(¶) %	* (+) %	(-) %	(¶) %	* (+) %	(-) %	(¶) %
ӨЭМТ	100%	-	100%	96%	4%	96%	-	100%	-
АӨЭМТ	100%	-	100%	87,5%	12,5%	100%	6,2%	93,8%	100%
СЭМТ	100%	-	100%	95,5%	4,5%	100%	3%	97%	100%

\* +: байгаа  
 -: байхгүй  
 ¶: ашиглалт

Судалгаанд оролцсон ЭМТ-ийн 2,8% нь Рентген аппараттай, оношилгоонд ашигладаг ба 800-810 хүний оношилгоонд ашигласан гэсэн бол 97,2% нь рентген аппарат байхгүй гэж хариулсан байна.

Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат байгаа ч огт ашиглаагүй 1 ӨЭМТ байсныг лавлахад ашиглах нөхцөл бүрдээгүй гэж хариулсан.

### 3.2 БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛЫН ҮЕД ҮЗҮҮЛЭХ ШУУРХАЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Батлагдсан тохиолдолуудын тусгаарлалт, эрэмблэн ангилалтыг зөв, хүн бүрт, цаг хугацаанд нь хийсэн эсэх мөн хүнд, хүндэвтэр хүмүүст зохих арга хэмжээг цаг алдалгүй, зөв авч хэрэгжүүлсэн болон цаг алдалгүй лавлагаа шатлалд илгээсэн байдлыг үнэлсэн.

Судалгаанд оролцсон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг Коронавируст халдвар (COVID-19)-ын эмнэлзүйн зааврын дагуу асуумжийг үнэлэхэд 42,5% нь хатгааны шинж тэмдгүүдийг зөв үнэлсэн бол хүндрэх эрсдлийг 23,6% нь, гэрээр хянах шийдвэрийг 76,8% нь эмнэлзүйн заавар, журмын дагуу зөв үнэлсэн байна.

Гэрээр хянах, лавлагаа шатлалд шилжүүлэх шийдвэрийг гаргахдаа эрэмблэн ангилалтад үндэслээгүй шалтгааныг тодруулахад орны хүрэлцээ, бололцоог үндэслэн шийдвэр гаргасан гэж хариулсан байна.

#### Хүснэгт 4. Өвчтөний биеийн байдал үнэлэх


	Сатураци хэмжсэн байдал (%)	Үнэлгээ				Гэрээр хянах шийдвэр	
		Хатгааны шинж		Хүндрэх эрсдэл		√ (%)	Х (%)
		*√ (%)	Х (%)	√ (%)	Х (%)		
<b>ӨЭМТ</b>	96,8	32	68	24	76	64	36
<b>АӨЭМТ</b>	89	50	50	31	69	87,5	12,5
<b>СЭМТ</b>	93,5	45	55	16	84	79	21

\* √- зөв үнэлсэн

Х- буруу үнэлсэн


### С. Шилжүүлэх хүлээлцэх тогтолцоо

Коронавируст халдвар (КОВИД-19) -ын батлагдсан тохиолдлыг өөр эмнэлэгт шилжүүлэх, зөөвөрлөх асуудлыг эмнэлзүй, халдварын сэргийлэлт, хяналтын баг зөвшилцөн шийдвэрлэнэ. Зайлшгүй шаардлагатай оношилгоо, эмчилгээ хийх зорилгоор өвчтөнг эмнэлгийн бусад тасаг, хэсэг, өөр эмнэлэг рүү шилжүүлэх бол очих зам талбайг урьдчилан чөлөөлүүлж, бусад хүмүүстэй хавьтал болохоос сэргийлнэ.




*Зураг 4. Хүндэвтэр, хүнд өвчтөн шилжүүлэх хугацаа*

Оролцогчдийн 84% хүндэвтэр болон хүнд тохиолдлуудыг шилжүүлэх хүсэлт өгснөөс хойш 30 минутаас 3 цаг хүртлэх хугацааны дараа шилжүүлсэн байна.



*Зураг 5. Өвчтөн шилжүүлэхэд үүсэх хүндрэлүүд*


Судалгаанд оролцсон ЭМТ-ийн дийлэнх буюу 61% нь орны хүрэлцээ муугаас хүлээгдэл их үүсэж байсан гэж хариулсан ба 12% нь зөврийн тоног төхөөрөмж хангалтгүй байсан, машины хүрэлцээ дутмаг байсан зэргээр хариулсан байна.



*Зураг 6. Өвчтөн өөрийн унаагаар дараагийн шатлалд зорчих*

Хүндэвтэр болон хүнд өвчтөнгүүдийн 13,1% нь өөрсдийн унаагаар дараагийн шатлалд хүрч тусламж үйлчилгээ авсан байна.






*Зураг 7. Аюулгүй тээвэрлэх, шилжүүлэх заавар боловсруулан хэрэгжүүлэлт*

Судалгаанд оролцогчдийн 94-с дээш хувь нь эрүүл мэндийн байгууллага хооронд аюулгүй тээвэрлэх, шилжүүлэх заавар боловсруулан хэрэгжүүлсэн байна.


### 3.3 ЭМЧИЛГЭЭ, ХЯНАЛТ

Судалгаанд оролцсон ЭМТ-үүд нь Коронавируст халдвар (КОВИД-19) -ын батлагдсан тохиолдлуудад 1-7350 орчим багц тараажээ.



*Зураг 8. Багц хүргэлт*

ЭМТ-үүд гэрийн хяналтад буй харъяа хорооны иргэдийн багц хүргэхдээ 75%-нь эрүүл мэндийн байгууллагаас хүргэлт хийсэн байна.



*Зураг 9. Гэрийн хяналтад буй өвчтөний эмчилгээ*

ЭМТ-ийн 90-ээс дээш хувь нь гэрээр хяналтад буй өвчтөний эмчилгээнд халуун бууруулах эмчилгээ, вирусын эсрэг эмчилгээ, витамин эмчилгээг хийсэн байна.


*Хүснэгт 5. Вирусийн эсрэг эмийн нөөц, хангалт*

	Хүндэвтэр болон хүнд тохиолдол	Вирусын эсрэг эмийн нөөц, хангалт			Нас баралтын шалтгааныг судлан шинжлэх, бололцоо байсан эсэх	
		хүрэлцэхгүйц	Зөвхөн хүндэвтэр, хүнд хүмүүст хүрэлцэхүйц	Хүрэлцэхгүй байсан	Тийм	үгүй
ӨЭМТ	11747	68%	4%	28%	48%	52%
АӨЭМТ	7040	75%	6%	19%	13%	87%
СЭМТ	3783	62%	13%	25%	37%	63%

Вирусийн эсрэг эмийн нөөц, хангалт хүрэлцэхүйц байсан гэж дийлэх буюу 66% нь хариулсан байна.


Нас баралтын тохиолдлуудын шалтгаан хүчин зүйлийг шинжлэх, судлан авах арга хэмжээг сайжруулах бололцоо байсан эсэхийг тодруулахад 37.4% нь тийм, 32.7 хувь нь үгүй, 16.8% нь мэддэг хэдий ч цаг зав хүрэлцээ байгаагүй, 13.1% нь хэрхэн хийх аргачлалыг мэдэхгүй гэж хариулсан байна.

Батлагдсан тохиолдлын тоо ихсэх тусам иргэн бүрлүү өдөрт 2 удаа утасдан биеийн байдлыг үнэлэх нь хүндрэлтэй мөн гэрээр эм тараах нь маш их цаг авч үндсэн ажлын хажуугаар оройгоор эм тараах, үзлэг хийх, дуудлагад явах, маягт хөтлөх, шивэх зэрэг маш их ачаалалтай байсан. Ажилчдын ар гэрээс их гомдол ирж байсан ба өдөр шөнөгүй утас дуугарах, иргэд уурлаж эмч сувилагч нарыг хараах, загнах, шөнө оройгоор ирж үз шинжилгээ ав гэж шаардах зэрэг тулгамдсан асуудлууд их тохиолдсон байна.




*Зураг 10. Анхан шатны тусламж үйлчилгээний тулгамдсан асуудал*

Судалгаанд оролцсон ЭМТ-ийн дийлэнхи буюу 38% нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүний нөөцийн хомсдол, орны хүрэлцээ, ачаалал зэрэг нь тусламж үйлчилгээ үзүүлэхэд хамгийн их хүндрэл үүсгэдэг гэсэн байна.




*Зураг 11. Эмч нар сургалтад хамрагдалт*

Судалгаанд оролцсон эрүүл мэндийн төвүүдийн эмч нар Ковидын үед үзүүлэх эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан байдал 89,7 хувьтай байгаа бол 10,3% нь сургалтад хамрагдаагүй байна. Сургалтад хамрагдаагүй ЭМТ-ийг лавлахад АӨЭМТ, СЭМТ-үүд байна.



*Зураг 12 . Хүндэвтэр тохиолдолд авах арга хэмжээнд өөртөө итгэх итгэлийн үнэлгээ /хувиар/*

ӨЭМТ, СЭМТ-үүдийн эмч нарын хүндэвтэр тохиолдолд авах арга хэмжээнд өөртөө итгэх итгэлийг оноогоор илэрхийлэхэд дийлэх буюу 49,5% нь өөртөө 61-80% өөртөө итгэлтэй, 29.0% нь 81-100% итгэлтэй гэж хариулсан бол 1.9% нь өөртөө итгэх итгэл 0-20% гэж үнэлсэн байна.



*Зураг 13. Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийн үнэлгээ*

Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийн чадавхийг оноогоор дүгнэхэд дийлэнх буюу 45,8% нь 61-80% гэж дүгнэсэн байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. АШЭМБ-дын харъяа хүн амын 1% дээш хувь нь халдварт өртөхөд хүний нөөцийн хомсдол бодитоор үүсэж байна.
2. Эмнэлгийн ажилчид халдвар авах, халдвар авсан байж болзошгүйн улмаас чөлөө авах нь хүний нөөцийн хомсдолд богино хугацаанд хүргэж байна.
3. Шуурхай хариу арга хэмжээний багт ажиллаж буй эмч, сувилагч нарын эрэмблэн ангилалт, хариу арга хэмжээний талаархи мэдлэг хангалтгүй байна.
4. Хэвтүүлэн эмчлэх орны хүрэлцээ хангалтгүй байгаа нь АШЭМБ-ийн гол тулгамдсан асуудал болж байна
5. Шаардлагагүй хүнд эм, эмийн багцийг толгой дараалан тарааж буй нь нөөцийн үрэлгэн байдалд хүргэж байна

## **ТАВ. ЗӨВЛӨМЖ**

1. Ажлаа хийх явцдаа халдвар авах, халдвар авсан байж болзошгүй шалтгаанаар чөлөө авах зэрэг нь хүний нөөцийн хомсдолд богино хугацаанд хүргэж буй тул аль болох зайнаас, цахимаар иргэдийн эрүүл мэндийг хянах.
2. Эмч, эмнэлгийн ажилчдын халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлж нэмэлт ачаалал үүсгэж буй эмийн багц тараах ажилд өвчтөний ар гэрийнхэн болон сайн дурын ажилтнуудыг татан оролцуулах.
3. АШЭМБ харьяаллын хүн амд үзүүлж буй үндсэн чиг үүргийн 8 төрлийн тусламж үйлчилгээг (дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, эх, хүүхдийн гэрийн эргэлт, эрсдэлт бүлгийн гэрийн эргэлт, даатгалаар эм бичих зэрэг) цахимжуулж ачааллыг бууруулах.
4. Эмнэлгийн ажилтнууд КОВИД-19-ын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллахдаа эмнэлэг дотооддоо сургалт болон өглөөний шуурхайг тогтмол хийх үйл ажиллагааны зураглалаа сайжруулах арга хэмжээ авч ажиллах.
5. Цахим технологийн тусламжтай иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, иргэд эрүүл мэндээ өөрөө хянах бололцоог бүрдүүлэх
6. Эмчилгээний заавар, журмын дагуу өвчтөнг үнэлж дүгнэх, өвчтөнд шаардлагагүй эмийг эмийн багцаас хасаж зардлыг хэмнэх.
7. Шуурхай хариу арга хэмжээнд ялангуяа хүндэвтэр, хүнд тохиолдолуудтай ажиллах үедээ чанарын хэмжилт, хяналтуудыг тогтмол хийж асуудлыг тухай бүрт сайжруулах.

**СУДАЛГААНЫ НЭР:**

**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ОРОН НУТГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ  
(2021-2022 ОН)**

**ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:**

**Н.НАРАНГЭРЭЛ (Магадлан итгэмжлэлийн албаны  
ахлах мэргэжилтэн, НЭМ-н магистр)**

## НЭГ. ОРОН НУТГИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР:




Улсын хэмжээнд 2021 онд 446, 2022 онд 472 эрүүл мэндийн байгууллагууд магадлан итгэмжлэгдсэнээс орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд 2021 онд 59,4 хувийг эзэлж байсан бол 2022 онд 8,2 хувиар өсч 67,6 хувийг эзэлж байна.


Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь харахад, Сум, тосгоны эрүүл мэндийн төв аль ч онд дийлэнх хувийг буюу 51,32% (136)/59,8% (191)-ийг, удаах байранд Хувийн хэвшлийн эмнэлэг 18,87% (50)/13,2% (42)-ийг мөн Өрхийн

эрүүл мэндийн төв 14,34% (38)/15,7% (50)-үүд тус тус эзэлж байгаа ба уламжлалт анагаах ухааны болон сэргээн засах 4 төв жил бүр магадлан итгэмжлэгдсэн байна.



### Магадлан итгэмжлэгдсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд, төрлөөр, бодит тоогоор (2021, 2022 он)



Эзлэх хувиар, байгууллагын төрлөөр, 2021 ба 2022 он



Магадлан итгэмжлэгдсэн хугацаа/жилийг харахад, сүүлийн 2 жилийн дунджаар орон нутгийн байгууллагуудын 33,1 хувь нь 1 жилээр, 33,1 хувь нь 2 жилээр, 28,4 хувь нь 3 жилээр, 5,3 хувь нь 4 жилээр, 0,2 хувь нь 5 жилээр тус тус магадлан итгэмжлэгджээ.




**СЭМТ-ийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

2022 онд МИ-сэн нийт СЭМТ-ийн 87,3 хувь нь 2 ба 3 жилээр МИ-сэн нь өмнөх оноос (30,5%) 56.8 хувиар өссөн байна.

2 жилээр МИ-сэн СЭМТ-ийн эзлэх хувь өмнөх оноос 34,4-р; 3 жилээр МИ-сэн СЭМТ-ийн элэх хувь өмнөх оноос 22,4-р тус тус өссөн.


Өмнөх онд 1-ч СЭМТ 4 жилээр МИ-ээгүй бол 2022 онд 3,9 хувь буюу 7 СЭМТ 4 жилээр МИ-жээ.





**Сувиллын магадлан итгэмжлэгдсэн байдал:**

3 жилээр МИ-сэн сувиллын эзлэх хувь өмнөх оноос 21,5-р; 4 жилээр МИ-сэн сувиллын элэх хувь өмнөх оноос 21,9-р тус тус өссөн.




**ӨЭМТ-ийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

2022 онд МИ-сэн нийт ӨЭМТ-ийн 84,0 хувь нь 2 ба 3 жилээр МИ-сэн нь өмнөх оноос (42,1%) 41,9 хувиар өссөн байна.

2 жилээр МИ-сэн ӨЭМТ-ийн эзлэх хувь өмнөх оноос 16,3-р; 3 жилээр МИ-сэн ӨЭМТ-ийн элэх хувь өмнөх оноос 25,6-р тус тус өссөн.

Өмнөх онд 1-ч ӨЭМТ 4 жилээр МИ-ээгүй бол 2022 онд 6,0 хувь буюу 3 ӨЭМТ 4 жилээр МИ-жээ.




**Хувийн эмнэлгийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

2022 онд МИ-сэн нийт Хувийн эмнэлгийн 83,3 хувь нь 2 ба 3 жилээр МИ-сэн нь өмнөх оноос (64,0%) 19,3 хувиар өссөн байна.




2 жилээр МИ-сэн Хувийн эмнэлгийн эзлэх хувь өмнөх оноос 8,1-р; 3 жилээр МИ-сэн Хувийн эмнэлгийн эзлэх хувь өмнөх оноос 11,2-р тус тус өссөн.

Өмнөх онд 2 хувийн эмнэлэг 4 жилээр МИ-ж байсан бол 2022 онд 11,9 хувь болж 5 хувийн эмнэлэг 4 жилээр МИ-жээ.



**УАУТ, СЗТ-ийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

2021 онд 4 жилээр МИ-сэн УАУТ, СЗТ 1-ч байхгүй байсан бол 2022 онд 2 УАУТ/СЗТ 4 жилээр МИ-сэн байна.



**ЦАЭМТ-ийн магадлан итгэмжлэгдсэн байдал:**

Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт 9 цэргийн ангийн эрүүл мэндийн төв магадлан итгэмжлэгдсэнээс 44,4 хувь буюу 4 нь 2 жилээр, 55,6 хувь буюу 5 нь 1 жилээр тус тус магадлан итгэмжлэгдсэн.

**ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ (2022)-НД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ:**

**Зорилго:** МИ-ийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээний хамгийн их оноо хасагдсан шалгуурт байгууллагын төрөл бүрээр дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах чиглэлийг тодорхойлох

**Түүвэр:** 2022 оны сүүлийн хагас жилд үнэлгээнд цахимаар болон газар дээр нь очиж үнэлсэн 127 байгууллагуудыг сонгон дүн шинжилгээнд хамруулсан. Үүнд:

- СЭМТ: 76 байгууллага (42%)
- ӨЭМТ: 23 байгууллага (46%)
- ХХЭМБ: 18 байгууллага (42.9%)
- Сувилал: 10 байгууллага (55.5%)

**Дүн шинжилгээний чиглэл:**

Дараах 5 чиглэлээр, онооны сонголт хийж дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

Бүлэг дотор, Дэд бүлэг дотор, Байгууллагын төрөл дотор, Дундаж оноо-гоор, Эзлэх хувь-иар

СЭМТ: 84,9 ба түүнээс доошхи оноо-г

ӨЭМТ: 85,9 ба түүнээс доошхи оноо-г

ХХЭМБ: 89,9 ба түүнээс доошхи оноо-г


Сувилал: 89,9 ба түүнээс доошхи оноо-г сонгож, шалгуур үзүүлэлт дээр дүн шинжилгээ хийлээ.

**ДҮГНЭЛТ:**

**БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ (ДУНДАЖ ОНОО, ЭЗЛЭХ ХУВЬ)**

Байгууллагын төрлөөр харахад, СЭМТ: 5 дэд бүлгийн 4-д нь (Дэд бүлэг 1, 3, 4, 5) хамгийн бага дундаж оноо-г (74.2; 72; 79.5; 79.6) авсан бол ӨЭМТ: 5 дэд бүлгийн 2-д нь (Дэд бүлэг 2, 5) хамгийн бага дундаж оноо-г (68.5; 79.6) авсан.


**Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ: Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (дундаж оноо)**



1-р бүлгийн 5 дэд бүлгийн дундаж оноог харахад, СЭМТ-ийн хувьд д/б 3:Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг дээр хамгийн бага буюу 72-г, ӨЭМТ-ийн хувьд д/б 2:Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал дээр хамгийн бага буюу 68.5-г, ХХЭМБ болон сувиллын хувьд д/б:1 буюу Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал дээр хамгийн бага оноо буюу 85.7; 83,8-г тус тус авсан байна.


Эзлэх хувийг байгууллагын төрлөөр харахад, ӨЭМТ-ийн талаас илүү хувь буюу 52.2% нь д/б 1 дээр 85,9-өөс доош үнэлэгдсэн, харин д/б 5 дээр хамгийн их оноо алдсан байгууллага бол сувилал буюу тал буюу 50 хувь нь 89.9-с доош оноо авчээ.



**Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ: Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь, (эзлэх хувь)**




Байгууллагын төрөл дотор нь харахад, СЭМТ-ийн 25 хувь нь д/б 1 дээр 84,9-с доош оноо, ӨЭМТ-ийн талаас илүү буюу 52,2 хувь нь мөн адил д/б 1 дээр 85,9-с доош оноо, ХХЭМБ-ийн 44,4 хувь нь д/б 5 дээр 89,9-с доош оноо, сувиллын 50 хувь нь мөн адил халдварын сэргийлэлт, хяналт дээр 89,9-с доош оноо тус тус авсан байна.

**Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ: Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь, (эзлэх хувь)**








## БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА (ДУНДАЖ ОНОО, ЭЗЛЭХ ХУВЬ)

Байгууллагын төрлөөр харахад, СЭМТ: 6 дэд бүлгийн 2-д нь (Дэд бүлэг 5, 6) хамгийн бага дундаж оноо-г (76.8; 72.6) авсан бол ӨЭМТ: 6 дэд бүлгийн 4-д нь (Дэд бүлэг 1, 2, 3, 4) хамгийн бага дундаж оноо-г (56.9; 70.7; 56.2; 28.5) авсан.



### Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагаа:

#### Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (дундаж оноо)




2-р бүлгийн 6 дэд бүлгийн дундаж оноог харахад, СЭМТ-ийн хувьд д/б 4: Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал дээр хамгийн бага буюу 61,6-г, ӨЭМТ-ийн хувьд мөн адил д/б 2: Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал дээр хамгийн бага буюу 28.5-г, ХХЭМБ-н хувьд д/б 3: Хүний нөөцийн хөгжил дээр хамгийн бага буюу 86,2-г, сувиллын хувьд д/б: 1 ба 2 буюу Засаглал манлайлал, удирдлага+Чанарын удирдлага дээр хамгийн бага оноо буюу 85.0-г тус тус авсан байна.

**Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагаа:  
Дэд бүлгээр, байгууллагын төрөл тус бүрээр (дундаж оноо)**








Эзлэх хувийг байгууллагын төрлөөр харахад, Сувиллын тал хувь буюу 50% нь Чанарын удирдлага болон Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа гэсэн 2 бүлэг дээр 89,9-өөс доош үнэлэгдсэн, харин 40 хувь нь Засаглал манлайлал болон Барилга инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаан дээр 89.9-с доош оноо авсан нь анхааруштай байна.

### Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагаа : Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (эзлэх хувь)



Байгууллагын төрөл дотор нь харахад, СЭМТ-ийн 21.1 хувь, ӨЭМТ-ийн 26,1 хувь нь, ХХЭМБ-ын 38,9 хувь, сувиллын 50 хувь нь Чанарын удирдлага дээр 84,9/85,9/89.9-с доош оноо тус тус авсан байна.


**Бүлэг 2. Байгууллагын үйл ажиллагаа :  
Дэд бүлгээр, байгууллагын төрөл тус бүрээр (эзлэх хувь)**



**БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ (ДУНДАЖ ОНОО, ЭЗЛЭХ ХУВЬ)**

Дундаж оноог харахад, ӨЭМТ-ийн хувьд НЭМ-ийн тусламж үйлчилгээн дээр хамгийн бага оноо буюу 63,4-г, Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээн дээр 77.5 оноо-г тус тус авсан байна.


**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:  
Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (дундаж оноо)**



СЭМТ-ийн хувьд хамгийн бага оноо буюу 73,3-г уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээн дээр авснаас гадна эмгэг судлалын тусламж дээр 74,9-г, зорилтот бүлэгт үзүүлэх тусламж дээр 75 оноог, лабораторийн тусламж дээр 76,1, халдварт бус өвчний тусламж дээр 77,3, сувилахуй болон яаралтай тусламж дээр 78,1 оноог тус тус авсан байна.


ХХЭМБ-ын хувьд дэд бүлэг 4 буюу лабораторийн тусламж дээр бага оноо 81.2-г авсан бол эм болон сувилахуйн тусламж дээр 85.3/85.7-г, эмчилгээний хоол болон амь тэнссэн үеийн тусламж дээр 86.3/86.9-г тус тус авсан байна.

**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:**  
**Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (дундаж оноо)**



Сувиллын хувьд, хамгийн бага оноог (81.0) яаралтай тусламж дээр, удаах байранд байгалийн хүчин зүйлийг ашиглах тусламж дээр 81.3 оноо, эм зүйн тусламж дээр 81.4 оноог тус тус авсан байна.


**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:  
Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (дундаж оноо)**



Хэр олон байгууллага доогуур оноо авсныг харахад, ӨЭМТ-ийн хувьд 60.9 хувь нь эмэн дээр, 39.1 хувь нь яаралтай тусламж дээр, 34.8 хувь нь уламжлалт болон лабораторийн тусламж дээр 85.9-с доош оноо авчээ.


СЭМТ-ийн хувьд 27.6 хувь нь бас эмэн дээр, 25 хувь нь бас яаралтай тусламж дээр, 19.7 хувь нь бас уламжлалт мөн халдварт өвчний тусламж дээр 84.9-с доош оноо авсан байна.

**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:  
Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (эзлэх хувь)**




ХХЭМБ-ын хувьд талаас илүү хувь нь буюу 55.6 хувь нь сувилахуйн тусламж дээр, 44.4 хувь нь амь тэнссэн үеийн тусламж дээр, 33.3 хувь нь эмийн менежмент дээр тус тус 89.9-с доош оноо авсан байна.

**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:  
Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (эзлэх хувь)**



Сувиллын хувьд тал буюу 50 хувь нь эм, яаралтай, сувилахуйн тусламж дээр 89.9-с доош оноог авчээ.

**Бүлэг 3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ:  
Дэд бүлгээр, байгууллагын төрлөөр нийтэд нь (эзлэх хувь)**



**НЭГДСЭН ДҮГНЭЛТ:**

1. Бүлэг 1 буюу “Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ”-ний хамгийн өндөр буюу 87.4 (дунджаар) оноог ХХЭМБ авсан бол хамгийн бага буюу 77 оноог (дунджаар) СЭМТ авсан байна. Хэлбэлзэл=10.4
2. Бүлэг 2 буюу “Байгууллагын үйл ажиллагаа”-дээр ӨЭМТ хамгийн бага буюу 63.2 оноо авсан бол ХХЭМБ хамгийн өндөр буюу 87.5 оноо авчээ. Хэлбэлзэл=24.3
3. Бүлэг 3 буюу “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-ний хамгийн өндөр оноог (84.3) мөн ХХЭМБ авсан бол хамгийн бага оноог СЭМТ (78.3) авчээ. Хэлбэлзэл=6
4. Байгууллагын төрөл дотор нь харахад: СЭМТ (74.1) болон ӨЭМТ (63.2) аль аль нь бүлэг 2 дээрээ хамгийн бага оноог авсан бол ХХЭМБ (84.3) болон сувилал (82.9) аль аль нь бүлэг 3 дээрээ хамгийн бага оноог тус тус авсан байна.

**СУДАЛГААНЫ НЭР:**

**МОНГОЛ УЛСАД 2017-2021 ОНД БҮРТГЭГДСЭН  
ХОРТ ХАВДРЫН ТАРХВАР ЗҮЙН СУДАЛГАА**

**СУДЛААЧ:**

**Н.ЦЭНДМАА**

**(Эрүүл мэндийн эдийн засаг,  
бодлогын судалгааны албаны  
мэргэжилтэн, НЭМ-н магистр)**

## ҮНДЭСЛЭЛ:

2016 онд дэлхий даяар 15.2 сая хүн сэргийлж болох нас баралт буюу халдварт бус өвчнөөр нас барсаны 6.2 сая (40.8%) нь зүрх судасны өвчин, 4.5 сая (29.8%) нь хорт хавдрын шалтгаант нас баралт байсан.


Хорт хавдар нь дэлхийн хэмжээнд нас баралтын хоёрдугаар шалтгаан болж байгаа ба 2018 онд 9.6 сая хүн хавдраас болж нас барсан (ДЭМБ, 2020). Халдварт бус өвчнөөр нас барсан арван хүн тутмын дөрөв нь зүрх судасны өвчнөөр, гурав нь хорт хавдраар нас бардаг. (Bray et al., 2021).

2020 онд дэлхий нийтээр хорт хавдрын 19.3 сая шинэ тохиолдол, 10 сая орчим хорт хавдрын шалтгаант нас баралт (меланома бус арьсны хорт хавдрыг тооцохгүйгээр 9.9 сая) бүртгэгдсэн байна (Sung, 2021).

Дэлхийн улсуудад эмэгтэйчүүдийн дунд хөхний хорт хавдар 2.3 сая (11.7%) хамгийн их тохиолдож байгаа ба уушгины хавдар (11.4%), бүдүүн гэдэсний хавдар (10.0%), умайн хүзүүний хавдар (7.3%), ходоодны хавдар (5.6%) тус тус удаалж байна.

Түрүү булчирхайн хорт хавдар нь 112 оронд эрэгтэйчүүдийн дунд хамгийн их бүртгэгдсэн ба 36 улсад уушгины хорт хавдар, 11 улсад бүдүүн гэдэсний хорт хавдар, 11 улсад элэгний хорт хавдар эрчүүдийн дунд тэргүүлж байна. (Зураг 1)

Уушгины хорт хавдар нь 93 улсад эрэгтэйчүүдийн хорт хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа ба түрүү булчирхай (48 улс), болон элэгний хорт хавдрын (23 улс) шалтгаант нас баралт удаалж байна.




Зураг 1. Дэлхийн улсуудад эрэгтэйчүүдийн дунд тэргүүлж байгаа хорт хавдар (Source: Global Cancer Statistics 2020, Globocan)



Эрэгтэйчүүдэд элэгний хорт хавдрын өвчлөл газарзүйн хувьд ялгаатай 11 оронд (Монгол улс бусад орнуудаас хамаагүй олон тохиолдол бүртгэгдэг), Зүүн өмнөд Ази (Тайланд, Камбож, Вьетнам), Африк (Египет, Нигер) зэрэг улсуудад өндөр тархалттай байна.

Дэлхийн хэмжээнд хорт хавдрын нас баралтын тэргүүлэх шалтгаан уушигны хавдар байгаа бөгөөд ойролцоогоор 1.8 сая хүн нас барсан (18%) ба бүдүүн гэдэсний хорт хавдар 9.4%, элэгний хорт хавдар 8.3%, ходоодны хавдар 7.7%, хөхний хорт хавдрын шалтгаант нас баралт 6.9%-ийг тус тус эзлэж байна (Sung et al., 2021).

Эмэгтэйчүүдэд хөхний хорт хавдар (159 улс), умайн хүзүүний хорт хавдар (23 улс) хамгийн их тохиолдож байна. (Зураг 2).



*Зураг 2. Дэлхийн улсуудад эмэгтэйчүүдийн дунд тэргүүлж байгаа хорт хавдар (Source: Global Cancer Statistics 2020, Globocan)*

2020 онд дэлхий даяар элэгний хорт хавдрын 906.000 шинэ тохиолдол, 830.000 нас баралт бүртгэгдсэн нь хамгийн түгээмэл оношлогддог хорт хавдрын зургаа дахь, хорт хавдрын шалтгаант нас баралтын гуравдугаарт орж байна. (Ferlay нар, 2021)

Монгол улс элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа дэлхийд нэгдүгээрт ордог бөгөөд 2012 онд тус улсын хорт хавдрын шалтгаант нас баралтын 43% -ийг эзэлж байна (Ferlay et al., 2013).

Ходоодны хорт хавдар 2020 онд нэг сая гаруй шинэ тохиолдол бүртгэгдэж, ойролцоогоор 769.000 хүн нас барж өвчлөлөөрөө тавдугаарт, нас баралтаар дөрөвдүгээрт жагсаж байна. Ходоодны хорт хавдрын өвчлөлийн түвшин Зүүн Ази

(Япон, Монгол хоёрт эрэгтэй, эмэгтэй хүйсийн хувьд ижил өндөр тархалттай) болон Зүүн Европийн хойд хэсэгт өвчлөл хамгийн өндөр байна.

ДЭМБ-ын тооцоолсноор 2018 онд дэлхийд 18.1 сая шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдсэн нь 2040 он гэхэд 50%-иар нэмэгдэж, жилд 27 сая хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдэх төлөвтэй байна. (ДЭМБ, 2020).

Монгол улсад 2008-2012 онд хорт хавдрын 21564 шинэ тохиолдол бүртгэгдсэний 52 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Эрэгтэйчүүдэд хамгийн түгээмэл хорт хавдар нь элэг (42.7%), ходоод (18.4%), уушиг (12.4%), улаан хоолой (7.1%), бүдүүн гэдэсний (2.5%) хавдар тус тус тохиолдож байна. Эмэгтэйчүүдийн дунд хамгийн түгээмэл хорт хавдар нь элэг (34.9%), умайн хүзүү (14.8%), ходоод (11.1%), улаан хоолой (7.2%), хөхний (5.8%) хавдар байна. (Chimed et al., 2017).

## **Зорилго**

2017-2021 онд Монгол улсад бүртгэгдсэн хорт хавдрын шинэ тохиолдлуудын тархвар зүйн онцлог, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах

## **Зорилт**

1. 2017-2021 онд бүртгэгдсэн хорт хавдрын шинэ тохиолдлын төрөл, давтамжийг тогтоох.
2. Хорт хавдрын тохиолдлыг нас, хүйс, оршин суугаа газартай харьцуулан судлах

## **Судалгааны ач холбогдол**

Монгол улсын хүн амын амьдралын чанар, эрүүл мэндийг сайжруулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хорт хавдраас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулахад нотолгоот мэдээлэл бүрдүүлэх

## **Судалгааны арга зүй**

Судалгаанд агшингийн судалгааны аргийг ашиглав.


## **Хамрах хүрээ**

ЭМС-ын 2019 оны 611 тушаалын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд 2017-2021 онд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн тооцов. Өвчний олон улсын ангилалын дагуу хорт хавдын кодоор бүртгэгдсэн оношийн бүлгээр ялган авч судаллаа.

2017-2021 онд Монгол улсын хүн амын дунд хорт хавдрын 23499 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс элэг, ходоод, уушиг, шулуун гэдэс, хөх, умайн хүзүү, улаан хоолойн хорт хавдар хамгийн олон тохиолдож байгаа ба нийт хавдрын 78.4%-ээлэж байгаа тул зонхилон тохиолдож байгаа дээрх 7 төрлийн хавдрыг (18443 тохиолдол) сонгон авч тооцоолов.

Судалгаанд шаардагдах сүүлийн 5 жилийн хүн ам зүйн тоон мэдээллийг (бүс нутгийн хүн амын тоо, он, нас, хүйсээр нь ангилсан) үндэсний статистикийн хорооны <https://www.1212.mn/mn> цахим хуудаснаас авч ашиглав.

Хүн амын насыг 0-30, 31-45, 46-60, 61-84, 85 ба түүнээс дээш гэж ангилан оруулсан ба харьялалыг Монгол улсын газарзүйн байршлаар дөрвөн бүсэд хувааж, нийслэл Улаанбаатар хотыг тусад нь оруулсан.



*Зураг 3. МУ-ын хүн амын байршилг бүсчилэн хуваасан байдал*

### Мэдээллийн дүн шинжилгээ хийх


Өгөгдлийг Jamovi (2.3.18) программыг ашиглан үр дүнгийн шинжилгээ хийв. (jamovi <https://www.jamovi> 2022)

*Хүснэгт 1. МУ-ын бүс нутгуудын эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд (2021)*

Бүс нутаг	Хүн амын тоо		Хүний хөгжлийн индекс	Дундаж наслалт (Жил)	Орлогын индекс
	Тоо	Хувь			
УБ хот	1639172	48%	0.797	72.32	0.804
Хангайн бүс	606430	17.7%	0.784	71.65	0.697
Төв-Говийн бүс	518344	15.2%	0.804	72.36	0.675
Баруун бүс	418607	12.2%	0.791	72.18	0.620
Зүүн бүс	227386	6.6%	0.704	72.37	0.721


## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хорт хавдар шинээр бүртгэгдсэн иргэдийн тэн хагас буюу 50.54% (9321) нь 60-85 нас, 36.4% (6700) нь 46-60 нас, 9.61% (1773) нь 31-45 нас, 2.72% (501) нь 85-аас дээш насныхан, үлдсэн 0.8% (148) нь 0-30 насныхан байв.



Зураг 4. 2017-2021 онд шинээр хорт хавдар бүртгэгдсэн иргэдийн насны байдал

Хүйсийн хувьд судалгаанд оролцогчдын 53.4% нь эрэгтэй, 46.6% нь эмэгтэйчүүд байлаа. Хорт хавдар шинээр бүртгэгдсэн иргэдийг оршин суугаа харьяалалаар нь судлаж үзэхэд 51.7% нь УБ хотоос, 18.8% нь Төв-Говийн бүсээс, 12.2% Баруун бүс, үлдсэн 10.3% нь Хангайн бүс, 7.1% нь Зүүн бүсийн иргэд байлаа.




Зураг 5.

2017-2021 онд шинээр хорт хавдар бүртгэгдсэн иргэдийн харьяалал


Хорт хавдар бүртгэгдсэн үе шатаар нь тооцон үзэхэд шинээр бүртгэгдсэн хавдрын дийлэнх буюу 82.2% (14.618) нь хожуу, үсэрхийлсэн шатандаа, 15.2% (2705) нь хорт хавдрын, үлдсэн 2.6% нь хавдрын эхний үедээ оношлогдсон байна.

Хавдрын төрлөөр нь ангилан үзвэл 41% нь элэгний хорт хавдар, 21.2% нь ходоодны, 11.7% нь уушигны, 8.7% нь улаан хоолойн, 6.8% нь хөхний, 6.3% нь умайн хүзүүний, үлдсэн 4.3% нь шулуун гэдэсний хорт хавдар тус тус бүртгэгдсэн байна.



*Зураг 6. 2017-2021 онд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын төрлүүд*

Сонгосон хугацаанд шинээр бүртгэгдсэн хорт хавдрын 24.5% 2017 онд, 19.1% нь 2018 онд, 21.1% нь 2019 онд, 19% нь 2020 онд, 16.3% нь 2021 онд бүртгэгджээ.



*Зураг 7. 2017-2021 онд зонхилон тохиолдож байгаа 7 төрлийн хорт хавдрын шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо, оноор*

Хүснэгт 2. 2017-2021 онд бүртгэгдсэн зонхилон тохиох хавдрын шинэ тохиолдлуудын нас, хүйс, харьяалал, бүртгэгдсэн хугацааны хоорондын хамаарал (n=18443)

Категори	Үзүүлэлт	Хавдрын төрөл							x <sup>2</sup>	P
		Улаан хоолойн хавдар	Ходоодны хавдар	Шулуун гэдэсний хавдар	Элэгний хавдар	Уушигны хавдар	Хөхний хавдар	Умайн хүзүүний хавдар		
		N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)		
Нас	0–30	2(0)	42(0.2)	13(0.1)	37(0.2)	4(0)	19(0.1)	31(0.2)	2624	<0.001
	31–45	51(0.3)	440(2.4)	117(0.6)	358(1.9)	60(0.3)	332(1.8)	415(2.3)		
	46–60	399(2.2)	1415(7.7)	250(1.4)	2855(15.5)	696(3.8)	574(3.1)	511(2.8)		
	61–85	1065(5.8)	1927(10.4)	395(2.1)	4106(22.3)	1318(7.1)	280(1.5)	230(1.2)		
	>85	93(0.5)	90(0.5)	23(0.1)	211(1.1)	69(0.4)	5(0)	10(0.1)		
Хүйс	Male	892(4.8)	2641(14.3)	384(2.1)	4176(22.6)	1745(9.2)	13(0.1)	0	3706	<0.001
	Female	718(3.9)	1273(6.9)	414(2.2)	3391(18.4)	402(2.2)	1197(6.5)	1197(6.5)		

Категори	Үзүүлэлт	Хавдрын төрөл							x <sup>2</sup>	P
		Улаан хоолойн хавдар	Ходоодны хавдар	Шулуун гэдэсний хавдар	Элэгний хавдар	Уушигны хавдар	Хөхний хавдар	Умайн хүзүүний хавдар		
		N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)	N (%)		
Харьяалал	УБ хот	922(5.0)	2078(11.3)	502(2.7)	3126(16.9)	1221(6.6)	917(5.0)	764(4.1)	1106	<0.001
	Төв-Говийн бүс	192(1.0)	690(3.7)	138(0.7)	1665(9.0)	396(2.1)	133(0.7)	246(1.3)		
	Баруун бүс	314(1.7)	578(3.1)	64(0.3)	959(5.2)	202(1.1)	63(0.3)	77(0.4)		
	Хангай бүс	136(0.7)	385(2.1)	47(0.3)	1027(5.6)	190(1.0)	48(0.3)	61(0.3)		
	Зүүн бүс	46(0.2)	183(1.0)	47(0.3)	790(4.3)	138(0.7)	49(0.3)	49(0.3)		
Хавдрын үе шат (missed=658)	Үсэрхийлсэн	1269(7.1)	2855(16.1)	501(2.8)	6332(35.6)	1754(9.9)	1048(5.9)	859(4.8)	230	<0.001
	Хорт хавдар	217(1.2)	638(3.6)	123(0.7)	1005(5.7)	285(1.6)	144(0.8)	293(1.6)		
	Байран хавдар	24(0.1)	125(0.7)	31(0.2)	132(0.7)	91(0.5)	17(0.1)	42(0.2)		
Бүртгэгд-	2017	345(1.9)	872(4.7)	215(1.2)	2007(10.9)	416(2.3)	288(1.6)	375(2.0)	400	<0.001

-СЭН ОН							
2018	370(2.0)	699(3.8)	152(0.8) )	1537(8.3)	475(2.6)	265(1.4) )	24(0.1)
2019	379(2.1)	856(4.6)	149(0.8) )	1428(7.7)	453(2.5)	306(1.7) )	319(1.7)
2020	281(1.5)	819(4.4)	136(0.7) )	1361(7.4)	447(2.4)	183(1.0) )	282(1.5)
2021	235(1.3)	668(3.6)	146(0.8) )	1234(6.7)	356(1.9)	168(0.9) )	197(1.1)

Хорт хавдрын төрлүүд нь өвчтөнүүдийн нас, хүйс, байршил, хавдрын үе шат зэрэгтэй статистик ач холбогдолтой ( $p < 0.05$ ) байлаа.

Элэгний хорт хавдар 61-85 (22.3%) болон 46-60 (15.5%) насанд хамгийн их тохиолдож байсан бол ходоодны хорт хавдар 61-85 насанд (10.4%) хамгийн их хамааралтай байна.

Насны бүлгээр авч үзвэл 0-30 насанд элэгний хавдар (37 тохилдол), 31-45 насанд ходоодны хавдар (440 тохилдол), 46-аас дээш бүх насны бүлэгт элэгний хавдар (нийт 7172 тохиолдол) хамгийн их хамааралтай байна.

46-60 насныханд нийт хавдрын 36.4% тохиолдсон ба үүнээс элэгний (2855), ходоодны (1415), уушигны хорт хавдар (1318) хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна.


61-85 насны бүлэгт хорт хавдрын хамгийн их тохиолдол (50.5%) бүртгэгдсэн ба элэгний хавдар хамгийн их (4106), дараа нь ходоодны хавдар (1927) тохиолдож байна.

85-аас дээш насныхны дунд 501 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэний, 211 буюу 42% нь нь элэгний хавдар байна.



Хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдэд элэгний хавдар 4176 (22.6%) тэргүүлж, ходоодны хавдар 2641 (14.3%), уушигны хавдар 1745 (9.2%) удаалж байгаа бол эмэгтэйчүүдийн дунд мөн элэгний хорт хавдар 3391(18.4%) хамгийн олон тохиолдож, ходоодны хавдар 1273 (6.9%), хөх, умайн хүзүүний хорт хавдар 1197 (6.5%) тус тус бүртгэгджээ.

Эрэгтэйчүүдэд уушигны хорт хавдар эмэгтэйчүүдтэй харьцуулахад 4.3 дахин, ходоодны хорт хавдар 2.07 дахин их тохиолдож байна. Шулуун гэдэсний хорт хавдрын тохиолдол хоёр хүйсийн хувьд ижил (2.1%; 2.2%) байв.



Зураг 8. 2017-2021 онд зонхилон тохиолдож байгаа хорт хавдрын шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо, бүс нутгаар

Оршин суугаа байрлалаар авч үзвэл нийт хавдрын 51.7% нь нийслэлд, 48.3% нь орон нутагт тохиолдож байна. Нийслэлд элэгний хорт хавдар 3126 (16.9%), ходоодны хорт хавдар 2078 (11.3%) хамгийн их, шулуун гэдэсний хорт хавдар хамгийн бага буюу 502 (2.7%) бүртгэгдсэн байна.

Төв-Говийн бүсэд нийт хавдрын 18.8% нь бүртгэгдсэн ба элэгний хавдар хамгийн их буюу 9.0%, ходоодны хавдар 3.7% байгаа бол хөх, шулуун гэдэсний хавдар хамгийн бага буюу 0.7% байна. Баруун бүсэд элэгний хавдар 5.2%,

ходоодны хавдар 3.1%, улаан хоолойн хавдар 1.7% байгаа нь эхний гурван байранд орж байна. Хангайн бүсэд нийт шинээр бүртгэгдсэн хорт хавдрын 10.3% нь тохиолдсон ба элэгний хорт хавдар (5.6%), ходоодны хавдар (2.1%) нь уушигны хорт хавдар (1.0%) тэргүүлж байна. Зүүн бүсэд элэгний хорт хавдар (4.3%), ходоодны хорт хавдар (1.0%) хамгийн олон тохиолдсон байв.

Хорт хавдрын үе шатаар авч үзвэл зонхилон тохиолдож байгаа 7 төрлийн хавдрын 82.2% нь үсэрхийлсэн шатандаа, 2.6% нь байран хавдар буюу анхан шатандаа оношлогдсон байна. Үүнээс элэгний хавдрын 6332 (35.6%), ходоодны хавдрын 2855 (16.1%), уушигны хавдрын 1754 (9.9%) тохиолдол үсэрхийлсэн шатандаа оношлогдсон бол анхан шатандаа элэгний хавдрын 132(0.7%), ходоодны хавдрын 125 (0.7%), уушигны хавдрын 138 (0.5%) тохиолдолд оношлогдсон байна.

Хугацааны хувьд авч үзвэл 2017 онд хамгийн олон тохиолдол (4518) бүртгэгдсэн бол жил ирэх тусам (2021 онд 3004) багасаж байгаа статистик ажиглагдаж байна.

*Хүснэгт 3. 2017–2021 онд бүртгэгдсэн зонхилон тохилдож байгаа хорт хавдрын шинэ тохиолдлыг 100.000 хүн амд оногдох өвчлөлөөр (ASR) тооцсон нь*

Үзүүлэлт	Тохиолдлын тоо	Хүн амын тоо	100.000 хүн амд оногдох өвчлөл
<b>Насны бүлэг</b>			
0-30	148	1,779,363.00	8.32
31-45	1773	779,290.00	227.51
46-60	6700	504,980.00	1,326.79
>61	9822	232,511.00	4,224.32
<b>Харьяалал</b>			
УБ хот	9530	1,546,124.00	616.38
Төв-Говийн бүс	3460	513,718.00	673.52
Баруун бүс	2257	411,083.00	549.04
Хангай бүс	1894	602,769.00	314.22
Зүүн бүс	1302	222,451.00	585.30
<b>Он</b>			
2017	4518	3,177,899	142.17
2018	3522	3,238,479	108.75
2019	3890	3,296,866	117.99
2020	3509	3,357,542	104.51
2021	3004	3,409,939	88.10
<b>Хүйс</b>			
Эмэгтэй	8592	1,676,779	512.41
Эрэгтэй	9851	1,619,366	608.32

### **Хавдрын төрөл**

Улаан хоолой	1610	3,296,145	48.84
Ходоод	3914		118.74
Шулуун гэдэс	798		24.21
Элэг	7567		229.57
Уушги	2147		65.14
Хөх	1210	1,676,779	72.162
Умайн хүзүү	1197	1,676,779	71.387

100.000 хүн амд ноогдох өвчлөлөөр тооцож үзэхэд 61-ээс дээш насныхан бусад насны бүлгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр 4224, харин 30-аас доош насныханд 8.32 буюу хамгийн бага өвчлөл бүртгэгдсэн байна.

Хорт хавдрын өвчлөлийг 100.000 хүн амд ноогдох дүнгээр, бүсээр харьцуулж харвал Төв-Говийн бүс нутагт хамгийн их буюу 672.53, УБ хотод 616.38, Зүүн бүсэд 585.3, Баруун бүсэд 549.04 байгаа бол Хангайн бүсэд 314.22 байгаа нь хамгийн бага тохиолдол байна.

Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн өвчлөл 100.000 хүн амд 608.32, эмэгтэйчүүдэд 512.41 байна. 2017 онд хорт хавдрын хамгийн их өвчлөл (100.000 хүн амд 142,17), 2021 онд хамгийн бага өвчлөл (100.000-д 88.10) бүртгэгджээ.

100.000 хүн амд ноогдох өвчлөлөөр тооцоход манай улсад элэгний хорт хавдрын өвчлөл хамгийн олон тохиолдол буюу 229.57, ходоодны хорт хавдар 118.74, хөхний хавдар 72.162 гуравдугаар байранд орж байна. Харин шулуун гэдэсний хорт хавдар хамгийн бага буюу 100.000 хүн амд 24.12 тохиолдол бүртгэгдсэн байна.

### **ДҮГНЭЛТ**

Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд 2017-2021 онд шинээр бүртгэгдсэн хавдрын 41% -ийг элэгний, 21.2%-ийг ходоодны, 11.7%-ийг уушигны, 8.7%-ийг улаан хоолойн хорт хавдар, үлдсэн 6.8%, 6.3%, 4.3%-ийг хөх, умайн хүзүү, шулуун гэдэсний хорт хавдар тус тус эзлэж байна.

Дээрх хорт хавдраар өвчлөгсдийн 86.9% нь 46-85 насныхан, 53.4% нь эрэгтэйчүүд мөн 51.7% нь УБ хотод амьдарч байсан бол шинээр бүртгэгдсэн хавдрын 82.2% үсэрхийлсэн шатандаа оношлогдсон байна.

Хорт хавдрын тохиолдлыг 100.000 хүн амд ноогдох дүнгээр авч үзвэл Төв-Говийн бүс (672.53), Улаанбаатар хотод (616.38) хамгийн олон тохиолдол бүртгэгдсэн байна. Зүүн бүсэд хорт хавдрын шинэ тохиолдол хамгийн бага буюу

1302 бүртгэгдсэн боловч 100.000 хүн амд ногдох өвчлөлөөр тооцвол Хангай бүсэд хамгийн бага 314.22 байна.

Оршин суугаа байрлалаар авч үзвэл 51.6% нь хотод, 48.4% нь хөдөөд байна. УБ хот, Төв-Говь, хангай, зүүн бүс нутагт элэг, ходоод, уушигны хорт хавдар тэргүүлжээ. Баруун бүсэд элэг, ходоод, улаан хоолойн хорт хавдрын өвчлөл тэргүүлж байна.

2017 онд хорт хавдрын хамгийн их өвчлөл 100,000 хүн амд 142.17 бүртгэгдэж, сүүлийн хоёр жилд буурсан бол 2021 онд хамгийн бага тохиолдол (100,000-д 88.2) бүртгэгджээ.

## **САНАЛ ЗӨВЛӨМЖ**

Элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл их байгаа нь хүнсний зохисгүй хэрэглээ, хорт зуршил, бактери вирусын архаг халдваруудтай холбоотой. Тиймээс эрүүл хүнсийг дэмжих, чихэрлэг бүтээгдэхүүн, давс, махны хэрэглээг багасгах, хүнсний ногоог түлхүү хэрэглэх, хэт халуун хоол цай, архи, тамхины хэрэглээг багасгах шаардлагатай байна.

Архи тамхины хэрэглээг буруулах, вакцинжуулалт (элэг, умайн хүзүүний хорт хавдрын эсрэг), эрт илрүүлэх, хөдөлгөөн, эрүүл хооллолт зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр хорт хавдраас урьдчилан сэргийлэх боломжтой.

Манай улсад хавдар хожуу үе шатанд оношлогдож байгаатай холбоотой хавдрын шалтгаант нас баралт өндөр байгаад анхаарал хандуулж, хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх бодлогыг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Судалгааны дүнгээс харахад элэг, ходоодны хорт хавдрын эрт илрүүлгийг 45-аас дээш насныханыг зорилтот бүлэг болгон сонгож, тогтмол зохион байгуулах нь ач холбогдолтой байх боломжтой юм.

Цаашид манай улсад элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралт дэлхийн бусад орнуудаас өндөр тархалттай байгаагийн шалтгаан, онцлог, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан тодруулах хэрэгтэй байна.



Энхтайвны гудамж-136  
Улаанбаатар-210648  
Ш/Х-187  
Монгол улс